






Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо

**МОНГОЛЫН ХҮҮХДИЙН  
ХӨДӨЛМӨРИЙН  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН  
2006–2007**



Улаанбаатар хот  
2008 он

**-АГУУЛГА-**

**ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ  
ӨМНӨХ ҮГ  
ТАЛАРХАЛ**

**Товчилсон үгийн жагсаалт  
Монгол Улсын газрын зураг, бүс нутгаар  
Бүлэг 1. Ерөнхий тойм**

**Бүлэг 2. Удиртгал**

- 2.1 Танилцуулга
- 2.2 Судалгааны зорилт
- 2.3 Судалгааны хугацаа
- 2.4 Тайлангийн агуулга, бүтэц

**Бүлэг 3. Судалгааны арга зүй, зохион байгуулалт, ойлголт тодорхойлолтууд**

- 3.1 Судалгааны хамрах хүрээ
- 3.2 Судалгааны түүвэрлэлт
- 3.3 Судалгааны асуулгын хуудас, ахлагч тоологч нарын сургалт, мэдээлэл цуглуулалт
- 3.4 Мэдээлэл боловсруулалт
- 3.5 Ойлголт, тодорхойлолт

**Бүлэг 4. Хүн ам зүйн болон өрхийн үзүүлэлтүүд**

- 4.1 Нийтлэг зүйл
- 4.2 Хүн ам зүйн үзүүлэлтүүд
- 4.3 Хүн амын тоо, байршил, бүс нутгаар
- 4.4 Хүн амын нас, хүйсийн бүтэц
- 4.5 Хүн ам зүйн ачаалал
- 4.6 Гэрлэлтийн байдал
- 4.7 Өрхийн бүтэц
- 4.8 Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх
- 4.9 Боловсролын түвшин
- 4.10 Сургуульд хамрагдалт
- 4.11 Бичиг үсгийн мэдлэгийн түвшин

**Бүлэг 5. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн өрхийн нийгэм, эдийн засгийн байдал**

- 5.1 5-17 насны хүүхдийн тоо, тэдний өрх, гэр бүлийн бүтэц
- 5.2 5-17 насны хүүхдийн сургуульд хамрагдалт, сургуульд хамрагдаагүй шалтгаан
- 5.3 5-17 насны хүүхдийн эдийн засгийн идэвхийн байдал
- 5.4 Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, байршил, бүсээр
- 5.5 Хөдөлмөр эрхэлж буй хүүхэд тэдний өрх, гэр бүлийн бүтэц
- 5.6 Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн гэр бүлийн нийгэм, эдийн засгийн байдал
- 5.7 Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн боловсролын түвшин
- 5.8 Хүүхдүүдийн чөлөөт цаг

**Бүлэг 6. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн төлөв байдал**

- 6.1 Удиртгал
- 6.2 Хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагаа

- 6.3 Ажил эрхэлж буй хүүхдүүдийн тоо, тухайн үеийн идэвхиэр
- 6.4 Сургууль боловсролоос гадуурх үйл ажиллагаанд зарцуулсан цаг
- 6.5 Ажил эрхэлж буй хүүхдүүдийн тоо
  - 6.5.1 Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар
  - 6.5.2 Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, ажил эрхлэлтийн байдал
  - 6.5.3 Ажил эрхэлж буй хүүхдүүд, ажил мэргэжлийн ангиллаар
  - 6.5.4 Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдүүдийн сарын орлого
- 6.6 Эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд

### **Бүлэг 7. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэх болсон шалтгаан, үр дагавар**

- 7.1 Удиртгал
- 7.2 Хүүхдийн хөдөлмөрийн тооцоо
- 7.3 Сургуулиас гадуурх үйл ажиллагаа
- 7.4 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж эхэлсэн нас
- 7.5 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгаан
  - 7.5.1 Өрхийн аж ахуйд туслах болсон шалтгаан
  - 7.5.2 Өрхөөс гадуур ажиллах болсон шалтгаан
- 7.6 Ажил эрхлэхгүй бол үзүүлэх нөлөө
- 7.7 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлснээс болж өвдөж, гэмтсэн хүүхдүүд

### **Бүлэг 8. Хүнд хортой болон аюултай хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд**

- 8.1 Нийтлэг зүйл
- 8.2 Аюултай ажил хөдөлмөр эрхэлж буй 5-17 насны хүүхдийн тоо

### **Бүлэг 9. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн улирлын хэлбэлзэл**

- 9.1 Нийтлэг зүйл
- 9.2 Ажил эрхэлж буй 5-17 насны хүүхдийн тоо
- 9.3 Ажил эрхэлж буй хүүхдүүдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар
- 9.4 Ажил эрхэлж буй хүүхдүүдийн ажил эрхлэлтийн байдал
- 9.5 Ажил эрхэлж буй хүүхдүүд, ажил мэргэжлийн ангиллаар
- 9.6 Чөлөөт цаг

### **Бүлэг 10. Хүүхдийн хөдөлмөрийн 2002/03 ба 2006/07 оны судалгаануудын үндсэн үр дүн**

- 10.1 Нийтлэг зүйл
- 10.2 Ажил эрхэлж буй 5-17 насны хүүхдийн тоо
- 10.3 Хүүхдийн хөдөлмөр

### **Бүлэг 11.Түүврийн алдаа Хавсралт хүснэгтүүд Асуулгын хуудас**

**ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

- Хүснэгт 1. Ажиллах хүчний түүвэр судалгааны бүлэг тус бүрт сонгогдсон ТАШН, өрхүүдийн тоо
- Хүснэгт 2. Өрх, хүн амын тоо, хот хөдөө, бүсээр
- Хүснэгт 3. 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур байгаа гишүүдтэй өрхийн тоо, хот, хөдөө, бүсээр
- Хүснэгт 4. Өрх, хүн амын тоо, хот, хөдөө, бүсээр
- Хүснэгт 5. Хүн ам зүйн ачааллын харьцаа, хот, хөдөө, бүсээр
- Хүснэгт 6. Өрхийн дүнд эзлэх хувь, ам бүлийн тоо, хот, хөдөө, бүсээр
- Хүснэгт 7. Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь, ам бүлийн тоогоор
- Хүснэгт 8. 15, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хот, хөдөө, хүйс, дүнд эзлэх хувиар
- Хүснэгт 9. 7-19 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин, хот, хөдөө, хүйсээр
- Хүснэгт 10. 5-17 насны хүүхдийн тоо, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр
- Хүснэгт 10а. 5-17 насны хүүхдийн нас, хүйсийн бүтэц, хот, хөдөөгөөр
- Хүснэгт 11. 2007 оны хүн амын жилийн эцсийн мэдээгээр гарсан хүүхдийн тоо болон судалгаагаар тооцсон хүүхдийн тоо, насны бүлгээр
- Хүснэгт 12. 5-17 насны өрхөөс гадуур амьдарч буй хүүхдийн тоо, хот, хөдөөгөөр
- Хүснэгт 13. 5-17 насны хүүхэд, өрхийн тэргүүлэгч, өрхийн ам бүлийн тоогоор, хувиар
- Хүснэгт 14. 5-17 насны хүүхэд, хот, хөдөөгөөр, бүсээр
- Хүснэгт 15. 5-17 насны хүүхдийн тоо, сургуульд суралцаж буй байдлаар, хот, хөдөөгөөр
- Хүснэгт 15а. 5-17 насны хүүхдийн бүтэц, сургуульд суралцаж буй байдлаар, хөдөөгөөр, бүсээр
- Хүснэгт 16. Сургууль, курст хамрагдаагүй 5-17 насны хүүхдийн тоо, шалтгаан, насны бүлэг, хүйсээр
- Хүснэгт 17. Сүүлийн 7 хоногт сургуульд сурсан болон сураагүй хүүхдийн тоо, эдийн засгийн идэвхийн байдал, хүйс, насны бүлгээр
- Хүснэгт 17а. Сүүлийн 7 хоногт сургуульд сурсан болон сураагүй хүүхэд, дүнд эзлэх хувиар
- Хүснэгт 18. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр
- Хүснэгт 19. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, бүсээр
- Хүснэгт 19а. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, насны бүлэг, хүйс, бүсээр
- Хүснэгт 19б. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, насны бүлэг, хүйс, бүсээр
- Хүснэгт 20. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, өрхийн тэргүүлэгчийн хүйс, хот, хөдөөгөөр
- Хүснэгт 20а. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, насны бүлэг, өрхийн тэргүүлэгчийн хүйс, хот, хөдөөгөөр
- Хүснэгт 21. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, амьдарч байгаа сууцны өмчлөлийн хэлбэрээр
- Хүснэгт 22. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, насны бүлэг, хүйс, сургуульд суралцсан байдлаар
- Хүснэгт 23. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, насны бүлэг, хүйс, боловсролын түвшингээр
- Хүснэгт 23а. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, насны бүлэг, хүйс, боловсролын түвшингээр
- Хүснэгт 24. Өдөрт чөлөөт цаг гардаг хүүхдийн дүнд эзлэх хувь
- Хүснэгт 25. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлгээр, хүйсээр

- Хүснэгт 26. Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, 7 хоногт ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйсээр
- Хүснэгт 27. Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, 7 хоногт ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, байршлаар
- Хүснэгт 28. Хүүхдүүдийн гэрийн ажил хийхэд долоо хоногт зарцуулсан цаг, насны бүлэг, хүйсээр
- Хүснэгт 29. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
- Хүснэгт 29а. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн дүнд эзлэх хувь, насны бүлэг, хүйс, бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
- Хүснэгт 29б. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн дүнд эзлэх хувь, насны бүлэг, хүйс, бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
- Хүснэгт 30. 5-17 насны ажил эрхэлсэн хүүхэд, насны бүлэг, хүйс, ажил мэргэжлийн ангиллаар, дүнд эзлэх хувиар
- Хүснэгт 31. 5-17 насны хүүхдүүдийн үндсэн ажлаараа ажилласан хугацаа, насны бүлэг, хүйсээр
- Хүснэгт 31а. 5-17 насны хүүхдүүдийн үндсэн ажлаараа ажилласан хугацаа, насны бүлэг, хүйсээр, хувиар
- Хүснэгт 32. Тухайн үед цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдүүдийн сарын орлого, төгрөгөөр
- Хүснэгт 33. Гэрийн ажил хийхэд оролцсон хүүхдүүдийн тоо, насны бүлэг, хүйс, хийсэн ажлын төрлөөр
- Хүснэгт 33а. Гэрийн ажил хийхэд оролцсон хүүхэд, насны бүлэг, хүйс, хийсэн ажлын төрлөөр
- Хүснэгт 34. Гэрийн ажил хийсэн болон ус авсан, түлээ түлш бэлтгэсэн хүүхдүүдийн тоо, насны бүлэг, хүйс, 7 хоногт зарцуулсан цагаар
- Хүснэгт 35. Эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан цагт үндэслэн тооцсон хүүхдийн хөдөлмөр, насны бүлэг, хүйсээр
- Хүснэгт 36. Сүүлийн 7 хоногт хийсэн үйл ажиллагаа, насны бүлэг, хүйсээр
- Хүснэгт 37. Сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн сүүлийн 7 хоногт хийсэн үйл ажиллагаа, насны бүлэг, хүйсээр
- Хүснэгт 38. Өрхийн аж ахуйд тусалж буй хүүхдүүд, тусалж эхэлсэн насны бүлэг, сургуульд хамрагдалт, хот хөдөө, хүйсээр
- Хүснэгт 39. Өрхөөс гадуур ажилаж байгаа хүүхдүүд, ажил хийж эхэлсэн насны бүлэг, хот хөдөөгөөр
- Хүснэгт 39а. Өрхөөс гадуур ажилаж байгаа хүүхдүүд, ажил хийж эхэлсэн насны бүлэг, хот хөдөөгөөр, хувиар
- Хүснэгт 40. Өрхийн аж ахуйд тусалж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгаан, насны бүлэг, хот хөдөөгөөр
- Хүснэгт 41. Өрхөөс гадуур ажиллаж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгаан, насны бүлэг, хот хөдөөгөөр
- Хүснэгт 42. Ажлаасаа болж өвдөж, гэмтсэн хүүхдийн тоо, өвчний төрөл, өвчлөл, гэмтлийн зэрэглэл, хүйс, хот, хөдөө, насны бүлгээр
- Хүснэгт 43. Аюултай ажил хийж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйсээр
- Хүснэгт 44. Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, улирлын тооцоогоор
- Хүснэгт 45. Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн насны бүтэц, хүйсээр, улирлаар, хувиар
- Хүснэгт 46. 5-17 насны ажил эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, хувиар, улирлаар

- Хүснэгт 47. Ажил эрхэлсэн хүүхдүүдийн ажил эрхлэлтийн байдлын бүтэц, хувиар, улирлаар
- Хүснэгт 48. Хүүхэд өдөрт чөлөөт цагт зарцуулж буй дундаж цагийн тооцоо, улирлаар
- Хүснэгт 49. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн идэвхитэй болон идэвхигүй байсан хүүхдийн тоо, насны бүлгээр, хувиар
- Хүснэгт 50. Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, хүүхдийн хөдөлмөрийн судалгааны дүнгээр
- Хүснэгт 51. 5-17 насны ажил эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, судалгааны дүнгээр
- Хүснэгт 52. Ажил эрхэлсэн хүүхдүүдийн ажил эрхлэлтийн байдлын бүтэц, хувиар, судалгааны дүнгээр
- Хүснэгт 53. Ажил эрхэлсэн хүүхдүүдийн тоо, ажил мэргэжлийн ангиллаар, судалгааны дүнгээр
- Хүснэгт 54. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан цагт үндэслэн тооцсон хүүхдийн хөдөлмөр, судалгааны дүнгээр
- Хүснэгт 55. Нийт хүн ам
- Хүснэгт 56. Ажиллах хүч
- Хүснэгт 57. Ажиллагчид
- Хүснэгт 58. Ажилгүйчүүд
- Хүснэгт 59. Хөдөлмөр эрхэлдэг хүүхэд

## ЗУРАГ

- Зураг 1. Хүн амын насны бүтэц, 2000 оны ХАОСТ, АХС-ны дүнгүүдээр
- Зураг 2. 5-17 насны хүүхдийн тоо, 2007 оны хүн амын жилийн эцсийн мэдээ болон Хүүхдийн хөдөлмөрийн судалгааны дүнгээр
- Зураг 3. Өрхийн тэргүүлэгчийн бүтэц, хүйсээр, хот, хөдөөгөөр
- Зураг 4. 5-17 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдаагүй шалтгаан, хувиар
- Зураг 5. Сургуульд огт суралцаж байгаагүй хүүхэд, насны бүлгээр
- Зураг 6. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйсээр
- Зураг 7. Ажил эрхэлсэн хүүхэд, бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, хувиар
- Зураг 8. Ажил эрхэлсэн хүүхэд, ажил эрхлэлтийн байдлаар, хувиар
- Зураг 9. Ажил эрхэлсэн хүүхэд, ажил мэргэжлийн ангиллаар, хувиар
- Зураг 10. Өрхийн аж ахуйдаа тусалж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгааны бүтэц хувиар
- Зураг 11. Өрхийн аж ахуйдаа тусалж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгааны бүтэц хувиар
- Зураг 12. Ажил эрхлэхгүй бол өөрт нь болон өрхөд үзүүлэх нөлөө, хувиар
- Зураг 13. Ажил эрхлэхгүй бол өөрт нь болон өрхөд үзүүлэх нөлөө, Улаанбаатар, хот, хөдөө, хувиар
- Зураг 14. Өвчлөл, гэмтэлтэй холбогдолтой зардлын төлбөрийн төрөл, хувиар
- Зураг 15. Аюултай ажил эрхэлж буй хүүхдийн насны бүтэц, хувиар
- Зураг 16. Аюултай ажил эрхэлж буй хүүхдийн тоо, хүйс, насны бүлгээр
- Зураг 17. Сүүлийн 7 хоногт 43 ба түүнээс дээш цагаар ажилласан хүүхдийн хүйсийн бүтэц, насны бүлгээр
- Зураг 18. Ажил эрхэлсэн хүүхдийн ажил мэргэжлийн ангиллын бүтэц, улирлаар, хувиар
- Зураг 19. Хүүхэд өдөрт чөлөөт цагт зарцуулж буй дундаж цаг, улирлаар, хувиар

Зураг 20. 5-17 насны хүүхдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхи, нийт дүнд эзлэх хувь, судалгааны дүнгээр

Зураг 21. 5-17 насны хүүхдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхи, хүйсээр, дүнд эзлэх хувь, судалгааны дүнгээр

Зураг 22. Ажил эрхэлж буй 5-17 насны эмэгтэй, эрэгтэй хүүхдүүдийн дүнд эзлэх хувь, насны бүлгээр, судалгааны дүнгээр

Зураг 23. Ажил эрхэлж буй 5-17 насны хүүхдүүдийн ажил мэргэжлийн ангиллын бүтэц, судалгааны дүнгээр, хувиар

### **ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

*Хүснэгт 1.* Хүн амын нас, хүйсийн бүтэц, хүйсийн харьцаа

*Хүснэгт 2.* Хүн амын гэрлэлтийн байдал, хот, хөдөө, бүсээр

*Хүснэгт 3.* Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин, хот, хөдөө, бүсээр

*Хүснэгт 4.* Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин, насны бүлэг, хот, хөдөөгөөр

*Хүснэгт 5.* 5-17 насны хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, хот, хөдөө, бүс, аймаг, нийслэлээр, дүнд эзлэх хувиар

*Хүснэгт 6.* 5-17 насны хүүхдийн тоо, байршлаар, бүсээр, өрхийн тэргүүлэгчээр, өрхийн ам бүлийн тоогоор

*Хүснэгт 7.* Сүүлийн 7 хоногт сургуульд суралцсан, эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхдийн тоо, насны бүлэг, хот, хөдөө, хүйс, бүсээр, хувиар

*Хүснэгт 8.* Сүүлийн 7 хоногт сургуульд суралцсан, эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхдийн тоо, аймаг, нийслэлээр, хувиар

*Хүснэгт 9.* 5-17 насны хүүхдийн насны бүтэц, сургуульд суралцаж буй байдал, хот, хөдөөгөөр, бүсээр

*Хүснэгт 10.* 5-17 насны хүүхдийн сургууль, курст хамрагдаагүй шалтгааны бүтэц, насны бүлэг, хүйсээр

*Хүснэгт 11.* Сүүлийн 7 хоногт эдийн засгийн идэвхтэй болон эдийн засгийн идэвхгүй байсан хүүхдийн тоо, насны бүлгээр, хүйсээр, сургуульд суралцсан байдлаар

*Хүснэгт 12.* Сүүлийн 7 хоногт эдийн засгийн идэвхтэй болон эдийн засгийн идэвхгүй байсан хүүхэд, эдийн засгийн идэвхийн бүтэц, сургуульд суралцсан эсэх

*Хүснэгт 13.* Сүүлийн 7 хоногт эдийн засгийн идэвхтэй болон эдийн засгийн идэвхгүй байсан хүүхэд, насны бүлгээр, хувиар

*Хүснэгт 14.* 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, насны бүлгээр, хот, хөдөөгөөр, хүйсээр

*Хүснэгт 15.* 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, насны бүлгээр, хот, хөдөөгөөр, хүйсээр

*Хүснэгт 16.* Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдлаар

*Хүснэгт 17.* 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, амьдарч байгаа сууцны өмчлөлийн хэлбэр, хот, хөдөөг, бүсээр

*Хүснэгт 18.* 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, сургуульд суралцсан байдлаар

*Хүснэгт 19.* 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, боловсролын түвшингээр

*Хүснэгт 20.* Өдөрт чөлөөт цаг гардаг хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, дундаж цагаар

- Хүснэгт 21.* Хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд зарцуулсан цаг, насны бүлэг, хүйс, хот, хөдөө, бүс, аймаг, нийслэлээр
- Хүснэгт 22.* Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, насны бүлэг, хүйс, ажил эрхлэлтийн байдлаар, хувиар
- Хүснэгт 23.* Тухайн үед цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдүүдийн сарын орлого, хувиар
- Хүснэгт 24.* 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн дүнд эзлэх хувь, ажил эрхлэлтийн байдал, хот, хөдөө, бүх төрлийн эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
- Хүснэгт 25.* 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн дүнд эзлэх хувь, хүйс, бүс, аймаг, нийслэлээр, бүх төрлийн эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
- Хүснэгт 26.* Хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгаан, насны бүлэг, хот, хөдөө, хүйс, бүсээр (хувиар)
- Хүснэгт 27.* Хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгаан, аймаг, нийслэлээр (хувиар)
- Хүснэгт 28.* Өрхийн аж ахуйд тусалж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгаан, насны бүлэг, хот хөдөөгөөр
- Хүснэгт 29.* Өрхөөс гадуур ажил хийж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгаан, насны бүлэг, хот, хөдөө, хүйс, бүсээр (хувиар)
- Хүснэгт 30.* Өрхөөс гадуур ажил хийж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгаан, аймаг, нийслэлээр (хувиар)
- Хүснэгт 31.* Ажлаасаа болж өвдөж, гэмтсэн хүүхэд, насны бүлэг, хот, хөдөө, хүйс, бүс, аймаг, нийслэл, хамгийн сүүлд авсан өвчлөл, гэмтлийн төрөл болон түүнтэй холбогдон гарсан зардлыг гаргагчийн төрлөөр, хувиар
- Хүснэгт 32.* Ажлаасаа болж өвдөж, гэмтсэн хүүхэд, насны бүлэг, хот, хөдөө, хүйс, бүс, аймаг, нийслэл, хамгийн сүүлд авсан өвчлөл, гэмтлийн зэрэглэлээр, хувиар
- Хүснэгт 33.* Хүүхдийн ажлын байрны байршлын бүтэц, насны бүлэг, хот, хөдөө, хүйс, бүсээр
- Хүснэгт 34.* Хүүхдийн ажлын байрны байршлын бүтэц, насны бүлэг, аймаг, нийслэлээр
- Хүснэгт 35.* Хүүхдийн ажлын байрны нөхцлийн талаарх үнэлгээ, насны бүлэг, хүйс, байршил, бүс нутаг, аймаг, нийслэлээр
- Хүснэгт 36.* Өрхөөс гадуур ажил хийж буй хүүхдийн орлогын зарцуулалт, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр, хувиар
- Хүснэгт 37.* Өрхөөс гадуур ажил хийж буй хүүхэд ажил эрхлэхээ боливол өөрт нь болон өрхөд үзүүлэх нөлөө, насны бүлэг, хот, хөдөөгөөр, хувиар
- Хүснэгт 38.* 5-17 насны хүүхдийн тоо, ажил эрхлэлтийн төрлөөр, улирлаар
- Хүснэгт 39.* Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, дүнд эзлэх хувь, улирлаар
- Хүснэгт 40.* 5-17 насны ажил эрхэлсэн хүүхдийн тоо, бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, хувиар, улирлаар
- Хүснэгт 41.* Өдөрт чөлөөт цаг гаргаж буй хүүхдүүдийн насны бүтэц, насны бүлэг, хүйсээр, улирлаар, хувиар
- Хүснэгт 42.* Өдөрт чөлөөт цаг гаргаж буй хүүхдүүдийн тоо, насны бүлэг, хүйсээр, улирлаар, хувиар
- Хүснэгт 43.* Сүүлийн 7 хоногт эдийн засгийн идэвхитэй болон идэвхигүй байсан хүүхдийн тоо\*, насны бүлгээр
- Хүснэгт 44.* 5-17 насны хүүхдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхи, дүнд эзлэх хувиар, судалгааны дүнгээр



Хүснэгт 45. 5-17 насны хүүхдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхи, дүнд эзлэх хувиар, судалгааны дүнгээр

Хүснэгт 46. 5-17 насны хүүхдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхи, дүнд эзлэх хувиар, судалгааны дүнгээр

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсад сүүлийн жилүүдэд хийгдсэн нийгэм эдийн засгийн шинэчлэл, өөрчлөлтүүд нь нийгмийн эмзэг хэсгийн орлого, хөдөлмөр эрхлэлтэд хүндээр нөлөөлж, ядуурал ажилгүйдэл өсөн нэмэгдэж хөдөлмөрийн зах зээл дээр хүүхдийн хөдөлмөр эрхлэх үзэгдэл нэмэгдэх боллоо. Монгол Улс НҮБ-аас батлан гаргасан Хүүхдийн Эрхийн Конвенцэд 1990 онд, ОУХБ-аас батлагдсан Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182 дугаар Конвенцэд 2000 онд, Ажил эрхлэх доод насны хязгаарын тухай 138 дугаар Конвенцэд 2002 онд тус тус нэгдэн орсны хувьд хүүхдийн хөдөлмөрийг бүрэн устгах болон хүүхдийг хүнд хортой, нөхцлийн ажил, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэлтэд татан оруулахыг таслан зогсооход чиглэсэн үндэсний бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд ихээхэн анхаарал тавьж ирсэн билээ. Хүүхдийн хөдөлмөрийн цар хүрээ, тархалт, төлөв байдлын талаарх үнэн зөв, бодит мэдээллийн эрэлт хэрэгцээ байнга нэмэгдэх болов.

Үндэсний статистикийн хороо нь Монгол Улсын хэмжээнд анх удаа “Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа(ХХС)”-г “Ажиллах хүчний судалгаа(АХС)”-тай хамтруулан 2002-2003 онд олон улсын жишиг аргачлалын дагуу улирлаар явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний судалгаа болсон юм. Энэхүү судалгааг явуулснаар хүүхдийн хөдөлмөрийн талаар ОУХБ-аас гаргасан нийтлэг тодорхойлолт, арга зүйг ашиглан хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар анх удаа өргөн хэмжээний мэдээлэл цуглуулж, хүүхдийн эдийн засгийн идэвхи, хүүхдийн ажил, хөдөлмөрийн цар хүрээ, төлөв байдлын талаарх мэдээллийн сангийн эхлэл тавигдсан билээ. ХХС-г АХС-ны хавсарга судалгаа болгон өмнө нь явуулсан туршлагад үндэслэн хүүхэд хамгааллын талаар цаашдын стратеги, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд шаардлагатай статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулах, хөдөлмөрийн статистикийн үзүүлэлтийн системд хүүхдийн хөдөлмөрийн үзүүлэлтүүдийг оруулж ирэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ шаардлагын үүднээс ОУХБ-ын Хүүхдийн Хөдөлмөрийг Устгах Олон Улсын Хөтөлбөр(ХХУОУХ)-ийн газраас тавьсан саналын дагуу хоёр дахь удаагийн ХХС-г АХС-тай хамтруулан ОУХБ-ын санхүү, техникийн дэмжлэгтэйгээр 2006 оны 7 дугаар сард эхэлж нэг жилийн турш явуулав.

Энэ удаагийн судалгаа нь өмнөх судалгаатай харьцуулахад түүврийн загварыг шинэчлэн боловсруулж, үндсэн үзүүлэлтүүдийг аймаг, нийслэлийн түвшинд гаргах бололцоотой болсноороо чухал ач холбогдолтой юм.

Энэхүү судалгааны үр дүн нь хөдөлмөр эрхлэх эрсдэлтэй болон хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг бодитойгоор тодорхойлон улмаар ажил хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн эрхийг хамгаалах, хүүхдийн хөдөлмөрийг бүрэн устгахад чиглэсэн үндэсний хэмжээний бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд ашиглагдах суурь мэдээлэл болохын зэрэгцээ судлаач, эрдэмтдийн зүгээс тодорхой чиглэлээр тусгайлсан, гүнзгийрүүлсэн шинжилгээ судалгааны ажил явуулахад мэдээллийн үндсэн эх үүсвэр болж чадна гэдэгт итгэлтэй байгаа болно.

П.БЯМБАЦЭРЭН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

## ТАЛАРХАЛ

“Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа(ХХС)”-г Үндэсний статистикийн хорооноос хоёр дахь удаагаа “Ажиллах хүчний судалгаа (АХС)-тай хамтруулан амжилттай зохион байгуулан явууллаа.

Энэ удаагийн судалгааны зорилго нь хүүхдийн хөдөлмөрийн төлөв байдал, хамрах хүрээ, хөдөлмөр эрхлэх болсон шалтгаан, хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн ажлын нөхцөл, хөдөлмөр эрхэлснээр хүүхдийн эрүүл мэнд, боловсролд хэрхэн нөлөөлж буй талаарх мэдээлэл цуглуулж 2002-2003 оны судалгааны мэдээллийн санг баяжуулахад чиглэгдсэн болно. Энэхүү мэдээллийг цуглуулснаар хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг тодорхойлох, ажлын байрны нөхцөл, гарч буй үр дагавар зэргийг тооцох замаар хүүхдийн хөдөлмөрийн талаар иж бүрэн дүн шинжилгээ хийж олон нийтэд таниулах, түгээх, ОУХБ-ын хүүхдийн хөдөлмөрийн мэдээллийн санг баяжуулах, бүс нутгийн болон дэлхийн түвшинд боловсруулан гаргадаг энэ талын тайланд Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн холбогдолтой мэдээллийг тусгадаг болох чухал ач холбогдолтой юм.

Хүүхдийн хөдөлмөрийн хавсарга судалгааг манай оронд хоёр дахь удаа олон улсын аргачлалаар үндэсний хэмжээнд явуулахад санхүү, техникийн туслалцаа үзүүлсэн ОУХБ-ын Хүүхдийн Хөдөлмөрийг Устгах Олон Улсын Хөтөлбөр (ХХУОУХ)-ийн газарт талархаж байгаагаа илэрхийлэхийн ялдамд судалгааны аргачлал, мэдээлэл боловсруулах, тайлан бичих ажилд мэргэжлийн өндөр түвшний зөвлөгөө өгч ажилласан ОУХБ/ХХУОУХ-ийн газрын Олон Улсын Зөвлөх Бижой Раучадхури, Деби Мондали, төслийн ажлыг хэрэгжүүлэх үйл явцыг зохицуулж байсан ОУХБ/ХХУОУХ-ийн үндэсний хөтөлбөрийн зохицуулагч Н.Монголмаа нарт чин сэтгэлийн гүн талархал илэрхийлье.

Мөн судалгааг олон улсын жишгийн дагуу мэргэжлийн түвшинд амжилттай зохион байгуулан явуулахад мэргэжлийн зөвлөгөө өгч, хамтран ажилласан ҮСХ-ны даргын болон аргачлал, судалгааны байнгын зөвлөлийн гишүүд, судалгааны ажлын хэсгийн гишүүд болон судалгааг орон нутагт зохион байгуулан явуулах, мэдээллийг цуглуулах, боловсруулалтанд бэлтгэх ажилд идэвхитэй оролцож ажилласан орон нутгийн статистикийн албадын ажилтнуудад талархал илэрхийлж сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.


П.БЯМБАЦЭРЭН

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ЗУРАГ, БАЙРШЛААР



- & Аймгийн төв
- Бүсүүд
- Баруун
  - Хангай
  - Зүүн
  - Улаанбаатар
  - Төв



**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

<b>АОЭХ</b>	Ажил олгогч эздийн холбоо
<b>АХОТ</b>	Ажиллах хүчний оролцооны түвшин
<b>АХС</b>	Ажиллах хүчний судалгаа
<b>АЭТ</b>	Ажил эрхлэлтийн түвшин
<b>БСШУЯ</b>	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
<b>МБНС</b>	Мэдээлэл боловсруулах нэгдсэн систем
<b>МХХС</b>	Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа
<b>МҮЭХ</b>	Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо
<b>НХХЯ</b>	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
<b>ОУХБ</b>	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
<b>ТАШН</b>	Тооллогын анхан шатны нэгж
<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага
<b>ТХШН</b>	Түүврийн хоёр дахь шатны нэгж
<b>УИХ</b>	Улсын их хурал
<b>ҮСХ</b>	Үндэсний статистикийн хороо
<b>ҮТС</b>	Үндэсний тооцооны систем
<b>ХАНСГ</b>	Хүн ам, нийгмийн статистикийн газар
<b>ХАОСТ</b>	Хүн ам, орон сууцны тооллого
<b>ХХУОУХ</b>	Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр
<b>ХХҮГ</b>	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

**Судалгааны хугацаа**

<b>Судалгааны 1 дүгээр улирал</b>	<b>2006 оны 7, 8, 9 сар</b>
<b>Судалгааны 2 дугаар улирал</b>	<b>2006 оны 10, 11, 12 сар</b>
<b>Судалгааны 3 дугаар улирал</b>	<b>2007 оны 1, 2, 3 сар</b>
<b>Судалгааны 4 дүгээр улирал</b>	<b>2007 оны 4, 5, 6 сар</b>

## **БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ТОЙМ**

Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа (МХХС) нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага(ОУХБ)-ас гаргасан нийтлэг тодорхойлолт, арга зүйг ашиглан хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар өргөн хэмжээний мэдээлэл цуглуулж явуулсан үндэсний хэмжээний томоохон судалгаа юм. Энэхүү түүвэр судалгаанд Монгол Улсын бүх аймаг, Улаанбаатар хотын 5-17 насны хүүхдүүд хамрагдсан.

### **5-17 насны хүүхдийн тоо**

Судалгааны тархаалтын тооцоогоор нийт 621612 хүүхэд судалгаанд хамрагдсаны 56.4 хувь нь хот, суурин газарт, 43.6 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна. Насны бүлгээр авч үзвэл 33.6 хувийг 5-9 насны, 38.2 хувийг 10-14 насны, 28.2 хувийг 15-17 насны хүүхдүүд тус тус эзэлж байна. Нийт хүүхдийн 52.4 хувь нь хөвгүүд, 47.6 хувь нь охид байна.

### **Хүүхдийн боловсролын түвшин**

Судалгаагаар 5-17 насны нийт хүүхдийн 15.3 хувь нь судалгааны хугацаа буюу 2006-2007 оны хооронд сургуульд сураагүй байгаагийн дийлэнх нь буюу 72.9 хувь нь 5-9 насны хүүхдүүд байгаа нь сургуульд орох насны доод хязгаар 6-7 нас байгаатай холбон үзэх хэрэгтэй. Сургуульд огт сураагүй байгаа хүүхдийн дотор 10-14 насны хүүхдүүд 7.7 хувь, 15-17 насны хүүхдүүд 19.4 хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна.

Хүүхдүүдийн боловсролын түвшинг хүйсээр авч үзэхэд нэг их ялгаа гарахгүй байна. Хүүхдүүдийн сургуульд хамрагдалтыг хот, хөдөөгөөр авч үзэхэд ямар нэгэн сургууль, курст сураагүй байгаа хүүхдүүд хот, суурин газрын хувьд нийт хүүхдийн 9.9 хувийг эзэлж байхад хөдөө, орон нутгийн хувьд 22.2 хувьтай байна. Мөн насны бүлгээр авч үзэхэд хотод 10-17 насныхан 15.8 хувь, хөдөөд 33.6 хувьтай байна. Эндээс дүгнэхэд хөдөөний хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын түвшин муу, анхаарал татсан асуудлын нэг хэвээр байна.

### **Хүүхдийн сургуульд хамрагдалт, эдийн засгийн идэвхи**

5-17 насны хүүхдийн эдийн засгийн идэвхийг тухайн үеийн (сүүлийн 7 хоногт) болон байнгын (сүүлийн 12 сард) идэвхийн байдлаар тооцож болох бөгөөд ойлгоход амар байх үүднээс тайланд ангиллыг зөвхөн тухайн үеийн эдийн засгийн

идэвхээр тооцсон. Ингээд нийт хүүхдийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн (түүнчлэн гэрийн ажил хийхэд оролцсон хүүхэд ч байж болно), зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон (эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн), зөвхөн сургуульд суралцсан, юунд ч оролцоогүй буюу эдийн засгийн идэвхгүй (өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг хүүхдүүдийг оруулан), сургуульд суралцсан, сургуульд суралцаагүй гэсэн бүлгүүдэд хуваасан.

5-17 насны нийт хүүхдийг сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн, зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон, зөвхөн сургуульд сурдаг, эдийн засгийн үйл ажиллагаа болон эдийн засгийн бус үйл ажиллагаа (гэрийн ажил)-нд оролцоогүй, мөн сургуульд сураагүй байдлаар ангилан насны бүлэг, хүйсээр тооцон гаргалаа.

Судалгаанд хамрагдсан 5-17 насны 621612 хүүхдээс сүүлийн 7 хоногийн байдлаар 80.9 хувь буюу 502671 нь сургуульд сурч байна. Насны бүлгээр тооцоход сургуульд суралцаж байгаа хүүхдийн эзлэх хувь 10-14 насанд хамгийн өндөр 95.3 хувьтай байна. 15-17 насны сургуульд сурч буй хүүхдийн өөрөөр хэлбэл 149686 хүүхдийн 50.3 хувь (75309) нь охид, 49.7 хувь (74377) нь хөвгүүд байна.

Нийт хүүхдийн дийлэнх нь гэрийн ажилд тусалдаг байна. 5-17 насны бүх хүүхдийн 64.6 хувь, үүнээс охидын 67.3 хувь, хөвгүүдийн 62.2 хувь нь гэрийн ажилд тусалжээ. Бүх насны бүлэгт гэрийн ажилд тусалж байгаа хөвгүүдийн эзлэх хувь охидынхоос өндөр байна. 5-17 насны нийт хүүхдийн 11.2 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаанд татагдан орсон байна. Энэ тоог хүйсээр задлан харуулбал хөвгүүдийнх өндөр буюу 13.0 хувьтай байхад охидынх 9.3 хувь байна.

Ерөнхийдөө бүх насны бүлэгт эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хөвгүүдийн тоо охидынхоос өндөр байгаа бөгөөд энэ нь 15-17 насныхны хувьд нилээд өндөр гарчээ. Гэрийн ажилд оролцож буй хүүхдийн нилээд хувийг 10-14 насныхан эзэлж байна.

Нийт хүүхдийг сургуульд сурсан болон сураагүй гэж ангилан харахад 5-17 насны хүүхдийн 15.0 хувь нь зөвхөн сургуульд сурч байгаа бөгөөд сургуульд хамрагдсан бүх хүүхдийн 18.6 хувь нь зөвхөн сургуульд сурч (эдийн засгийн ямарваа нэгэн үйл ажиллагаа эрхэлдэггүй, гэрийн ажил хийхэд оролцдоггүй), 8.7 хувь нь сурахын хажуугаар ажил эрхэлж байна. Сургуулийн сурагчдын дийлэнх (72.8 хувь) нь сургуульд сурахын зэрэгцээ гэрийн ажилд тусалж байна. Харин сургуульд сураагүй хүүхэд нийт хүүхдийн 19.1 хувийг эзэлж байгаа бөгөөд эдгээр хүүхдийн бараг тал нь буюу 47.8 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаанд ч



оролцоогүй, гэрийн ажил ч хийгээгүй хүүхдүүд байна. Энд зөвхөн гэрийн ажилд оролцдог хүүхэд 30.2 хувьтай байгаа бөгөөд сурахын хажуугаар гэрийн ажилд оролцдог хүүхдүүдтэй харьцуулахад бараг 2.5 дахин бага хувьтай байна. Харин сургуульд сураагүй хүүхдүүдийн 22.0 хувь буюу таван хүүхдийн нэг нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцжээ.

Судалгаагаар 5-17 насны бүх хүүхдийн 9.4 хувь буюу 58201 нь 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байна. Хөдөөгийн нийт хүүхдэд өрхөөс гадуур амьдарч буй хүүхдүүдийн эзлэх хувь 16.7 (271140 хүүхдийн 45198) байхад хот, суурин газарт энэ үзүүлэлт нэлээд доогуур буюу 3.7 хувь (350472 хүүхдийн 13003)-тай байгаа нь хөдөө орон нутагт сургууль хүрэлцэхгүй байгаатай холбоотой байж болох юм. Өрхөөс гадуур амьдарч байгаа хөдөөгийн хүүхдүүдийн 96.2 хувь нь, хот, суурин газрын хүүхдүүдийн 83.0 хувь нь суралцах зорилгоор өрхөөс гадуур амьдарч байна. Өрхөөс гадуур амьдарч буй хот, суурин газрын хүүхдийн 13.2 хувь нь суралцах, эсвэл ажиллах зорилгогүй, улмаар шалтгаан нь тодорхой бус байгаад анхааран гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй. Өрхөөс гадуур амьдарч буй хүүхдүүдийн 2.3 хувь нь ажил хийх гэсэн үндсэн шалтгаантай байна. Ийм шалтгаантай хүүхдийн эзлэх хувь хөдөө орон нутагт 1.9 хувь, хот, суурин газарт 3.9 хувь байна.

### **Сургуульд суралцаагүй шалтгаан**

5-17 насны нийт хүүхдийн 15.3 хувь (621612 хүүхдийн 94905) нь сүүлийн 7 хоногт сургуульд суралцаагүй байна. Сургуульд хамрагдаагүй хүүхдийн тоо, эзлэх хувь 5-9 насны бүлэгт 72.9 байснаа 10-14 насны бүлэгт эрс багасч, 15-17 насныхны хувьд буцаад өссөн буюу 19.4 хувь болжээ. 5-17 насны 94905 хүүхэд (үүний 54442 нь эрэгтэй, 40463 нь эмэгтэй) сургуульд суралцахгүй байгаагийн 68.9 хувь буюу 65349 нь сургуулийн өмнөх насны хүүхдүүд байна. Үүний дараагаар сурлага муу, сурах сонирхолгүй 6764 хүүхэд, өрхийн орлогод нэмэр болох зорилгоор 5089 хүүхэд сургуульд хамрагдаагүй байгаа ба мөн гэрийн ажилд туслах, ном сурах бичиг, сургуулийн дүрэмт хувцас зэрэг сургалтын зардлыг төлөх чадваргүй өөрөөр хэлбэл хичээлийн хэрэглэл, хувцас зэргийн зардлыг гаргаж чадахгүй, шилжин ирсэн болон шилжиж явсны улмаас сургууль завсардсан хүүхдүүд нилээд хувь буюу 13.4 хувийг эзэлж байна. Сурах сонирхолгүй хүүхэд сургуульд хамрагдаагүй байгаа хүүхдийн 7.1 хувийг эзэлж буй нь манай орны сургалтын систем, багш нарын заах арга зүй, сургалтын орчин нөхцлийг өөрчлөх шаардлага байгааг байна гэж үзэж байна

### Хүүхдийн эдийн засгийн идэвхи

Ажил эрхэлж буй хүүхэд гэдэг нь ажил болон хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг хамруулсан өргөн хүрээний ойлголт юм. Хувиараа хөдөлмөр эрхэлж буй, эсвэл хөлстэй, хөлсгүй, байнгын болон түр зуурын ажил хийж буй, хууль бусаар хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзнэ. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлнэ гэдэг нь ажил эрхлэлтийг тооцох олон улсын жишиг ойлголт юм<sup>1</sup>.

5-17 насны хүүхдийн эдийн засгийн идэвхийг тооцохдоо а) ажил эрхэлж буй буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн, б) эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй, в) ажил ч хийдэггүй, сургуульд ч сурдаггүй гэж гурав ангилан, ангиллын түвшин бүрд эдийн засгийн идэвхийн байдлыг маш нарийвчлан давхардуулалгүйгээр гаргасан бөгөөд ингэснээр нэг хүүхэд зөвхөн нэг ангилалд байхаар тооцсон. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн тоог тооцохдоо хоёр нөхцөл байдлыг анхааралдаа авах ёстойг тэмдэглэх нь зүйтэй. Үүнд: а) зөвхөн ажил эрхэлж буй хүүхдүүд, б) суралцахын зэрэгцээ ажил эрхэлж буй хүүхдүүд. Хүүхдүүдийн өөрийн гэртээ хийж буй ойр зуурын (гэрийн) ажлыг эдийн засгийн үйл ажиллагаанд оруулдаггүй тул дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-ийг тооцдог НҮБ-ын 1993 оны үндэсний тооцооны систем/ҮТС/-ийн үйлдвэрлэлийн хүрээнд хамааруулдаггүй. Тиймээс ажил эрхэлж буй хүүхдүүдэд эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүдийг оруулан тооцоогүй болно.

Судалгаагаар хүүхдийн эдийн засгийн идэвхийг тухайн үеийн идэвхи буюу сүүлийн долоо хоногийн, байнгын идэвхи буюу сүүлийн 12 сарын байдлаар тус тус тооцож гаргасан ба энэ тайланд тухайн үеийн идэвхийн аргачлалаар тооцсон дүнг ашиглав<sup>2</sup>.

### Ажил эрхэлж буй хүүхдүүдийн тоо, тухайн үеийн идэвхийн байдлаар

Судалгааны дүнг улсын хэмжээнд тархаан тооцоход тухайн үеийн идэвхийн аргачлалаар 5-17 насны 71330 хүүхэд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон буюу ажил эрхэлсэн байна. Нийт 5-17 насны хүүхдийн 11.5 хувь нь ажил эрхэлсэн бөгөөд эдгээр хүүхдийг насны бүлгээр авч үзэхэд 5-14 насанд 9.7 хувь, харин 15-17 насанд үлэмж өндөр буюу 16.1 хувьтай байна. Энэ нь Монгол Улсын хөдөлмөрийн хуулинд хөдөлмөрийн насны доод хязгаарыг 16 насаар, зарим ажлыг эрхлэх насны доод хязгаарыг 15 насаар тус тус зааглан тогтоосонтой холбоотой

<sup>1</sup> Эдийн засгийн идэвхтэй хүн амын судалгаа, ажил эрхлэлт, ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлт, ОУХБ, Женев хот, 1990

<sup>2</sup> Эдийн засгийн идэвхийн талаарх ойлголт, тодорхойлолт, тайлбарыг Бүлэг 5-д танилцуулав.

юм. Ажил эрхэлж буй хөвгүүдийн тоо охидынхоос өндөр байна. 5-14 насанд ажил хийж буй хөвгүүдийн эзлэх хувь 10.8 хувь, охидынх 8.4 хувь байна. 15-17 насны бүлэгт энэ үзүүлэлт хөвгүүдийн хувьд 19.5 хувь, охидын хувьд 12.4 хувьтай байна.

Тухайн үеийн аргачлалаар 71330 хүүхэд ажил эрхэлж байгаагийн 1651 нь ажлын байртай боловч сүүлийн долоо хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй буюу ажил хийгээгүй хүүхдүүд байна. Эдгээр хүүхдүүд нь амарсан, чөлөө авсан, өвдсөн зэрэг ямар нэг шалтгаанаар эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй буюу ажил хийгээгүй байгаа тул сүүлийн долоо хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийсэн 69679 хүүхдийн талаарх үзүүлэлтүүдийг нарийвчлан тооцсон.

Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн 69678 хүүхдийн 25.5 хувь нь 5-9 насны, 35.2 хувь нь 10-14 насны, 39.3 хувь нь 15-17 насныхан байна. Эдгээр хүүхдийн 1184 нь цалин хөлстэй ажил, дийлэнх болох 68495 хүүхэд хувиараа хөдөлмөр эрхэлсэн эсвэл өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцсон байна. Нас болон хүйсийн бүтцээр харахад цалин хөлстэй ажил эрхэлсэн хөвгүүдийн тоо /890/ охидынхоос /294/ гурав дахин өндөр байна. Хувиараа хөдөлмөр эрхэлсэн, өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцсон хөвгүүдийн тоо 41283 байхад охидынх ердөө 27211 байна.

Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдийн дийлэнх /1130/ нь 15-17 насныхан байна. 5-14 насны хөвгүүдийн 34 нь цалин хөлстэй ажил эрхэлсэн бол ийм ажил эрхэлсэн охид зөвхөн 10-17 насныхан байна. Цалин хөлстэй ажил эрхэлсэн 15-17 насны хүүхдүүд дунджаар 50 гаруй цагийг 7 хоногийн ажилдаа зарцуулсан нь ОУХБ-аас тогтоосон хүүхдийн хөдөлмөр гэсэн ангилалд тооцох цагаас үлэмж дээгүүр байгаа юм<sup>3</sup>. Энэ нь цалин хөлстэй ажил эрхэлж буй насанд хүрэгчдийн долоо хоногт зарцуулж буй цагаас ч өндөр байгаа боловч ийм ажил эрхэлж буй хүүхдийн тоо маш цөөн байгаа тул энэ талаар дүгнэлт хийхдээ болгоомжтой хандах хэрэгтэй. Долоо хоногт хувиараа хөдөлмөр эрхлэх болон өрхийн бизнест цалин хөлсгүй ажил эрхлэхэд хөвгүүд охидыг бодоход илүү олон цагийг зарцуулсан байна. Ажил эрхэлж буй охид, хөвгүүдийн эзлэх хувийг насны бүлгээр харахад ерөнхийдөө ойролцоо байна.

Нийт ажил эрхэлж буй хүүхдийн дийлэнх буюу бараг 90.0 хувь нь хөдөө орон нутагт байна. Харин цалин хөлстэй ажил эрхэлж буй хүүхдийн дийлэнх нь хот, суурин газарт байна. Хот, суурин газарт ажил эрхэлж буй нийт хүүхдийн 14.5 хувийг цалин хөлстэй ажил эрхэлж буй хүүхэд эзэлж байхад энэ үзүүлэлт хөдөөд

<sup>3</sup> Бүлэг 3-ын хэсэг 5-д өгсөн тодорхойлолтыг үзнэ үү.

0.2 хувьтай байна. Ажил эрхэлж буй нийт хүүхдэд 5-9 насны хүүхдийн эзлэх хувь хөдөө орон нутагт 24.2 хувь байхад хотод ердөө 1.3 хувьтай байна.

Хот, суурин газартай харьцуулахад хөдөө орон нутагт хүүхдүүд өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцоход илүү их цаг зарцуулжээ. Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон хүүхдүүдийг хүйсээр нь авч үзэхэд хот, хөдөөд бараг адил ойролцоогоор 60.0 хувь нь хөвгүүд, 40.0 хувь нь охид байна. Зарим хүүхэд харьцангуй бага наснаас эхлэн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон байна.

### **Ажил эрхэлж буй хүүхдүүдийн боловсролын түвшин**

Ажил эрхэлж буй хүүхдүүдийн боловсролын түвшин анхаарал татсан асуудал хэвээр байна. Ажил эрхэлж буй 10-14 насны хүүхдүүдийн 1.9 хувь нь сургуульд огт суралцаагүй байхад, 15-17 насны хүүхдүүдийн 7.0 хувь нь сургуульд огт суралцаагүй, харин 16.5 хувь нь бага боловсрол эзэмшээгүй хүүхдүүд байна. Эндээс харахад ажил эрхэлж буй хүүхдүүдийн боловсролын түвшин үе тэнгийнхнээсээ доогуур байна. Ажил эрхэлж буй 15-17 насны хүүхдүүдийн бараг тэн хагас нь (46.7 хувь) боловсролгүй болон бага ангийн боловсролтой байна. Гэтэл энэ насны хүүхдүүд доод тал нь 5-9-р ангид сурч байх ёстой. Хүйсийн хувьд онцын ялгаа ажиглагдахгүй байгаа бөгөөд харин 15-17 насны ажил эрхэлж буй охидын 3.4 хувь нь, хөвгүүдийн 2.6 хувь нь бүрэн дунд боловсролтой байна.

### **Сургууль, боловсролоос гадуурх үйл ажиллагаанд зарцуулсан цаг**

Бүх хүүхдийн талаас илүү нь (58.4 хувь) гэрийн ажил хийхэд долоо хоногт 10 хүртэлх цагийг, 10.5 хувь нь 25-аас илүү цагийг тус тус зарцуулсан байна. Энэ үзүүлэлт хүйсээр ялгаатай байгаа бөгөөд гэрийн ажил хийхэд оролцож буй охидын 12.9 хувь, хөвгүүдийн зөвхөн 8.3 хувь нь долоо хоногт 25-аас илүү цагийг зарцуулсан байна. 5-9 насны хүүхдүүд гэрийн ажилд нэлээд тусалж байна. Гэхдээ ийм хүүхдүүдийн 82.2 хувь нь долоо хоногт 9 хүрэхгүй цагийг гэрийн ажилд туслахад зарцуулжээ. Насны бүлэг дээшлэх тусам гэрийн ажилд туслах нь цаг нь нэмэгдэж байна. Жишээлбэл: 10-14 насны хүүхдүүдийн тавны хоёр нь (40.3 хувь), 15-17 насны хүүхдүүдийн бараг тавны гурав нь (55.3 хувь) нь долоо хоногт 10-41 цагийг гэрийн ажилд туслахад зарцуулжээ. Долоо хоногт 42-оос дээш цагийг гэрийн ажил хийхэд зарцуулсан охидын тоо (5503) хөвгүүдийнхээс (4011) нилээд их байна. Гэрийн ажлыг хийхэд оролцож буй хүүхдүүдийн дийлэнх нь 10-14; 15-17 насныхан байна.

### **Хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагаа**

МХХС-ны тархаалтын тооцоогоор тухайн үед 71330 хүүхэд ажил эрхэлж байгаагийн дийлэнх хүүхэд нь (88.9 хувь) хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт ажиллаж байна. Нийт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүдийн 5.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 1.4 хувь нь боловсруулах аж үйлдвэрт, 1.2 хувь нь зочид буудал, зоогийн газарт, 1.0 хувь нь уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт ажиллаж байна. Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд бүх салбарт ажиллаж буй хүүхдүүдийн дийлэнх нь хөвгүүд байна. Насны бүлгээр харахад хөдөө аж ахуйн салбарт бүх насны хүүхдүүд ажиллаж байгаа бол, бусад салбарт 10-17 насныхан илүү ажиллаж байгаа дүн гарчээ.

### **Ажил эрхэлж буй хүүхдүүдийн ажил эрхлэлтийн байдал**

Тухайн үед ажил эрхэлсэн дийлэнх хүүхэд (90.0 орчим хувь) өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч байж, түүний дараагаар хувиараа хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд (8.8 хувь) орж байна. Гэрээгээр ажил эрхэлж буй хүүхдүүдийн ихэнх нь боловсруулах аж үйлдвэр, уул уурхай, олборлолт болон барилгын салбарт ажиллаж байна. Хүйсийн хувьд онцын ялгаа ажиглагдсангүй.

### **Ажил эрхэлж буй хүүхдүүд, ажил мэргэжлийн ангиллаар**

Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдүүдийн ихэнх нь (84.6 хувь) нь хөдөө аж ахуйн холбогдолтой ажил хийж байна. Түүний дараагаар энгийн ажил (5.8 хувь), үйлчилгээний ажил (5.1 хувь), үйлдвэр, худалдааны ажил (3.5 хувь) хийж байгаа хүүхдүүд орж байна. Насны бүлгээр авч үзвэл 5-9 насны бараг бүх хүүхэд (89.1 хувь) хөдөө аж ахуйн холбогдолтой ямар нэгэн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлжээ. Харин бусад төрлийн ажилд ахлах насны хүүхдүүд илүү ажиллаж байна. Байнгын эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүдийн ажил мэргэжлийн төрөл нь тухайн үеийнхтэй адилхан байна.

### **Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдүүдийн сарын орлого**

Судалгааны дүнгээс харахад цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдүүдийн 56.1 хувь нь сургуульд сурч, 43.9 хувь нь сургуульд сурдаггүй хүүхдүүд байна. Сургуульд сурахын зэрэгцээ цалин хөлстэй ажил хийдэг хүүхдүүдийн 25.2 хувь нь 10000 хүртэлх төгрөгийн, ихэнх нь буюу 46.1 хувь нь 11000-20000 төгрөгийн, харин үлдсэн 28.7 хувь нь 21000 төгрөгөөс дээш орлого олж байгаа нь хамгийн өндөр

орлого олдог хүүхдүүдийн тавны хоёрыг эзэлж байна. Хүйсийн хувьд онцын ялгаагүй, гагцхүү сарын цалин, орлого нь өндөр буюу 30000-аас дээш төгрөгний орлоготой хүүхдүүд нь дандаа хөвгүүд байна. Гэхдээ цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдийн тоо бага, зөвхөн тооцоогоор гарч байгаа гэдгийг энэхүү мэдээллийг ашиглахдаа анхаарах хэрэгтэй.

### **Эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд**

Ихэнхи хүүхдүүд ямар нэгэн хэмжээгээр гэрийнхээ ажилд тусалж байна. Хүүхэд хэд хэдэн төрлийн гэрийн ажил хийсэн байж болох бөгөөд хамгийн түгээмэл хийж буй эдийн засгийн бус үйл ажиллагаа буюу гэрийн ажлуудыг дурьдвал, хоол цай хийх, аяга таваг угаах, гэр орон цэвэрлэх, ус авах, түлээ түлш бэлтгэх, хувцас угаах, индүүдэх, гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдаж авахаар дэлгүүр явах зэрэг ажлууд байна. Хүүхдүүдийн 71.9 хувь нь хоол унд хийх, аяга таваг угаах, 70.7 хувь нь гэр орон цэвэрлэх, 23.9 хувь нь гэр орныхоо хэрэгцээт зүйлсийг худалдан авахаар дэлгүүр хоршоогоор явах ажилд тусалсан байна. Ус авах, түлээ түлш бэлтгэх ажлыг хөвгүүд илүүтэй хийж байгаа нь биеийн хүч шаарддаг, магадгүй хол зам туулахад хүрдэг зэрэгтэй холбоотой байж болох юм. Гэр орныхоо хэрэгцээт зүйлсийг худалдан авах, дэлгүүр явахын хувьд бол охид, хөвгүүдийн аль аль нь оролцож байна.

Ус авах, түлээ түлш бэлтгэх ажлыг хийхэд олон хүүхэд оролцсоныг харгалзан тусгайд нь хүснэгт боловсруулан долоо хоногт зарцуулсан цаг, насны бүлэг, хүйсээр тооцсон. НҮБ-ын 1993 онд боловсруулсан ҮТС-ийн хүрээнд дээрх хоёр ажлыг эдийн засгийн үйл ажиллагаанд тооцон, ажил мэргэжлийн олон улсын ангиллын 6210-р бүлэгт (амиа аргацаасан хөдөө аж ахуй, загас ан агнуур эрхлэх) бүртгэдэг. Гэхдээ ус авах, түлээ түлш бэлтгэх ажлыг ҮТС-ийн үйл ажиллагаанд хамруулах асуудлыг тухайн улс орон өөрийн орны нөхцөл байдалд тохируулан харилцан адилгүй шийддэг бөгөөд Монгол Улсын хувьд энэхүү ажлуудыг ҮТС-ийн үйл ажиллагаанд оруулж тооцдоггүй болно.

### **Хүүхдийн хөдөлмөрийн тооцоо**

Хүүхдийн хөдөлмөр нь ажил эрхэлж буй буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд гэсэн ойлголтоос арай бага хүрээг хамарсан, нарийвчилсан ойлголт юм. ОУХБ-ын 138, 182-р конвенцийн дагуу хүүхдийн хөдөлмөрийг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

5-11 нас = Энэ насны эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй бүх

хүүхэд;

Нэмэх нь:

12-14 нас = Энэ насны эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд [эсвэл “хөнгөн ажлыг өдөрт 2-оос дээш цагаар эрхэлж буй хүүхэд” гэж томъёолбол зөв болно]

Нэмэх нь: 15-17 нас = Аюултай ажил эрхэлж буй болон тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй бүх хүүхэд [Долоо хоногт 43 болон түүнээс дээш цагийг зарцуулж буй ажлыг аюултай ажилд оруулж тооцсон]

Тооцоогоор сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 69678 хүүхдийн 43158 (62.0 хувь) нь хөдөлмөр эрхэлж байна гэж гарлаа. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан 5-17 насны нийт хүүхдийн 6.9 хувь нь (621612 хүүхдийн 43158 нь) хөдөлмөр эрхэлж байна гэсэн үг юм. Хөдөлмөр эрхэлж буй нийт 43158 хүүхдийн 62.0 хувь нь хөвгүүд, 38.0 хувь нь охид байна.

Гэхдээ МХХС-нд хараа хяналтгүй, тэнүүчлэн амьдарч буй болон нийтийн байранд суугаа хүүхдүүдийг хамруулаагүй тул хүүхдийн хөдөлмөрийн талаарх дээрх тоо мэдээ нь Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийг бүрэн хамраагүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Үүнээс гадна өрхийн судалгаа нь голдуу далд хэлбэрээр явагддаг тэвчишгүй хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг хамрах боломжгүй байдаг.

### **Өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх буюу ажил хийх болсон шалтгаан**

Судалгааны тооцоогоор нийт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийсэн хүүхдүүдийн 4.5 орчим хувь (71330 хүүхдээс 3219) нь өрхөөс гадуур ямар нэгэн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийж байна. Эдгээр хүүхдүүдийн олонхи нь өрхийн орлогод нэмэр болох зорилгоор (3219 хүүхдийн 1957 нь буюу 60.8 хувь) эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байна гэж хариулсан байна. Ийм хариултыг өрхөөс гадуур ажил хийхийн зэрэгцээ сургуульд сурч буй хүүхдүүдийн 56.9 хувь (2337 хүүхдийн 1329 нь), харин сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн 71.2 хувь (882 хүүхдийн 628) нь өгчээ. Ажлын дадлага, туршлагатай болох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх болсон гэсэн хариултыг нийт хүүхдүүдийн 7.2 хувь (3219 хүүхдийн 233 нь), сургуульд сурч буй хүүхдүүдийн 9.0 хувь (2337 хүүхдийн 211 ) нь, сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн 2.5 хувь (882 хүүхдийн 22) нь тус тус өгчээ. Сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн зарим нь

сургуульд сурахад гарах зардлыг олохын тулд ажилласан гэж хариулсан сонирхууштай дүн гарлаа. Өөрийгөө авч явах, эдийн засгийн хувьд биеэ даахын тулд зарим хүүхэд ажил эрхэлж байна.

### **Хүүхэд ажиллахаа боливол өөрт нь болон өрхөд үзүүлэх нөлөө**

Өрхөөс гадуур ажил эрхэлж буй нийт хүүхдийн 43.8 хувь нь ажил хийхээ болих нь өөрсдөд нь болон өрхөд нь ямар нэг нөлөө үзүүлэхгүй гэж хариулжээ. Харин муугаар нөлөөлнө гэж хариулсан хүүхдүүдийн бараг тал нь өрхийн амьжиргааны түвшин доошилно гэж, харин 7.1 хувь нь өрх орлогын эх үүсвэргүй болно гэж хариулжээ. Түүнчлэн ажлын дадлага, туршлагагүй болно, өрхийн бизнест муугаар нөлөөлнө гэж цөөн хүүхэд үзжээ.

### **Хүүхдийн ажил эрхлэлт, улирлаар**

Тухайн үеийн эдийн засгийн идэвхийн байдлаар судалгааны улирлын үр дүнг харьцуулан үзэхэд 1 дүгээр улиралд буюу 7-9 сард хамгийн их буюу 118405 хүүхэд ажил эрхэлж, харин судалгааны 2 дугаар улирал буюу 10-12 сард хамгийн цөөн буюу нэгдүгээр улирлынхаас бараг гурав дахин бага 40462 хүүхэд ажил эрхэлсэн байна. Ер нь хүүхдийн ажил эрхлэлт манай оронд улирлаар их хэлбэлзэлтэй байдаг хандлагыг дээрх дүнгээс харж болохоор байна. Судалгааны нэг, дөрөвдүгээр улиралд буюу зун, намрын цагт хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил эрхэлсэн хүүхдийн тоо хамгийн өндөр байгаа бөгөөд, харин судалгааны хоёр, гуравдугаар улирал буюу өвөл, хаврын улиралд хамгийн бага байгаа нь хүүхдүүдийн хичээл сургуультай нь холбоотой. Сургуулийнхаа амралтын цагаар хүүхэд залуусын эдийн засгийн үйл ажиллагааны оролцоо буюу ажил эрхлэлт их байна.

Тухайн үеийн идэвхийн байдлаар ажил эрхэлж буй 5-17 насны нийт хүүхдийн насны бүтцийг улирлаар тооцож үзэхэд судалгааны 2 дугаар улирлаас бусад гурван улирлын турш ажил эрхэлж буй хүүхдүүдийн насны бүтэц нэг их өөрчлөгдөлгүйгээр ойролцоо хувьтай гарсан байна. Харин судалгааны 2 дугаар улирал буюу 10-12 сард арван хүүхдийн тав нь 15-17 настай, гурав нь 10-14 настай, хоёр нь 5-9 настай хүүхдүүд байна. Энэхүү хандлага эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн хувьд мөн хадгалагдаж байна.



## БҮЛЭГ 2. УДИРТГАЛ

### 2.1 Танилцуулга

Үндэсний статистикийн газарт “Ажиллах хүчний түүвэр судалгаа”-г “Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа” –тай хамтруулан 2002-2003 онд олон улсын жишиг аргачлалын дагуу анх удаа зохион байгуулж, явуулсан билээ. Энэ судалгаа нь олон улсын нийтлэг тодорхойлолт, арга зүйг ашиглан хүн амын эдийн засгийн идэвхийг сүүлийн 7 хоногийн буюу тухайн үеийн, сүүлийн 12 сарын буюу байнгын идэвхийн аргачлалаар тооцох замаар хүн амын ажил эрхлэлтийн байдлыг тодорхойлон, хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийн холбогдолтой үзүүлэлтүүдийг бүс нутаг, хот, хөдөө, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангилал, ажил эрхлэлтийн байдлаар улирлын нөлөөллийг тусган тооцож гаргаснаараа чухал ач холбогдол бүхий судалгаа болсон.

МХХС-г, АХС-ны хавсарга судалгаа болгон өмнө нь нэг удаа явуулсан туршлагад үндэслэн хүүхэд хамгааллын талаар цаашдын стратеги, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд шаардлагатай статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулах, цаашлаад хөдөлмөрийн статистикийн үзүүлэлтийн системд хүүхдийн хөдөлмөрийн үзүүлэлтүүдийг оруулж ирэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ шаардлагын үүднээс ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөрийн газраас тавьсан саналын дагуу өмнөх 2002 - 2003 оны судалгааны нэг адилаар ХХС-г, АХС-ны хавсарга судалгаа болгон ОУХБ-аас гаргасан нийтлэг тодорхойлолт, арга зүйн дагуу 2006 оны 7 дугаар сараас эхлэн Үндэсний Статистикийн Газар нь ОУХБ-ын санхүү, техникийн дэмжлэгтэйгээр явуулсан юм.

Ийнхүү МХХС-г хоёр дахь удаагаа явуулж байгаа нь хүүхдийн эдийн засгийн идэвхи, хүүхдийн ажил, хөдөлмөрийн цар хүрээ, төлөв байдлын талаарх мэдээллийн санг баяжуулж байгаагаараа ихээхэн ач холбогдолтой юм. Энэ нь хөдөлмөр эрхлэх эрсдэлтэй болон хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг бодитойгоор тодорхойлон улмаар ажил эрхэлж буй хүүхдүүдийн эрхийг хамгаалах, хүүхдийн хөдөлмөрийг бүрэн устгахад чиглэсэн үндэсний хэмжээний бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд тулгуур материал болох юм.

Энэ удаагийн судалгаа нь өмнөх судалгаатай харьцуулахад түүврийн загварыг шинэчлэн боловсруулж, үзүүлэлтүүдийг аймгийн түвшинд гаргах бололцоотой болсноороо чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн өмнөх 2002-2003 оны судалгааны үр дүнг боловсруулах явцад зарим асуултуудыг тодруулан

баяжуулах зайлшгүй шаардлага ажиглагдсан тул энэ удаагийн судалгааны асуулгыг боловсруулахдаа хүүхдийн амьдарч буй өрхийн нийгэм, эдийн засгийн байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хүн амын шилжилт хөдөлгөөн, боловсрол болон сургалтанд хамрагдалт, хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн ажлын байрны нөхцөлийн талаарх асуултуудыг нэмж оруулсан юм.

## 2.2. Судалгааны зорилт

МХХС-гаар 5-17 насны хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагааг өрхөд суурилан авч үзэж судаллаа. Тус судалгааны стратегийн зорилт нь хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж (сургуульд хамрагдалт, эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаан дахь хүүхдийн оролцооны талаарх), тоон болон чанарын үзүүлэлтээс бүрдсэн 2002-2003 оны мэдээллийн санг баяжуулахад оршиж байв. Хөдөө орон нутаг, хот, суурин газар болон улсын хэмжээн дэх хүүхдийн хөдөлмөрийн байдалд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, хүүхдийн хөдөлмөрийн чиг хандлага, тэдгээрийн үндсэн шалтгаануудыг тодорхойлоход судалгааны дүнг ашиглана.

Судалгааны асуулга (АХС+ХХС) нь үндсэн болон хавсарга хэсгээс бүрдсэн. Судалгааны үндсэн болон хавсарга асуулгын мэдээллийг бөглөхдөө өрхийн 5 ба түүнээс дээш насны бүх гишүүдээс (харин асуултанд хариулах чадваргүй гишүүнийг төлөөлөн хариулж чадах өрхийн насанд хүрсэн гишүүнээс) ярилцлага авч өрхийн бүх гишүүдийн хүн ам зүйн болон эдийн засгийн идэвхийн талаарх мэдээлэл цуглуулсан. Хүүхдийн хөдөлмөрийн хавсарга судалгаагаар хүүхдийн хөдөлмөрийн төлөв байдал, хамрах хүрээ, хөдөлмөр эрхлэх болсон шалтгаан, хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн ажлын нөхцөл, хөдөлмөр эрхэлснээр хүүхдийн эрүүл мэнд болон боловсрол, хэвийн өсөлт бойжилтод хэрхэн нөлөөлж буй талаарх мэдээллийг хамруулав. Энэхүү мэдээллийг цуглуулснаар хүүхдийн хөдөлмөрийг устгах бодлого, үйл ажиллагаанд ашиглах зорилгоор хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг тодорхойлох, ажлын байрны нөхцөл, гарч буй үр дагавар зэргийг тооцох замаар хүүхдийн хөдөлмөрийн талаар иж бүрэн шинжилгээ хийх, статистикийн мэдээлэл, дүн шинжилгээ дүгнэлт бүхий Монгол Улсын Хүүхдийн хөдөлмөрийн үндэсний тайланг боловсруулан, олон нийтэд танилцуулах, түгээх, тэдний ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, Монгол Улсын хүүхдийн хөдөлмөрийн талаарх тоо мэдээг ОУХБ-ын хүүхдийн хөдөлмөрийн мэдээллийн санд нэгтгэн оруулж, бүс нутгийн болон дэлхийн түвшинд боловсруулан гаргадаг энэ талын тайланд Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн холбогдолтой мэдээллийг

тусгадаг болох чухал ач холбогдолтой юм.

### 2.3 Судалгааны хугацаа

Судалгааны хамралтын хугацаа нь 4 улирал буюу 2006 оны 7 дугаар сараас 2007 оны 6 дугаар сарыг дуусталх нэг жилийн хугацааг хамарсан. Судалгааны эхний улирлын мэдээллийг 2006 оны 7-9 дүгээр саруудад, хоёрдугаар улирлынхыг 2006 оны 10-12 дугаар саруудад, гуравдугаар улирлынхыг 2007 оны 1-3 дугаар саруудад харин сүүлчийн буюу дөрөвдүгээр улирлын мэдээллийг 2007 оны 4-6 дугаар саруудад цуглуулсан болно. Иймд судалгааны улирлын хугацаа цаг тооллын улирлын хугацаатай таарахгүй байгаа болно.

### 2.4 Тайлангийн агуулга, бүтэц

Энэхүү Хүүхдийн хөдөлмөрийн судалгааны үр дүнгийн тайлан нь дараах 11 бүлэгтэй. Үүнд:

Бүлэг 1. Ерөнхий тойм

Бүлэг 2. Удиртгал

Бүлэг 3. Судалгааны арга зүй, зохион байгуулалт, ойлголт тодорхойлолтууд

Бүлэг 4. Хүн ам зүйн болон өрхийн үзүүлэлтүүд

Бүлэг 5. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн өрхийн нийгэм, эдийн засгийн байдал

Бүлэг 6. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн төлөв байдал

Бүлэг 7. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэх болсон шалтгаан, үр дагавар

Бүлэг 8. Хүнд хортой болон аюултай хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд

Бүлэг 9. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн улирлын хэлбэлзэл

Бүлэг 10. Хүүхдийн хөдөлмөрийн 2002/03 ба 2006/07 оны судалгаануудын үндсэн үр дүн

Бүлэг 11. Түүврийн алдаа

**Бүлэг нэгд** судалгааны ерөнхий тойм, танилцуулга, **Бүлэг хоёрт** судалгааны үндсэн зорилт, тайлангийн агуулга бүтцийг тодорхойлсон бол, **Бүлэг гуравт** судалгаанд хэрэглэсэн арга зүй болон ойлголт тодорхойлолтууд, судалгааны зохион байгуулалтын талаар, **Бүлэг дөрөвт** хүн ам зүйн болон өрхийн байдлыг тодорхойлсон бол **Бүлэг тавд** хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн өрхийн нийгэм-эдийн засгийн байдлын талаар, **Бүлэг зургаад** хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн

төлөв байдлыг дэлгэрэнгүй байдлаар, **Бүлэг долоод** ОУХБ-аас 2002<sup>4</sup> онд гаргасан Хүүхдийн хөдөлмөрийн тооцоонд хэрэглэх олон улсын тодорхойлолтын дагуу хүүхдийн хөдөлмөрийг зарим үзүүлэлтээр тооцон гаргаж, хүүхдийг хөдөлмөр эрхлэхэд хүргэж буй шалтгаан, ажиллахаа боливол өөрт нь болон түүний гэр бүл, өрхөд үзүүлэх нөлөөний талаар, **Бүлэг наймд** хүнд хортой болон аюултай хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн талаар, **Бүлэг есөд** хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг улирлаар харьцуулан харуулсан бол, **Бүлэг аравт** өмнөх 2002-2003 онд явуулсан хүүхдийн хөдөлмөрийн судалгааны үр дүнг энэ удаагийн судалгааны үр дүнтэй харьцуулалт хийсэн талаар, **Бүлэг арван нэгд** судалгааны түүвэрлэлтийн алдааны талаар тус тус тайлбарласан болно.

---

<sup>4</sup> Хүүхдийн Хөдөлмөрийн Тоо Мэдээ, Дэлхийн Хэмжээнд, ОУХБ/ХХУОУХ-ХХС, Женев хот, 2002 оны 4-р сар.

### **БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТУУД**

#### **3.1 Судалгааны хамрах хүрээ**

Ажиллах хүчний судалгаатай хамтруулан явуулсан энэхүү судалгаа нь хүүхдийн хөдөлмөрийн талаарх бодит тоо мэдээг улсын хэмжээнд болон хот, хөдөө, бүс нутаг, аймаг нийслэлээр цуглуулан тооцох зорилгоор явагдсан. Өрхөд түшиглэн явуулсан тул өрхийн 5-17 насны хүүхдүүд хамрагдаж судалгааны асуулганд хариулсан болно. Харин гэр оронгүй, хараа хяналтгүй хүүхдүүд болон засан хүмүүжүүлэх газар, асрах газар, халамжийн төв зэрэг нийтийн байранд амьдарч буй хүүхдүүд хамрагдаагүй юм.

Судалгааны бүлэглэлтийг засаг захиргааны нэгж буюу бүх аймгууд, Улаанбаатар хотын дүүргүүд байхаар хийсэн бөгөөд үндсэн үзүүлэлтүүдийг бүс нутгаар, аймгаар тооцож болохуйцаар Монгол Улсыг бүхэлд нь хамруулан өргөн цар хүрээнд явуулж, улсын хэмжээнд 4 бүс нутаг (Төв, Баруун, Зүүн, Хангай), Улаанбаатар хотын нийт 12288 өрхөөс асуулга авсан. Нэг жилийн туршид судалгаанд хамруулахаар төлөвлөсөн нийт 12288 өрхөөс 12286 өрх хамрагдаж, хамралтын хувь 99.9 хувьтай гарлаа.

Тоон мэдээллийг сар бүр цуглуулан улирлаар үр дүнг нэгтгэсэн ба улирал тутамд нийт түүвэрлэгдсэн өрхийн дөрөвний нэг нь ногдож байв. Энэхүү тайланд нийт 12 сар буюу бүтэн жилээр нэгтгэн гаргасан үзүүлэлтүүдийг тооцсоны зэрэгцээ улирлын хэлбэлзэлийг харуулах зорилгоор зарим тоон мэдээллийг улирлаар тооцсон.

#### **3.2 Судалгааны түүвэрлэлт**

Судалгааны түүвэрлэлтийн нэгж нь өрх юм. Байнга хамтран амьдарч, орлогоо нэгтгэн хоол хүнсээ бэлтгэж, нэг тогооноос хоол иддэг нэг буюу хэд хэдэн хүмүүсийг өрх гэж үзнэ. Эдгээр хүмүүс нь хамаатан садан болон ажил олгогчтойгоо хамтран амьдардаг, цусан төрлийн хамааралгүй гэрийн үйлчлэгч, бусад хөлсний ажилчид ч байж болно. Өрхийн ам бүлийн тоонд тухайн өрхөд 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа (хугацаат цэргийн албан хаагч, оюутан сурагчид, гадаадад ажиллаж, амьдарч байгаа болон цагдан хоригдож байгаа) иргэдийг оруулаагүй болно.

Ажиллах хүчний болон Хүүхдийн хөдөлмөрийн 2002-2003 оны судалгааны түүвэрлэлтийн нэгж нь 2000 оны Хүн ам, орон сууцны улсын тооллогын нэгж

байсан бол 2006-2007 оны судалгааны нэгжээр Монгол Улсын засаг захиргааны нэгжийг авч, түүвэрлэлтийг 2005 оны өрх, хүн ам, хөдөлмөрийн насны хүн амын тоог үндэслэн өмнө хийсэн судалгааны түүврийн дизайныг сайжруулах замаар хийгдсэн болно. 2000 оны ХАОСТ-оор нийт хүн амын тоо 2373493, өрх 541149 байсан бол 2005 оны жилийн эцсийн байдлаар хүн ам 2562400, өрх 611026 болж өөрчлөгдсөний зэрэгцээ, хүн амын шилжих хөдөлгөөн их байсан нь түүврийн дизайныг дахин (Re design) сайжруулах, сүүлчийн оны жилийн эцсийн холбогдох тоо, мэдээлэлд үндэслэн хийх шаардлага гарсан болно. Мөн олон өрх, хүн амтай түүврийн анхан шатны нэгж буюу зарим аймгийн төвийн баг, хотын хэсгүүдийг сегмент болгон хуваах шаардлага түүвэрлэлтийн техникээс шалтгаалан урган гарч ирсэн болно. Энэхүү нөхцөл болон түүвэрлэлтийн нэгж, түүвэрлэх өрхийн тооны харьцааны шаардлагын дагуу судалгааны нэгжид оногдох өрхийг 12, нэгжийг 1024 байхаар тогтоосон болно.

Ийнхүү судалгааны түүвэрлэлтийг нарийвчилсан байдлаар хийсэн нь судалгааны үр дүнг аймаг, нийслэлээр гаргах боломжтой болсноороо өмнөх судалгаанаас давуу талтай юм.

Ажиллах хүчний түүвэр судалгааны бүлэглэлтийг 21 аймаг тус бүрийг нэг бүлэг, Улаанбаатар хотын 9 дүүргийг 8 бүлэгт (хамгийн цөөн өрхтэй 2 дүүргийг нэг бүлэгт хамруулсан) хувааж нийт 29 бүлэглэлт хийсэн. Улаанбаатар хотын дүүргийн хорооны хэсгүүд болон аймгийн багуудыг түүвэрлэлтийн анхан шатны нэгж (ТАШН) -ээр авч 384 хэсэг, 640 баг нийт 1024 анхан шатны нэгжийг түүвэр судалгаанд хамрууллаа.

**Ажиллах хүчний түүвэр судалгаанд олон шатат түүврийн арга** хэрэглэсэн. Түүвэрлэлтийг хийхдээ таамаглаж байгаа ажилгүйчүүдийн тооны нийт хүн амд эзлэх хувийн жингээр магадлал хийн тооцсон болно. Нөгөөтэйгүүр түүвэрлэлтийг аймаг, хотын дүүргээр бүлэглэн хуваарилахдаа хөдөлмөрийн насны хүн амд пропорциональ харьцаагаар жигд тархаан тооцсон.

Түүврийн эхний шатанд ТАШН нь нийт хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргаар сонгогдсон (ПМТ), Түүврийн хоёрдугаар шатанд судалгааны нэгж бүрээс 12 өрхийг сонгохдоо, ТАШН-ээс энгийн санамсаргүй системчилсэн циклт түүврийн дэд түүвэрлэлтийн техникийг ашигласан болно. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдах өрхийг сонгохдоо 2 шаттай түүвэрлэлтийн (sub-sampling) аргыг хэрэглэсэн.

**Хүснэгт 1: Ажиллах хүчний түүвэр судалгааны бүлэг тус бүрт  
сонгогдсон ТАШН, өрхүүдийн тоо**

Бүлгийн дугаар	Бүлгийн нэрс	Нийт өрх	Нийт хүн ам	Түүвэрлэгдэх нэгжийн тоо	Түүвэрлэгдэх өрхийн тоо	Улиралд түүвэрлэгдэх өрхийн тоо	Сард түүвэрлэгдэх өрхийн тоо
1	Архангай	24,276	91,092	32	384	96	32
2	Баян-Өлгий	21,328	95,758	40	480	120	40
3	Баянхонгор	20,935	82,088	32	384	96	32
4	Булган	15,016	56,428	24	288	72	24
5	Говь-Алтай	15,473	63,587	24	288	72	24
6	Дорноговь	13,968	51,582	24	288	72	24
7	Дорнод	18,087	73,981	32	384	96	32
8	Дундговь	12,628	49,934	24	288	72	24
9	Завхан	19,929	78,668	32	384	96	32
10	Өвөрхангай	28,793	108,235	40	480	120	40
11	Өмнөговь	12,798	47,866	24	288	72	24
12	Сүхбаатар	13,339	52,768	24	288	72	24
13	Сэлэнгэ	22,193	90,190	32	384	96	32
14	Төв	23,309	88,491	32	384	96	32
15	Увс	19,800	80,924	32	384	96	32
16	Ховд	19,478	91,687	32	384	96	32
17	Хөвсгөл	29,655	123,416	56	672	168	56
18	Хэнтий	17,941	66,762	24	288	72	24
19	Дархан-Уул	22,238	90,656	40	480	120	40
21	Орхон	20,870	84,297	32	384	96	32
22	Говь-Сүмбэр	3,245	12,625	8	96	24	8
	<b>Аймгийн дүн</b>	<b>395,299</b>	<b>1,581,035</b>	<b>640</b>	<b>7,680</b>	<b>1,920</b>	<b>640</b>
22	Сонгино хайрхан	44,862	204,587	80	960	240	80
23	Баян зүрх	47,459	196,132	80	960	240	80
24	Баянгол	35,294	160,479	64	768	192	64
25	Сүхбаатар	26,097	117,233	48	576	144	48
26	Хан Уул	20,032	87,912	40	480	120	40
27	Чингэлтэй	28,371	130,501	56	672	168	56
28	Налайх	6,521	26,529	8	96	24	8
29	Багануур Багахангай	7,091	29,037	8	96	24	8
	<b>Нийслэлийн дүн</b>	<b>215,727</b>	<b>952,410</b>	<b>384</b>	<b>4,608</b>	<b>1,152</b>	<b>384</b>
	<b>УЛСЫН ДҮН</b>	<b>611,026</b>	<b>2,533,445</b>	<b>1,024</b>	<b>12,288</b>	<b>3,072</b>	<b>1,024</b>

### 3.3. Судалгааны асуулгын хуудас, ахлагч тоологч нарын сургалт, мэдээлэл цуглуулалт

Ажиллах хүчний судалгаа болон Хүүхдийн хөдөлмөрийн 2002-2003 онд явуулсан судалгааны асуулга 7 бүлэг бүхий 123 асуулттай байсан бол энэхүү судалгааны асуулга нь 9 бүлэг 159 асуултаас бүрдэж, шинээр 2 бүлэг, 36 асуулт нэмэгдээд байна. Энэ нь өмнөх судалгааны үр дүнг боловсруулах явцад хүн амын ажил эрхлэлт нэн ялангуяа хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг өрхийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдтэй уялдуулан судлах, мөн хүн амын ажил эрхлэлттэй салшгүй холбоотой шалтгаануудыг тодруулах зорилгоор хүн амын шилжих хөдөлгөөн, боловсрол, сургалт, албан бус хөдөлмөр эрхлэлттэй холбогдолтой үзүүлэлтүүдийг нэмсэнтэй холбоотой.

Хүүхдийн хөдөлмөрийн судалгааны асуулга нь хүүхдийн өрх, өрхөөс гадуурх эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаан дахь оролцооны талаарх

мэдээллийг цуглуулахад чиглэсэн. Тухайлбал 5-17 насны хүүхэд нь гэрийн ажилд оролцож буй эсэх, хэдэн наснаасаа эхлэн өрхөөс гадуур ажил хийж эхэлсэн, ажлаас болж өвдөж гэмтсэн эсэх талаар нарийвчлан судалсан.

Судалгааны зорилго, зорилтууд, хамрах хүрээг харгалзан, тухайн үеийн болон байнгын эдийн засгийн идэвхийн тодорхойлолт, аргачлалыг ашиглан судалгааны асуулгыг дараах мэдээллийг боловсруулан гаргахад чиглүүлж боловсруулсан. Үүнд:

1. Өрхийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд (өрхийн сууцны төрөл, өмчлөл, эзэмшлийн хэлбэр, эрчим хүч, түлш, усан хангамж, хувийн мал, газартай эсэх)
2. Хүн ам зүйн үзүүлэлтүүд (өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох, хүйс, төрсөн он, сар, өдөр, сургуульд суралцсан, суралцаж байгаа эсэх, боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэг, гэрлэлтийн байдал, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан)
3. Сүүлийн 7 хоног буюу тухайн үеийн идэвхи (эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаа, түүнд зарцуулсан цаг, эдийн засгийн идэвхитэй, идэвхигүй байдал, үндсэн болон давхар ажил эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, ажил эрхлэлтийн байдал, ажил мэргэжлийн ангиллаар, үндсэн ажлынхаа цалин хөлсийг ямар хугацааны давтамжтай авдаг, авч буй цалин, хөлс, орлого)
4. Нэмэгдэл ажил хийх хүсэл, боломж (нэмэгдэл ажил хийх хүсэл, боломжтой эсэх, нэмэгдэл ажил хийх хүсэл боломжгүй байгаа шалтгаан, нэмэгдэл ажил хэрхэн хайсан)
5. Ажилгүйдэл (ажил хийхэд бэлэн байсан эсэх, эдийн засгийн идэвхигүй байсан шалтгаан, ажил хайсан хугацаа, ямар төрлийн/ажил мэргэжлийн ажил хийх хүсэлтэй байгаа, хичнээн төгрөгний цалин хөлс (өдрийн, сарын) авах бодолтой байгаа, хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн эсэх, хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн хугацаа, сүүлийн 30 хоногт ажил хайсан эсэх, ажил хайсан хэлбэр, ажил хайгаагүй шалтгаан, ажилгүй байсан хугацаа)
6. Байнгын эдийн засгийн идэвхи (сүүлийн 12 сарын буюу байнгын эдийн засгийн идэвхи, сүүлийн 12 сарын хугацааны үндсэн болон давхар ажил эрхлэлт, ажил эрхлэлтийн байдал, ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрлөөр, ажилгүй байсан хугацаа, ажил



- хайсан хэлбэр, сүүлийн 12 сард үндсэн болон давхар ажил эрхлэлтээс авсан дундаж цалин хөлс, орлого)
7. Өмнөх үеийн ажил эрхлэлт (өмнөх үеийн ажил эрхлэлт, ажил мэргэжил, ажил эрхлэлтийн байдал, ажиллаж байсан эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, хамгийн сүүлийн ажлаа хир удаан хийсэн, өмнөх үеийн ажил эрхлэлтийн хамгийн сүүлчийн өдөр, хугацаа, хамгийн сүүлчийн ажлаа хийхээ больсон шалтгаан, ажилгүй байх хугацаандаа ямар орлого, тусламжаар амьдарч байгаа)
  8. 5-17 насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлт (гэрийнхээ ажилд тусалж байгаа хэлбэрүүд, сургуульд хамрагдалт, сургуульд бүрэн хамрагдаж чадахгүй байгаа шалтгаан, өрхийн аж ахуйн ажилд оролцдог эсэх, анх хэдэн настайгаасаа эхэлж ажил хийсэн, өрхийн аж ахуйд туслах, ажиллах болсон шалтгаан, өрхөөс гадуур ямар нэг ажил хийх болсон шалтгаан, хүүхдүүд ажлын байрныхаа нөхцөлд сэтгэл ханамжтай байдаг эсэх, хийж буй ажил нь хүүхдэд бие болон сэтгэлийн дарамт учруулдаг эсэх, шөнө, оройн цагаар ажилладаг эсэх, хэр олон удаа ажилладаг, хүүхэд ажлаасаа болж өвдөж гэмтсэн эсэх, ямар өвчин гэмтэл авсан, олсон орлогоо юунд зарцуулдаг, өдөрт өөрт нь чөлөөт цаг гардаг эсэх)

ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр (ХХУОУХ)-ийн газрын захиалгын дагуу хүүхдийн хөдөлмөрийн хавсарга судалгаа явуулж байгаа тул олон улсын стандартын дагуу АХС-ны асуулга авах өрхийн гишүүдийн насны доод хязгаарыг 5 насаар тогтоосон болно.

Энэ судалгааг зохион байгуулан явуулах ажлын хэсэг нь асуулгын хуудас, зааврыг боловсруулахдаа НХХЯ, БСШУЯ, АОЭХ, МҮЭХ, ОУХБ болон ТББ, ОУБ-уудтай зөвшилцөх, саналыг нь авах, турших замаар асуулгыг хэд хэдэн удаа шинэчлэн боловсронгуй болгож эцэслэн, ҮСГ-ын даргын 2006 оны 6-р сарын 28-ны өдрийн 01/69 тоот тушаалаар батлуулсан болно. Асуулгын маягыг энэхүү тайланд хавсаргав.

Улсын хэмжээнд энэхүү судалгааг чанартай явуулах зорилгоор 2006 оны 6 дугаар сарын 28-наас 30-ны өдрүүдэд судалгааны ахлагч, тоологч нарт зориулсан нийт 60 хүн оролцсон сургалтыг ажлын хэсгийн зүгээс төвлөрсөн хэлбэрээр зохион байгуулсан. Энэхүү сургалтын үеэр аймаг, нийслэлийн ажиллах хүчний судалгааны ахлагч, тоологч, шивэгч нарыг судалгааны бөглөгдсөн асуулгыг кодлох, компьютерт шивэх дадлага хийлгэж, үр дүнг хэлэлцүүлэн тодруулга,

тайлбар хийсэн. Түүнчлэн ахлагч, тоологч нарыг сургалтын үеэр болон судалгааны мэдээлэл цуглуулах ажилд шаардагдах гарын авлагаар хангасан.

Судалгааны тоологч, ахлагч нар сонгогдсон өрхүүдэд очиж 5 ба түүнээс дээш насны гишүүн бүртэй нэг бүрчлэн уулзаж ярилцлага хийх замаар мэдээллээ цуглуулсан. Судалгааны нэгдүгээр улирлын мэдээллийг цуглуулах ажил 2006 оны 7-9 сард, хоёрдугаар улирлынх 2006 оны 10-12 сард, гуравдугаар улирлынх 2007 оны 1-3 сард, дөрөвдүгээр улирлынх 2007 оны 4-6 сард хийгдэж дууссан. Монгол Улсад хүн амын шилжих хөдөлгөөн их байгааг харгалзан судалгаа авах үеэр өрх эзгүй байх тохиолдолд судалгаанд сонгогдсон өрхөө бүрэн хамруулахын тулд тухайн өрхөд 2-3 удаа дахин очиж, судалгаанд хамруулах ажилд хяналт тавьж ажиллав. Үүний дүнд нийт 4 улирлын хэмжээнд 12286 өрхөөс асуулга бүрэн авч амжив. Судалгааны ажлын хэсгийн гишүүд, байгууллагын удирдлагуудаас бүрдсэн хяналтын баг АХС+ХХС-ны ажлын явцыг нийт 11 аймаг болон Улаанбаатар хотод хянаж шалган, гарсан ололт, дутагдлыг тухай бүр нь танилцуулж, шаардлагатай арга хэмжээ авч ажилласан.

#### **3.4. Мэдээлэл боловсруулалт**

АХС болон ХХС-ны мэдээлэл боловсруулах ажлыг 2 үе шаттайгаар явуулсан. Судалгааны асуулгын загвар болон мэдээллийг компьютерт бэлтгэн оруулах, бүрдэлтийг шалган хүлээн авах, хянах, засварлах, боловсруулах, нэгдсэн үр дүнг гарган авах ажлуудыг ҮСГ-т, харин өрхөөс ярилцлага авч, цуглуулсан мэдээллийг зааврын дагуу шалгаж, кодлон компьютерт шивж оруулах, шалгах, засварлан төвд дамжуулах ажлыг аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын ажиллах хүчний судалгааны баг хийж гүйцэтгэсэн.

Тооллого, судалгааны мэдээлэл боловсруулдаг CSP<sup>®</sup>3.1 багц программаар АХС+ХХС-ны мэдээллийг компьютерт шивж оруулах, шалгах, засварлах програмыг хийж, бэлэн болсон мэдээллийн үр дүнг боловсруулж нэгтгэлийн хүснэгт гаргахдаа SPSS13.0 програмыг ашигласан. Судалгааны мэдээллийг боловсруулж дууссаны дараа ажлын хэсэг ОУ-ын зөвлөхийн хамт тодорхой үзүүлэлтүүд дээр статистикийн дүн шинжилгээ хийж, судалгааны боловсруулалтын үр дүнг хянах, илэрсэн алдааг засварласны үндсэн дээр судалгааны үр дүнгийн хүснэгтүүдийг бэлтгэн гаргаж тайлан бичихэд хэрэглэв.

### 3.5 Ойлголт, тодорхойлолт

Хүүхэд: 1989 онд тунхагласан НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенцид тодорхойлсноор 18-аас доош насны хүн амыг хүүхэд гэж үзнэ. ОУХБ-аас 1999 онд баталсан Хүүхдийн Хөдөлмөрийн Тэвчишгүй Хэлбэрүүдийн тухай 182-р Конвенцэд 18 хүртэлх насны хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс хамгаалах тухай заасан байдаг. 5 хүртэлх насны хүүхэд ажил эрхлэх, сурах насанд хүрээгүй, балчир гэж нийтээр хүлээн зөвшөөрсний дагуу МХХС-нд 5-17 насны хүүхдийг хамруулсан.

Нас: Насыг тодорхойлохдоо бүтэн насаар авна. Төрсөн он, сар, өдрөөр тооцож бүтэн насыг тогтооно. Гэхдээ судалгаа авч байгаа өдрөөс буцааж тооцно.

Хүүхдийн насны бүлэг: Хүүхдийн насыг 5-9, 10-14 ба 15-17 гэж бүлэглэв.

Ажил/Эдийн засгийн үйл ажиллагаа: НҮБ-ын 1993 оны ҮТС-ийн хүрээнд эдийн засгийн үйл ажиллагааг тодорхойлсны дагуу цалин хөлс, ашиг орлого олох зорилгоор болон өөрсдийн хэрэглээндээ зориулан эрхэлж буй өрхийн аж ахуйн үйл ажиллагааг ажил гэж нэрлэнэ. Ажил нь цалин хөлстэй болон цалин хөлсгүй, албан болон албан бус хэлбэртэй байж болно. Жишээлбэл, өөрийн өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцож буй хүүхдийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байна гэж үзнэ. Түүнчлэн бусдын өрхийн аж ахуйд ажиллаж буй хүүхэд (гэрийн ажилд туслах зэрэг) эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу эдийн засгийн идэвхитэй гэж үзнэ. Харин өөрийн өрхөд гэрийн ажил хийхэд оролцож буй хүүхдийг эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн буюу эдийн засгийн идэвхигүй гэж үзнэ.

Эдийн засгийн бус үйл ажиллагаа: Өөрийн өрхийн гэрийн ажилд оролцож буй хүүхэд нь эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн буюу эдийн засгийн идэвхигүйд тооцогдоно. Үүнд:

- Гэр орон цэвэрлэх, хувцас бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах;
- Хувцас угаах, индүүдэх, гэр байшин, эд хогшил сэргээн засах;
- Хоол унд хийх, аяга таваг угаах;
- Хүүхэд асрах;
- Өвчтэй хүн, өндөр настангуудыг асрах
- Гэрийнхээ хэрэгцээт зүйлийг худалдаж авах, дэлгүүр явах.

Ажиллагч: Ажиллагч гэдэг нь ажиллах хүчинд хамаарагдах тухайн хугацаанд ажил, хөдөлмөр эрхэлж байгаа болон тухайн долоо хоногт ажил эрхлээгүй ч ажилтай байсан хүнийг хэлнэ. Тухайн хугацаанд (сүүлийн долоо хоногт) ямар нэг байдлаар ажил хөдөлмөр эрхэлсэн (нэг цагаас дээш хугацаагаар) хүнийг ажилтай гэнэ. Өвчлөл, гэмтэл, амралт, чөлөө, цаг агаарын таагүй байдал, ажил хаялт болон бусад шалтгаанаар түр хугацаагаар ажил эрхлэхгүй байгаа ч ажилтай, бизнес эрхэлдэг бол тухайн хүнийг ажиллагч гэж үзнэ.

Өрх: Өрх гэдэг нь байнга хамтран амьдарч, орлогоо нэгтгэн хоол хүнсээ бэлтгэж, нэг тогооноос хоол иддэг нэг буюу хэд хэдэн хүмүүсийг хэлнэ. Эдгээр хүмүүс нь хамаатан садан болон ажил олгогчтойгоо хамтран амьдардаг, цусан төрлийн хамааралгүй, гэрийн үйлчлэгч, бусад хөлсний ажилчид ч байж болно.

Өрхийн тэргүүлэгч: Өрхийн тэргүүлэгч гэдэг нь бусад гишүүд нь өрхийн тэргүүн хэмээн хүлээн зөвшөөрсөн, насанд хүрсэн, өрхийн гишүүн юм. Хэрвээ тухайн сууцанд нэгээс олон өрх амьдран сууж байвал төдий тооны өрхийн тэргүүн байна.

Судалгааны тайлант хугацаа: Судалгааны тайлант хугацаа нь 2006 оны 7-р сараас 2007 оны 6-р сарыг дуусталх хугацааг хамарна.

Хүүхдийн хөдөлмөр: ОУХБ-аас 1973 онд баталсан Ажил эрхлэх насны доод хязгаарын тухай конвенц (138)-д үндэслэн хүүхдийн хөдөлмөрийг тодорхойлно. Энэ конвенцид ажил буюу “эдийн засгийн үйл ажиллагаа” эрхлэх насны доод хязгаарыг дэлгэрэнгүй тодорхойлон заасан. МХХС-нд 5-17 насны эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу эдийн засгийн идэвхитэй хүүхдүүдийг хамруулсан. Үүнд:

- (1) 5-11 насны эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй бүх хүүхдүүд
- (2) 12-14 насны долоо хоногт 14-өөс дээш цаг ажиллаж байгаа болон аюултай ажил хийж буй хүүхдүүд
- (3) 15-17 насны долоо хоногт 43-аас дээш цаг ажиллаж байгаа болон аюултай ажил хийж буй хүүхдүүдийг хүүхдийн хөдөлмөр эрхэлж буй гэдэгт хамруулна.

Хөдөлмөр эрхэлж буй/эдийн засгийн идэвхитэй/ажиллаж буй хүүхэд: ХХС-д энэ гурван нэр томъёо ижил утгатай хэрэглэгдэж байгаа. Сүүлийн 7 хоногт нэг болон түүнээс дээш цагаар орлого олох зорилгоор бусдад хөлслөгдөн ажилласан эсхүл өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцсон, мөн ажлын байртай боловч сүүлийн 7 хоногт ажиллаагүй хүүхдийг тухайн үед ажил эрхэлсэн гэж үзнэ.

Эдийн засгийн идэвхигүй хүүхэд: Эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй, зөвхөн гэрийн ажилд оролцож тусалсан хүүхдийг эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэн хүүхдийн хөдөлмөрийг тооцоход оруулахгүй.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч хүүхэд: Бусдын оролцоогүйгээр ашиг, орлого олох зорилгоор аж ахуй эрхлэх, эсвэл ажиллаж буй хүүхдийг хэлнэ.

Ажил олгогч: Өөрийн ажил мэргэжлээс үл хамааран нэг болон түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, хамтарсан үйлдвэрийг удирдаж байгаа хүн. Энэ судалгаанд гэрийн ажлыг бусдаар цалин хөлстэйгээр хийлгэж байгаа хүнийг ажил олгогч гэж үзнэ.

Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч: Өрхийн аж ахуйн нэгжид цалин хөлсгүйгээр нэг цагаас доошгүй ажилласан хүн. Ялангуяа хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын салбарт өрхийн аж ахуй зонхилж байдаг тул цалин хөлсгүй оролцогч их байдаг. Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон хүүхдүүдийг ажил эрхэлсэн гэж үздэг.

Ажилгүй хүн: Ажиллах хүчинд хамаарагдах тухайн хугацаанд ажил эрхлээгүй байгаа болон тухайн долоо хоногт ажил эрхлээгүй боловч ажил эрхлэхэд бэлэн байсан, ажил идэвхитэй хайсан хүнийг хэлнэ. Ажил эрхлээгүй ч ажил эрхлэх боломжтой байгаа, ажилд орох өргөдлөө өгсөн болон ярилцлаганд орохоор хүлээж байгаа хүнийг мөн ажилгүй хүн гэж тодорхойлно.

Эдийн засгийн идэвхитэй хүн ам: Ажиллагчид болон ажилгүйчүүдийн нийлбэрийг ажиллах хүч гэнэ. Ажиллах хүч нь эдийн засгийн идэвхитэй хүн амтай нэг утгатай тул энэ хоёр нэр томъёо бие биенээ орлон ашиглагдаж болно.

Хүүхдийн эдийн засгийн идэвхийн оролцооны түвшин: Эдийн засгийн идэвхитэй хүүхдийн тоог 5-17 насны нийт хүүхдийн тоонд харьцуулж гаргана.

Ажилласан цаг: Сүүлийн 7 хоногт ажилласан нийт цаг. Хүүхэд нэгээс илүү тооны ажил хийсэн бол бүх ажлыг хийхэд зарцуулсан цагийг хооронд нь нэмж нийт ажилласан цагийг тооцно.

Ажил мэргэжил: Цалин, хөлс, орлого олох зорилгоор тухайн хүний хийж гүйцэтгэж буй эдийн засгийн үйл ажиллагааны ажил, мэргэжлийн төрлийг ажил, мэргэжил гэнэ. Хэрвээ тухайн хүн ажилгүй байгаа бол эрхлэхэд бэлэн байгаа ажил, мэргэжлийн төрлийг тухайн хүний ажил, мэргэжил гэж үзнэ.

Үндсэн ажил: Тухайн хугацаанд нэгээс олон ажил цалинтай буюу хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бол нийгмийн болон хууль зүйн тал, цалин хөлсний хэмжээ, ажиллаж байгаа цагаас хамааруулан үндсэн ажлыг тодорхойлно. Хэрвээ хүүхэд нэгээс илүү ажил гүйцэтгэсэн бол хамгийн их цаг зарцуулсан ажлыг үндсэн ажилд тооцно. Хэрвээ адил хэмжээний цаг зарцуулсан бол хамгийн их орлого оруулж буй ажлыг үндсэн ажилд тооцно.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар: Тухайн хүний ажиллаж байгаа ажлын байр, үйлдвэрийн газар, байгууллагын үйлдвэрлэдэг үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр тодорхойлогдоно. Олон Улсын Стандарт Ангилал 3-т нийцүүлэн боловсруулсан “Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ыг ашигласан.

Аюултай ажил: Хүүхдийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ёс суртахуун, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх аливаа ажил, үйл ажиллагааг хэлнэ. Илүү цагаар их ачаалалтай ажиллаж байгаа бол аюултай ажил эрхэлж байна гэж үзнэ. Иймд долоо хоногт ажил эрхэлсэн 5-11 насны хүүхэд, 15-аас илүү цаг ажилласан 12-14 насны хүүхэд, 43 болон түүнээс илүү цаг ажиллаж буй 15-17 насны хүүхдийг хүнд хүчир, хортой нөхцөлд ажиллаж байгаад тооцно.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд (ХХТХ): Үүнд:

- Хүүхдийг худалдаалах, хил дамжуулан наймаалах, өрийн барьцаа болгох, албадан хүчээр хөдөлмөрлүүлэх, зэвсэгт мөргөлдөөнд ашиглах;
- Хүүхдийг, биеийг нь үнэлүүлэх, садар самуунд татан оруулах;
- Хүүхдийг хууль бус үйл ажиллагаанд татан оруулах, тухайлбал, мансууруулах бодис, хар тамхи үйлдвэрлэх, зөөвөрлөх, наймаалах.
- Мөн чанар, эсвэл хийгдэж буй нөхцлөөрөө хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлэх ажлууд /аюултай ажлууд/

## **БҮЛЭГ 4. ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

### **4.1. Нийтлэг зүйл**

Энэ бүлэгт АХС+ХХС-ны дөрвөн улирлын турш хийсэн (2006 оны 7 дугаар сараас 2007 оны 6 дугаар сарыг дуусталх) тооллогын нийт 1024 нэгжийн 12286 өрхөөс цуглуулсан мэдээлэл, түүн дээр үндэслэн тооцсон судалгааны үр дүнг танилцуулж байна. Түүвэрлэлтийн загварын дагуу тооллогын нэгж бүрээс 12 өрх, нийт 12288 өрх сонгогдож хамрагдах ёстойгоос нийт 12286 өрх хамрагдаж, хамралтын түвшин 99.9 хувьтай байна.

АХС+ХХС нь ОУХБ-аас гаргасан нийтлэг ойлголт, тодорхойлолт, арга зүйн дагуу хийгдэж байгаа ажиллах хүчний 2 дахь түүвэр судалгаа юм. ҮСХ-оос энэхүү судалгааны тоо мэдээ, үр дүнг улирал тус бүрээр болон бүтэн жилээр нэгтгэн боловсруулсан. Өөрөөр хэлбэл энэ тайлан нь улирал бүрээр болон дөрвөн улирлаар нэгтгэн боловсруулсан тоо мэдээ, үр дүнд үндэслэсэн бөгөөд тайланд зөвхөн үндсэн үр дүнг харуулсан хүснэгтүүдийг оруулсан болно.

### **4.2 Хүн ам зүйн үзүүлэлтүүд**

2006-2007 оны АХС+ХХС-гаар хүн амын тоо, насны бүлэг, хүйс, боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, бичиг үсгийн мэдлэг, өрхийн ам бүлийн тоо, гэрлэлтийн байдал гэх мэт хүн ам зүйн холбогдолтой үндсэн мэдээлэл гарч байна. Судалгаанд 2 шатат түүврийн аргыг ашиглан бүлэглэлт хийсэн тул хүн ам зүйн үзүүлэлтүүдийг дөрвөн бүс нутаг, хот, хөдөө, аймаг, нийслэлээр гэсэн ангиллаар гаргав. Хүн ам зүйн үзүүлэлтүүдийг эдгээр ангиллаар тооцон гаргахад түүврийн нийт хэмжээ хангалттай гэж үзэж, дөрвөн улирлын нэгдсэн тоонд үндэслэн дэлгэрэнгүй хүснэгтүүдийг байршил, бүсээр боловсруулан гаргав.

### **4.3 Хүн амын тоо, байршил, бүс нутгаар**

Судалгааны үр дүнг тархаасан тооцоогоор манай орны 597.2 мянган өрхөд нийт 2.415 мянган хүн ам байгаагийн дотор 6 сараас дээш хугацаагаар гэр орноосоо гадуур амьдарч байгаа хүний тоо 178.0 мянга байна. Өрхийн ам бүлийн дундаж тоо 4.0 байна. Судалгаанд хамрагдсан өрхийн хүн амыг тооцохдоо сургуулийн хүүхдийн дотуур байр, цэргийн хуаран, засан хүмүүжүүлэх газар, эмнэлэг зэрэг нийтийн байранд амьдрагчдыг хамруулаагүй болно. Өрхийн хүн амын тоог байршил, бүсээр Хүснэгт 2-д харуулав. Нийт хүн амын 57.5 хувь буюу

1,388 мянган хүн хотод амьдарч байна. Хөдөөгийн өрхийн ам бүлийн дундаж тоо хотынхоос өндөр буюу 4.1 байна. Нийт өрхийн 35 орчим хувь нь Улаанбаатар хотод байгаа бөгөөд нийслэлийн өрхийн ам бүлийн дундаж тоо улсын дундажтай адилхан байна. Хүн амын суурьшлыг бүс нутгаар авч үзэхэд харилцан адилгүй байгаа бөгөөд зүүн бүсэд хамгийн бага, тухайлбал нийт хүн амын 8.3 хувь нь амьдарч байна.

### Хүснэгт 2. Өрх, хүн амын тоо, хот хөдөө, бүсээр

Байршил/ Бүс	Өрх		Хүн ам		Нийт хүн ам		Өрхийн ам бүлийн дундаж тоо
	Тоо	%	Тоо	Тоо	Тоо	%	
Хот	345528	57.9	1310504	78174	1388678	57.5	4.0
Хөдөө	251690	42.1	926828	99830	1026658	42.5	4.1
Төв	104707	17.5	378675	29504	408179	16.9	3.9
Зүүн	49420	8.3	183505	4078	187583	7.8	3.8
Баруун	96261	16.1	384301	45315	429616	17.8	4.5
Хангай	140989	23.6	522079	53518	575597	23.8	4.1
Улаанбаатар	205842	34.5	768771	45589	814360	33.7	4.0
<b>Дүн</b>	<b>597218</b>	<b>100.0</b>	<b>2237332</b>	<b>178004</b>	<b>2415335</b>	<b>100.0</b>	4.0

Засаг захиргааны нэгжээс гаргуулан авдаг хүн амын ажил эрхлэлтийн 2007 оны жилийн эцсийн тайлангийн дүнгээр суурин хүн амын тоо 2,602 мянга байна.

АХС-нд нийтийн байранд амьдрагчид болон 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа өрхийн гишүүдийг хамруулаагүй болно. 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур байгаа гишүүдийн тоог хот, хөдөө, бүсээр нь гаргаж Хүснэгт 3-д үзүүлэв.

Тухайн өрхийн гишүүн боловч 6 сараас дээш хугацаагаар эзгүй байсан өрхийн гишүүд нийт хүн амын 7.4 хувийг эзэлж байгаа бөгөөд эдгээр хүмүүсийг судалгаанд хамруулах эсэхээс хамаарч нийт хүн амын тоо болон өрхийн ам бүлийн дундаж тоог газар зүйн байршлаар тооцож гаргасан нь үр дүнд нөлөөлж байна. Ямар нэг сургууль, курст суралцан өрхөөс гадуур амьдарч байгаа хүн 116404 байхад ажил эрхлэн өрхөөс гадуур амьдарч байгаа хүн 40995 байна. Судалгаагаар 6 сараас дээш хугацаагаар эзгүй байсан өрхийн гишүүдийн талаарх мэдээллийг цуглуулаагүй болно.

Иймээс судалгааны тайланд орсон хүснэгтүүд нь өрхөөс гадуур амьдарч байгаа цэрэг, хоригдол, дотуур байранд амьдарч байгаа хүмүүс, 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа өрхийн гишүүдийг оруулахгүйгээр тооцсон хүн амын тоонд үндэслэн хийгдсэн болно. Үүнийг судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийхдээ анхаарах шаардлагатай.



**Хүснэгт 3. 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур байгаа гишүүдтэй өрхийн тоо, хот, хөдөө, бүсээр**

Хот, хөдөө/ Бүс	Өрхийн тоо	Өрхийн гишүүдийн тоо	Өрхөөс гадуур амьдарч байгаа хүний тоо	Үүнээс:		
				Суралцаж байгаа	Ажиллаж байгаа	Бусад
Хот	38042	99518	78174	38228	26219	13727
Хөдөө	55701	136786	99830	78176	14775	6818
Төв	18122	45279	29504	20542	5633	3328
Зүүн	2436	6675	4078	1908	1567	603
Баруун	25663	65686	45315	35980	7410	1924
Хангай	30299	76007	53518	41688	7811	4019
Улаанбаатар	17223	42657	45589	16286	18573	10731
<b>Дүн</b>	<b>93744</b>	<b>236304</b>	<b>178004</b>	<b>116404</b>	<b>40995</b>	<b>20606</b>

Хүснэгт 4-д судалгаанд хамрагдсан хүн амын тоог бүс нутаг, хот, хөдөөгөөр харуулав.


**Хүснэгт 4. Өрх, хүн амын тоо, хот, хөдөө, бүсээр**

Байршил/ Бүс	Өрх		Өрхийн ам бүлийн дундаж тоо	Хүн ам		Эрэгтэй %	Эмэгтэй %
	Тоо	%		Тоо	%		
Хот	345528	57.9	4.0	1310504	100.0	47.8	52.2
Хөдөө	251690	42.1	4.1	926828	100.0	50.6	49.4
Төв	104707	17.5	3.9	378675	100.0	49.5	50.5
Зүүн	49420	8.3	3.8	183505	100.0	49.9	50.1
Баруун	96261	16.1	4.5	384301	100.0	49.6	50.4
Хангай	140989	23.6	4.1	522079	100.0	49.9	50.1
Улаанбаатар	205842	34.5	4.0	768771	100.0	47.6	52.4
<b>Улсын дүн</b>	<b>597218</b>	<b>100</b>	<b>4.0</b>	<b>2237332</b>	<b>100.0</b>	<b>49.0</b>	<b>51.0</b>

**4.4 Хүн амын нас, хүйсийн бүтэц**

Нийт хүн амын дотор 0-14 насны хүүхэд 27.8 хувийг эзэлж байгаа бөгөөд хүйсээр нь авч үзэхэд эрэгтэйчүүдийн 29.4 хувь, эмэгтэйчүүдийн 26.3 хувь нь энэ насны бүлэгт хамрагдаж байна. Зураг 1-д хүн амын насны бүтцийг хүн ам, орон сууцны 2000 оны тооллого болон АХС-ны дүнгүүдээр харьцуулан харуулав.

Зураг 1. Хүн амын насны бүтэц, 2000 оны ХАОСТ, АХС-ны дүнгүүдээр



Судалгаагаар нийт хүн амын 68.4 хувийг 15-64 насны хүн ам, 3.8 хувийг 65 ба түүнээс дээш насны хүн ам тус тус эзэлж байна.

#### 4.5 Хүн ам зүйн ачаалал

Хүн ам зүйн ачааллыг тооцохдоо 15 хүртэлх насны хүүхэд болон 65 ба түүнээс дээш насны хүн амын тооны нийлбэрийг, 15-64 насны хүн амын тоонд харьцуулж гаргах бөгөөд судалгаагаар энэ үзүүлэлт манай улсын хувьд 46.2 хувьтай гарлаа. Хүснэгт 5-д Хүн ам зүйн ачааллыг хот, хөдөө, бүсээр харуулснаас үзэхэд Улаанбаатар хотод хамгийн бага 38.4 хувь, баруун бүсэд хамгийн өндөр 57.4 хувь гарчээ. Өөрөөр хэлбэл баруун бүсийн хөдөлмөрийн насны 100 хүн тутамд ажил эрхлэх нас нь бага, эсвэл нас нь өндөр 57 хүн ногдож байна гэсэн үг юм. Өмнө дурьдсанчлан сургууль, курст суралцах зорилгоор 6 сараас дээш хугацаагаар гэр орноосоо /өрхөөс/ гадуур амьдарч байгаа 116404 залуучуудыг хамруулаагүйгээс энэ харьцаа доогуур гарсан байна.

Хүснэгт 5. Хүн ам зүйн ачааллын харьцаа, хот, хөдөө, бүсээр

Хүн ам зүйн ачаалал	Бүгд %	Хот %	Хөдөө %	Төв %	Зүүн %	Баруун %	Хангай %	УБ %
Залуу насны (0-14)	40.6	35.8	48.0	48.0	41.6	52.1	44.2	32.5
Ахимаг насны (65+)	5.6	5.6	5.6	5.6	6.7	5.3	5.0	5.9
<b>Улсын дундаж</b>	<b>46.2</b>	<b>41.4</b>	<b>53.6</b>	<b>53.6</b>	<b>48.3</b>	<b>57.4</b>	<b>49.2</b>	<b>38.4</b>

#### 4.6 Гэрлэлтийн байдал

Судалгаагаар 15 ба түүнээс дээш насны бүх хүмүүсийн гэрлэлтийн байдлыг гэрлэсэн, огт гэрлээгүй, хамт амьдардаг, тусгаарласан, салсан, бэлбэсэн гэсэн 6 бүлэгт хувааж авч үзсэн. Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 53.3 хувь нь гэрлэсэн, 34.9 хувь нь огт гэрлээгүй, 7.1 хувь нь бэлбэсэн байна.

Гэрлэлтийн мэдээллийн үнэн зөв байгаа, эсэхийг гэрлэсэн эрэгтэйчүүдийн тоо, гэрлэсэн эмэгтэйчүүдийн тоотой ойролцоо тэнцүү байдлаар нь үнэлдэг. Ингэж шалгаж үзэхэд гэр бүл болсон эрэгтэй, эмэгтэйчүүдийн тоо хот, хөдөөд адил гарч байгаа нь судалгааны энэ асуултад өгсөн хариулт үнэн бодитой болохыг харуулж байна.

#### 4.7 Өрхийн бүтэц

Хүснэгт 6-д нийт өрхийн тоог ам бүлийн тоо, хот, хөдөө, бүс нутгаар харууллаа. Судалгаагаар гарсан өрхийн ам бүлийн тоо нь түр эзгүй байсан өрхийн гишүүдийг оруулаагүйгээс шалтгаалан доогуур гарсан байна. Нийт өрхийн 7.6 хувь нь ганц бие өрх байна. Харин долоо ба түүнээс дээш ам бүлтэй өрх улсын дүнгээр 5.0 хувьтай байна. Баруун бүсэд ийм өрхийн эзлэх хувь хамгийн өндөр буюу 7.6 хувь байгаа бөгөөд энэ бүсэд өрхийн ам бүлийн дундаж тоо 4.0 байна. Өрхөөс түр эзгүй байгаа гишүүдийг оруулж тооцсоноор өрхийн ам бүлийн дундаж тоо Улаанбаатар хотод 4.0 байхад баруун бүсэд 4.5 (Хүснэгт 2-г үзнэ үү) байна.

Хүснэгт 6. Өрхийн дүнд эзлэх хувь, ам бүлийн тоо, хот, хөдөө, бүсээр

Өрхийн ам бүлийн тоо	Улсын дүн	Хот	Хөдөө	Төв	Зүүн	Баруун	Хангай	УБ
	%	%	%	%	%	%	%	%
1	7.6	6.6	9.0	9.1	8.7	5.6	8.2	7.1
2-3	37.0	37.1	36.7	37.2	35.2	33.7	37.7	38.2
4-6	50.4	51.0	49.6	49.9	51.8	53.1	49.3	49.8
7+	5.0	5.3	4.6	3.8	4.3	7.6	4.8	4.8
<b>Дүн, %</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тоо</b>	<b>597218</b>	<b>345528</b>	<b>251690</b>	<b>114700</b>	<b>48500</b>	<b>97900</b>	<b>138900</b>	<b>168800</b>
Түр эзгүй байгаа хүнийг оруулаагүй өрхийн ам бүлийн дундаж тоо	3.7	3.8	3.7	3.6	3.7	4.0	3.7	3.7

#### 4.8 Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх

Судалгааны үр дүнгээр таван өрхийн нэг нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байгаа бөгөөд энэ харьцаа хөдөөд буурч 14.5 хувь болж байна. Хүснэгт 7-д эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийг ам бүлийн тоо болон хот, хөдөөгөөр харууллаа.

Ер нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүд гол төлөв цөөхөн ам бүлтэй байна. Өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь багасч байна. Тухайлбал ганц бие өрхийн 47.2 хувийг эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эзэлж байхад, 2-3 ам бүлтэй өрхийн 27.5 хувь, 4-6 ам бүлтэй өрхийн 12.3 хувь, 7-оос дээш ам бүлтэй өрхийн 11.3 хувийг эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эзэлж байна.

Хүснэгт 7. Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь, ам бүлийн тоогоор

Өрхийн ам бүлийн тоо	Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх		
	Бүгд	Хот	Хөдөө
	%	%	%
1	47.2	54.2	40.2
2-3	27.5	33.7	19.0
4-6	12.3	15.7	7.4
7+	11.3	15.4	4.9
<b>Улсын дундаж, %</b>	<b>20.5</b>	<b>24.9</b>	<b>14.5</b>

#### 4.9 Боловсролын түвшин

Судалгаагаар хүн амын эзэмшсэн боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, бичиг үсгийн мэдлэгийн талаархи мэдээллийг цуглуулсан. 15 ба түүнээс дээш насны хүмүүсийн эзэмшсэн боловсролын түвшинг хүснэгт 8-д харуулав. Хүснэгтээс харахад хот, хөдөөгийн алинд ч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эзэмшсэн боловсролын түвшин бараг ойролцоо, гэхдээ эмэгтэйчүүдийнх эрэгтэйчүүдийнхээс арай дээгүүр байна. Хүснэгт 8-д эрэгтэйчүүдийн 4.0 хувь, эмэгтэйчүүдийн 3.9 хувь нь боловсролгүй, эрэгтэйчүүдийн 14.1 хувь, эмэгтэйчүүдийн 13.1 хувь нь бага боловсролтой байна.

Хөдөөд энэ харьцаа нилээд өндөр буюу 7.4 хувь нь боловсролгүй, 21-24 хувь нь бага боловсрол эзэмшсэн байна.

Хотын хүн амын бараг 14.0 хувь нь бакалаврын болон магистрийн цол эзэмшсэн байхад энэ нь хөдөөд 4.0 хүрэхгүй хувьтай байна. Хүн амын боловсролын түвшинг хот, хөдөөгөөр харьцуулж үзэхэд хөдөөд доогуур гарч байна.

**Хүснэгт 8. 15, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хот, хөдөө, хүйс, дүнд эзлэх хувиар**

Боловсролын түвшин	Бүгд			Хот		Хөдөө	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
	%	%	%	%	%	%	%
Боловсролгүй	3.9	4.0	3.9	1.6	1.7	7.5	7.4
Бага	13.6	14.1	13.1	7.2	7.9	24.0	21.6
Бүрэн бус дунд	26.2	28.7	23.8	22.1	18.4	38.0	32.9
Бүрэн дунд	29.6	28.8	30.3	36.3	35.1	18.2	22.4
Мэргэжлийн анхан шатны	5.9	6.4	5.4	7.2	6.0	5.2	4.4
Тусгай мэргэжлийн/ бүрэн бус дээд	10.6	8.9	12.2	12.1	15.3	4.3	7.1
Дээд	10.2	9.1	11.3	13.5	15.7	2.8	4.1
<b>Дүн, %</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>15, түүнээс дээш насны хүн амын тоо</b>	<b>1615485</b>	<b>773681</b>	<b>841804</b>	<b>454392</b>	<b>524040</b>	<b>319289</b>	<b>317765</b>

#### 4.10 Сургуульд хамрагдалт

Судалгааны үр дүнгээр 7-19 насны хүн амын 85.2 хувь нь, үүнээс эрэгтэйчүүдийн 83.4 хувь, эмэгтэйчүүдийн 87.2 хувь нь сургуульд суралцаж байна.

**Хүснэгт 9. 7-19 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин, хот, хөдөө, хүйсээр**

Бүтэн нас	Одоогоор сургуульд сурч байгаа								
	Улсын дүн			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
%	%	%	%	%	%	%	%	%	%
7	78.3	77.1	79.5	85.0	86.9	83.3	71.0	68.0	74.8
8	95.3	94.1	96.6	96.3	94.8	97.7	94.2	93.6	95.1
9	96.1	95.2	97.1	97.6	97.3	97.9	94.4	92.6	96.2
10	97.5	97.9	97.1	98.4	98.3	98.5	96.5	97.4	95.7
11	96.0	95.8	96.2	96.8	95.7	98.1	95.0	95.8	94.2
12	94.2	91.4	97.2	95.1	92.4	98.1	93.1	90.1	96.1
13	95.3	94.4	96.4	97.9	98.2	97.7	91.9	89.7	94.8
14	93.7	92.5	95.0	97.2	96.6	97.8	88.2	86.5	90.4
15	89.7	87.5	91.8	94.6	93.3	96.0	81.5	78.4	84.8
16	86.7	83.4	90.4	94.4	94.0	94.7	73.9	67.2	82.2
17	79.7	74.6	85.6	89.3	85.4	93.6	64.6	59.2	71.7
18	62.2	58.8	65.5	73.5	71.9	75.1	41.2	35.8	46.9
19	49.1	43.6	54.0	62.9	60.3	65.0	26.3	18.9	33.8
07-19 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь	<b>85.2</b>	<b>83.4</b>	<b>87.2</b>	<b>90.1</b>	<b>89.4</b>	<b>90.9</b>	<b>78.3</b>	<b>75.4</b>	<b>81.6</b>
<b>Сургуульд хамрагдсан хүүхдийн тоо</b>	<b>547010</b>	<b>278260</b>	<b>268751</b>	<b>337591</b>	<b>170626</b>	<b>166964</b>	<b>209420</b>	<b>107633</b>	<b>101787</b>
<b>Нийт хүн ам</b>	<b>641964</b>	<b>333638</b>	<b>308326</b>	<b>374538</b>	<b>190943</b>	<b>183595</b>	<b>267426</b>	<b>142695</b>	<b>124731</b>

Сургуулийн насанд хүрсэн хүүхдүүд сургуульд оройтож орж байгаа нь сургуульд хамрагдалтын түвшинг бууруулахад нөлөөлж байгааг Хүснэгт 9-өөс үзэж болно Хот, хөдөөгийн алинд ч охидын сургуульд хамрагдалтын хувь хөвгүүдийнхээс дээгүүр хэвээр байна.

Хөдөөд анх сургуульд орохоос эхлэн сургууль төгсөх хүртэлх тухайлбал 10-11 наснаас бусад бүх шатанд охидын сургуульд хамрагдалтын түвшин хөвгүүдийнхээс өндөр байна. Ялангуяа хөдөөгийн өсвөр насны охидын сургуульд хамрагдалтын түвшин мөн насны хөвгүүдийнхээс дээгүүр байгаа нь бусад хөгжиж буй орнуудаас нэлээд ялгаатай байна. Хөдөөд мал аж ахуйд туслах зорилгоор хөвгүүд сургууль завсардаж, мөн боловсрол эзэмшсэн залуучууд ажил олоход хэцүү болж байгаа зэрэг нь сургуульд хамрагдалтын түвшинд нөлөөлж байгаа юм.

#### **4.11 Бичиг үсгийн мэдлэгийн түвшин**

Судалгаагаар бичиг үсэг мэддэг эсэхийг тодорхойлохын тулд энгийн захиа уншиж бичиж чадах уу гэж асуусан. Энгийн бичиг захиаг уншиж, бичиж чадаж байвал бичиг үсэгт тайлагдсанд тооцсон. Харин зөвхөн өөрийнхөө нэрийг унших эсвэл тоо уншиж чаддаг боловч бичиж чаддаггүй бол тэр хүнийг бичиг үсэгт тайлагдсанд тооцоогүй. Насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдалтын хувийг тодорхойлохдоо 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын дотор энгийн бичиг захиа уншиж, бичиж чаддаг хүний эзлэх хувиар тооцлоо. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшин 97.8 хувь гарсан бол энэ удаагийн судалгаагаар эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин ойролцоо 98.6 хувьтай байна. Хөдөөд бичиг үсгийн мэдлэгийн түвшин 97,5 хувь байхад хотод үүнээс 2.5 пунктээр дээгүүр байна. 64 хүртэлх насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин 98-аас дээш хувьтай байна.

## БҮЛЭГ 5. АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ХҮҮХЭД, ТЭДНИЙ ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2006-2007 оны Хүүхдийн Хөдөлмөрийн Судалгаагаар 5-17 насны хүүхдийн эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаан дахь оролцоог тодорхойлох зорилгыг тавьсан. Судалгаагаар 5-17 насны хүүхдийг насны бүлэг, хүйс, хот, хөдөө, боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, сургуульд хамрагдаагүй шалтгаан, тэдний өрх гэр бүлийн байдал, хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн нийгэм эдийн засгийн байдал, хүүхдүүдэд чөлөөт цаг гардаг эсэх гээд ажил эрхэлж буй болон нийт хүүхэдтэй холбоотой бүхий л мэдээллийг цуглуулсан.

### 5.1 5-17 насны хүүхдийн тоо, тэдний өрх, гэр бүлийн бүтэц

Судалгааны түүврийн тархаалтын тооцоогоор 5-17 насны нийт 621612 хүүхэд байгаагийн 350472 буюу 56.4 хувь нь хот, суурин газарт, 271140 буюу 43.6 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна. Насны бүлгээр тооцвол 5-9 насны 209127 (33.6 хувь) хүүхэд, 10-14 насны 237149 (38.2 хувь) хүүхэд, 15-17 насны 175336 (28.2 хувь) хүүхэд байна. Хүснэгт 10, 10а-аас харахад 5-17 насны нийт хүүхдийн 325631 нь буюу 52.4 хувийг хөвгүүд, 295981 буюу 47.6 хувийг охид эзэлж байна.

*Хүснэгт 10. 5-17 насны хүүхдийн тоо, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр*

Насны бүлэг	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Хүн амын тоо	2,237,332	1,095,754	1,141,578	1,310,504	626,960	683,544	926,828	468,794	458,034
Насны бүлгээр									
5-9	209,127	108,089	101,039	107,999	54,140	53,860	101,128	53,949	47,179
10-14	237,149	126,485	110,664	133,880	71,928	61,952	103,268	54,556	48,712
15-17	175,336	91,058	84,278	108,592	54,749	53,843	66,744	36,309	30,435
<b>Нийт 5-17</b>	<b>621,612</b>	<b>325,631</b>	<b>295,981</b>	<b>350,472</b>	<b>180,817</b>	<b>169,655</b>	<b>271,140</b>	<b>144,815</b>	<b>126,325</b>

*Хүснэгт 10а. 5-17 насны хүүхдийн нас, хүйсийн бүтэц, хот, хөдөөгөөр*

Насны бүлэг	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
5-17 насны хүүхэд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Үүнээс:									
5-9	33.6	33.2	34.1	30.8	29.9	31.7	37.3	37.3	37.3
10-14	38.2	38.8	37.4	38.2	39.8	36.5	38.1	37.7	38.6
15-17	28.2	28.0	28.5	31.0	30.3	31.7	24.6	25.1	24.1

Хүснэгт 11-ээс харахад 2006 оны 7 сараас 2007 оны 6 сарыг дуусталх хугацаанд улс орон даяар явуулсан судалгааны дүнгээр гарсан 5-17 насны хүүхдийн тоо (насны бүлгээр) 2007 оны хүн амын жилийн эцсийн мэдээтэй ойролцоо гарчээ (Зураг 2, Хүснэгт 11).


**Хүснэгт 11. 2007 оны хүн амын жилийн эцсийн мэдээгээр гарсан хүүхдийн тоо болон судалгаагаар тооцсон хүүхдийн тоо, насны бүлгээр**

Насны бүлэг	2007 оны эцэст	Үүнээс:	
		Нийт хүн амд эзлэх хувь	2006-2007 оны Хүүхдийн хөдөлмөрийн судалгаагаар*
Нийт хүн ам	2,635,169		2,237,332
Үүнээс:			
5-9	248,266	9.6	209,127
10-14	270,701	10.4	237,149
15-17	187,083	7.2	175,336
<b>5-17 насны хүүхэд</b>	<b>706,050</b>	<b>27.2</b>	<b>621,612</b>

\* 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа хүүхдүүд ороогүй тоо

Дээрх хүснэгтэд 5-17 насны хүүхдийн нийт хүн амд эзлэх хувь бараг ижил гарсан байна. Гэхдээ энэ судалгаа нь өрхөд суурилсан судалгаа тул өрхөөс гадуур амьдарч (өрхөөсөө гадуур ажил хийдэг, дотуур байр, болон бусад газарт) байгаа хүүхдүүд болон орон гэргүй, хараа хяналтгүй хүүхдүүдийг хамруулаагүйгээс шалтгаалан 5-17 насны хүүхдийн тоо буурч гарсан байна. Иймээс эдгээр хүүхдүүд нийт хүүхдийн тоо болон судалгааны бусад тооцоонд ороогүй болно.

**Зураг 2. 5-17 насны хүүхдийн тоо, 2007 оны хүн амын жилийн эцсийн мэдээ болон Хүүхдийн хөдөлмөрийн судалгааны дүнгээр**





Судалгаагаар 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч буй 5-17 насны хүүхдийн талаарх тоо мэдээ, ямар шалтгаанаар өрхөөс гадуур амьдарч байгааг тодорхойлсон (Хүснэгт 12). Нийт 58201 хүүхэд өрхөөс гадуур амьдарч байгаа нь судалгаанд хамрагдсан энэ насны 621612 хүүхдийн 9.4 хувьтай тэнцэж байгаа юм.

**Хүснэгт 12. 5-17 насны өрхөөс гадуур амьдарч буй хүүхдийн тоо, хот, хөдөөгөөр**

Шалтгаан	Бүгд	Үүнээс	
		Хот	Хөдөө
Суралцаж байгаа	54,271	10,786	43,485
Ажил хийж байгаа	1,363	504	859
Бусад	2,567	1,713	854
<b>Нийт 5-17</b>	<b>58,201</b>	<b>13,003</b>	<b>45,198</b>
<b>Дүнд эзлэх хувь</b>			
Суралцаж байгаа	100.0	19.9	80.1
Ажил хийж байгаа	100.0	37.0	63.0
Бусад	100.0	66.7	33.3
<b>Нийт 5-17</b>	<b>100.0</b>	<b>22.3</b>	<b>77.7</b>
Суралцаж байгаа	93.2	83.0	96.2
Ажил хийж байгаа	2.3	3.9	1.9
Бусад	4.4	13.2	1.9
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Хүснэгт 12-оос харахад 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч буй хүүхдийн дийлэнх нь буюу 80.1 хувь нь хөдөө, орон нутгийн хүүхдүүд байгаа ба тэдний 96.2 хувь нь сурч, боловсрохын тулд өрхөөсөө гадуур амьдардаг байна. Энэ хандлага нь нийт хүүхдүүдийн хувьд нийтлэг харагдаж байна. Хөдөөд өрхөөс гадуур амьдарч байгаа хүүхдийн тоо ийнхүү өндөр байгаа нь сургууль хүрэлцэхгүй, хол байгаатай холбоотой юм. Харин хот, суурин газрын хүүхдийн өрхөөс гадуур амьдарч байгаа үндсэн шалтгаан нь суралцахтай холбоотой байгаа бөгөөд энэ шалтгаан нь 83.0 хувьтай байна. Өрхөөс гадуур амьдарч буй хот, суурин газрын хүүхдийн 3.9 хувь нь ажиллаж, харин 13.2 хувь нь суралцах эсвэл ажиллах зорилгогүй, улмаар шалтгаан нь тодорхой бус байгаа нь нилээд сонирхол татаж байгаа бөгөөд гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй юм.


Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн өрх гэр бүлийн бүтцийг Хүснэгт 13-аас харахад нийт хүүхдийн 16.2 хувь буюу 100418 нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд амьдарч байна. Энэ байдал нь бүсүүдийн хувьд ерөнхийдөө хадгалагдаж байгаа боловч төвийн бүс болон Улаанбаатар хотод нилээд их буюу 18.3-24.3 хувьтай

гарчээ. Харин баруун бүсийн хувьд нилээд нааштай буюу 8.1 хувьтай байна. Хот, хөдөөний хувьд өрх толгойлсон эмэгтэйчүүдийн харьцаа нилээд зөрөөтэй гарчээ (Зураг 3). Хөдөөд таван өрх тутмын нэг нь эмэгтэй тэргүүлэгчтэй байхад хөдөөд арван өрхийн нэг нь эмэгтэй тэргүүлэгчтэй байна.

**Хүснэгт 13. 5-17 насны хүүхэд, өрхийн тэргүүлэгч, өрхийн ам бүлийн тоогоор, хувиар**

Байршил, бүс	Бүгд	Өрхийн тэргүүлэгчээр		Өрхийн ам бүлийн тоогоор		
		Эрэгтэй тэргүүлэгчтэй	Эмэгтэй тэргүүлэгчтэй	1-3	4-6	7-оос дээш
Хот	100.0	79.3	20.7	16.9	71.4	11.7
Хөдөө	100.0	89.7	10.3	12.4	74.1	13.5
<b>Бүс</b>						
Баруун	100.0	91.9	8.1	9.2	70.6	20.3
Хангай	100.0	88.2	11.8	13.7	74.5	11.8
Төв	100.0	81.7	18.3	16.4	74.3	9.3
Зүүн	100.0	86.1	13.9	15.1	76.5	8.5
Улаанбаатар	100.0	75.7	24.3	18.8	70.2	11.0
<b>Нийт 5-17</b>	<b>100.0</b>	<b>83.8</b>	<b>16.2</b>	<b>14.9</b>	<b>72.6</b>	<b>12.5</b>

**Зураг 3. Өрхийн тэргүүлэгчийн бүтэц, хүйсээр, хот, хөдөөгөөр**



Нийт хүүхдийг өрхийн ам бүлийн тоогоор авч үзэхэд дийлэнх нь буюу 72.6 хувь нь 4-6 ам бүлтэй өрхөд амьдарч байна. Энэ харьцаа нь хот, хөдөө болон бүсийн хувьд ерөнхийдөө ойролцоо байна.

Харин баруун бүсийн хувьд 1-3 ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдийн тоо арай бага 10947 буюу 9.2 хувьтай, 7-оос дээш ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдийн

эзлэх хувь 20.3 байгаа нь бусад бүсүүдээсээ нилээд онцлогтой байна. Хот суурин газар болон хөдөөгийн хувьд өрхийн ам бүлийн тоо нэг их ялгаатай харагдахгүй байна.

#### Хүснэгт 14. 5-17 насны хүүхэд, хот, хөдөөгөөр, бүсээр

Байршил, бүс	Бүгд	Өрхийн тэргүүлэгчээр		Өрхийн ам бүлийн тоогоор		
		Эрэгтэй тэргүүлэгчтэй	Эмэгтэй тэргүүлэгчтэй	1-3	4-6	7-оос дээш
Хот	56.4	53.3	72.2	63.9	55.4	52.8
Хөдөө	43.6	46.7	27.8	36.1	44.6	47.2
<b>Бүс</b>						
Баруун	19.2	21.0	9.7	11.8	18.6	31.1
Хангай	25.2	26.5	18.4	23.1	25.8	23.8
Төв	17.4	16.9	19.7	19.1	17.8	13.0
Зүүн	8.4	8.7	7.2	8.5	8.9	5.7
Улаанбаатар	29.9	27.0	45.0	37.5	28.9	26.4
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Нөгөө талаас Улаанбаатар хот болон төвийн бүсийн хүүхдийн 16.4-18.8 хувь нь 1-3 ам бүлтэй айлын хүүхэд байгаа ба 7-оос дээш ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдийн хувь энэ бүсэд 9.3-11.0 хувьтай гарсан байна. Эндээс харахад цөөхөн ам бүлтэй өрх Улаанбаатар хот болон төвийн бүсэд нилээд хувийг эзэлж байна.

Хот, суурин газар болон хөдөөд амьдарч байгаа 5-17 насны хүүхдийн хувь ойролцоо гарчээ. Өрхийн тэргүүлэгчийн хамаарлаар авч үзвэл эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувьд энэ харьцаа нь ерөнхийдөө хадгалагдаж байгаа ба харин эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхөд амьдарч байгаа хүүхдийн ихэнх нь буюу 72454 (72.2 хувь) нь хотод байна.

Бүсийн хувьд ихээхэн зөрөөтэй буюу эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд амьдарч буй хүүхэд Улаанбаатар хот болон хангай, баруун бүсэд нийт хүүхдийн 19.2-29.9 хувьтай тэнцүү байхад зүүн бүсэд 8.4 хувь нь байна. 7-оос дээш ам бүлтэй өрхөд амьдарч байгаа хүүхдийн нилээд хувь буюу 31.1 хувийг баруун бүсийнхэн эзэлж байна. Энэ харьцаа нь 1-3 ам бүлтэй өрхийн хувьд алдагдаж цөөхөн ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдийн ихэнхийг Улаанбаатар (37.5 хувь) хотынхон болон Хангайн (23.1 хувь) бүсийнхэн эзэлж байна.

#### 5.2 5-17 насны хүүхдийн сургуульд хамрагдалт, сургуульд хамрагдаагүй шалтгаан

Судалгаанд хамрагдсан 5-17 насны хүүхдүүдийг 2006-2007 онд сургууль, курст суралцаж буй эсэх мөн сургууль, курст хамрагдаж буй хүүхдүүдийн суралцаж

байгаа анги сургууль зэргийг насны бүлэг, хот, хөдөөгөөр тооцсон дүнг гаргаж Хүснэгт 15, 15а-д үзүүлэв.

**Хүснэгт 15. 5-17 насны хүүхдийн тоо, сургуульд суралцаж буй байдлаар, хот, хөдөөгөөр**

Насны бүлэг/хүйс	Нийт	Ямар нэгэн сургууль, курст сураагүй байгаа хүүхдийн тоо	Асуултанд хариулаагүй хүүхдийн тоо	Сургуулийн өмнөх/цэцэрлэг	Анги			Албан бус сургалт (алсын зайны, гэрийн сургалт г.м)	Техник мэргэжлийн анхан шатын сургууль	Тусгай мэргэжлийн дунд/ Бүрэн бус дээд, Дээд сургуульд сурч байгаа
					Бага анги	Дунд анги	Ахлах анги			
<b>Нийт хүүхэд</b>	<b>621,612</b>	<b>94,905</b>	<b>1,868</b>	<b>12,045</b>	<b>208,067</b>	<b>205,238</b>	<b>87,563</b>	<b>5,387</b>	<b>870</b>	<b>5,670</b>
Үүнээс:										
Насны бүлгээр										
5-9	209127	69,199	837	12,045	125,554	1,383	29	0	0	0
10-14	237149	7,276	479	0	81,605	143,530	3,682	127	449	0
15-17	175336	18,430	551	0	907	60,325	83,851	5,260	421	5,670
<b>Хот</b>	<b>350,472</b>	<b>34,686</b>	<b>1,128</b>	<b>8,597</b>	<b>110,351</b>	<b>127,003</b>	<b>59,778</b>	<b>3,930</b>	<b>284</b>	<b>4,715</b>
5-9	107999	29,193	527	8,597	68,670	982	29	0	0	0
10-14	133880	1,873	203	0	41,083	88,161	2,337	88	135	0
15-17	108592	3,620	398	0	598	37,859	57,412	3,842	274	4,715
<b>Хөдөө</b>	<b>271,140</b>	<b>60,218</b>	<b>739</b>	<b>3,448</b>	<b>97,716</b>	<b>78,236</b>	<b>27,785</b>	<b>1,457</b>	<b>587</b>	<b>955</b>
5-9	101128	40,006	310	3,448	56,884	401	0	0	0	0
10-14	103268	5,402	276	0	40,522	55,369	1,345	40	313	0
15-17	66744	14,810	153	0	310	22,466	26,440	1,417	194	955

**Хүснэгт 15а. 5-17 насны хүүхдийн бүтэц, сургуульд суралцаж буй байдал, хот, хөдөөгөөр, бүсээр**

Насны бүлэг/хүйс	Нийт	Ямар нэгэн сургууль, курст сураагүй байгаа хүүхдийн тоо	Асуултанд хариулаагүй хүүхдийн тоо	Сургуулийн өмнөх/цэцэрлэг	Анги			Албан бус сургалт (алсын зайны, гэрийн сургалт г.м)	Техник мэргэжлийн анхан шатын сургууль	Тусгай мэргэжлийн дунд/ Бүрэн бус дээд, Дээд сургуульд сурч байгаа
					Бага анги	Дунд анги	Ахлах анги			
<b>Нийт хүүхэд</b>	<b>100.0</b>	<b>15.3</b>	<b>0.3</b>	<b>1.9</b>	<b>33.5</b>	<b>33.0</b>	<b>14.1</b>	<b>0.9</b>	<b>0.1</b>	<b>0.9</b>
Насны бүлгээр										
5-9	100.0	33.1	0.4	5.8	60.0	0.7	0.0	0.0	0.0	0.0
10-14	100.0	3.1	0.2	0.0	34.4	60.5	1.6	0.1	0.2	0.0
15-17	100.0	10.5	0.3	0.0	0.5	34.4	47.8	3.0	0.2	3.2
<b>Хот</b>	<b>100.0</b>	<b>9.9</b>	<b>0.3</b>	<b>2.5</b>	<b>31.5</b>	<b>36.2</b>	<b>17.1</b>	<b>1.1</b>	<b>0.1</b>	<b>1.3</b>
5-9	100.0	27.0	0.5	8.0	63.6	0.9	0.0	0.0	0.0	0.0
10-14	100.0	1.4	0.2	0.0	30.7	65.9	1.7	0.1	0.1	0.0
15-17	100.0	3.3	0.4	0.0	0.6	34.9	52.9	3.5	0.1	4.3
<b>Хөдөө</b>	<b>100.0</b>	<b>22.2</b>	<b>0.3</b>	<b>1.3</b>	<b>36.0</b>	<b>28.9</b>	<b>10.2</b>	<b>0.5</b>	<b>0.2</b>	<b>0.4</b>
5-9	100.0	39.6	0.3	3.5	56.2	0.4	0.0	0.0	0.1	0.0
10-14	100.0	5.2	0.3	0.0	39.2	53.6	1.3	0.0	0.3	0.0
15-17	100.0	22.2	0.2	0.0	0.5	33.5	39.6	2.1	0.3	1.4
<b>Нийт хүүхэд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Судалгаагаар 5-17 насны нийт хүүхдийн 15.3 хувь нь судалгааны хугацаа

буюу 2006-2007 оны хооронд сургуульд сураагүй байгаагийн дийлэнх нь буюу 72.9 хувь нь 5-9 насны хүүхдүүд байгаа нь сургуульд орох насны доод хязгаар 6-7 нас байгаатай холбон үзэх хэрэгтэй.

Сургуульд сураагүй байгаа хүүхдийн дотор 10-14 насны хүүхдүүд 7.7 хувь, 15-17 насны хүүхдүүд 19.4 хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна.

Хүүхдүүдийн сургуульд хамрагдалтыг хот, хөдөөгөөр авч үзэхэд ямар нэгэн сургууль, курст сураагүй байгаа хүүхдүүд хот, суурин газрын хувьд нийт хүүхдийн 9.9 хувийг эзэлж байхад хөдөө, орон нутгийн хувьд 22.2 хувьтай байна. Мөн насны бүлгээр авч үзэхэд хотод 10-17 насныхан 15.8 хувь, хөдөөд 33.6 хувьтай байна. Эндээс дүгнэхэд хөдөөний хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын түвшин муу, анхаарал татсан асуудлын нэг болсон байна.

Эндээс сургуульд суралцаагүй байгаа хүүхдүүдийг шалтгаанаар ангилан гаргалаа. 5-17 насны нийт хүүхдийн 15.3 хувь (621612 хүүхдийн 94905) нь сүүлийн 7 хоногт сургуульд суралцаагүй байна. Хүүхдүүдийн сургууль, курст хамрагдаагүй шалтгааныг Хүснэгт 16-д харуулав. Эдгээр хүүхдийн 57.4 хувь буюу 54442 нь хөвгүүд, 42.6 хувь буюу 40463 нь охид байв. Сургуульд хамрагдаагүй хүүхдийн тоо, эзлэх хувь 5-9 насны бүлэгт 72.9 байснаа 10-14 насны бүлэгт эрс багасч, 15-17 насныхны хувьд буцаад өссөн буюу 19.4 хувь болжээ. Эндээс 10-14 насны бүлэгтэй харьцуулахад 15-17 насанд сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн эзлэх хувь эрс өсчээ.


**Хүснэгт 16. Сургууль, курст хамрагдаагүй 5-17 насны хүүхдийн тоо, шалтгаан, насны бүлэг, хүйсээр**

Насны бүлэг/ хүйс	Сургуульд хамрагдаагүй нийт хүүхэд	Сургуулийн насанд хүрээгүй	Сургууль хол	Сургууль, курст хамрагдаагүй шалтгаан							Бусад
				Хичээлийн хэрэглэл, хувцас зэрэг зардлыг гаргаж чадахгүй	Сурлага муу, сурах сонирхолгүй	Өрхийн орлогод нэмэр болох	Гэрийн ажилд туслах	Өвчтэй/ Хөгжлийн бэрхшээлтэй	Шилжиж ирсэн/ явсан		
<b>Нийт</b>	94905	65349	2546	3970	6764	5089	4793	1504	3935	954	
5-9	69199	64794	1581	616	454	104	178	217	1175	79	
10-14	7276	320	231	940	1504	879	1192	482	1589	139	
15-17	18430	236	734	2413	4806	4106	3424	805	1170	736	
<b>Эрэгтэй</b>	54442	34757	1726	2656	4631	3697	3404	724	2268	579	
5-9	37047	34253	1054	336	201	38	78	217	810	60	
10-14	4805	320	124	466	1197	643	797	173	946	139	
15-17	12590	184	548	1854	3234	3015	2528	333	512	380	
<b>Эмэгтэй</b>	40463	30592	820	1314	2133	1393	1389	780	1667	375	
5-9	32152	30541	527	281	254	66	99	0	365	19	
10-14	2471	0	107	474	307	236	395	309	644	0	
15-17	5840	51	186	559	1573	1091	895	471	658	356	

Хөвгүүдийн хувьд энэ үзүүлэлт илүү, 10-14 насанд 4805 байсан бол 15-17 насанд 12590 болж эрс нэмэгджээ. 10-14 насны охидын 2471 нь сургуульд хамрагдаагүй байхад 15-17 насанд энэ тоо 5840 болж өссөн байна.

5-17 насны 94905 хүүхэд /үүний 54442 нь эрэгтэй, 40463 нь эмэгтэй/ сургуульд суралцахгүй байгаагийн дотор 68.9 хувь буюу 65349 нь сургуулийн өмнөх насны хүүхдүүд байна. Сурлага муу, сурах сонирхолгүй 6764 хүүхэд, өрхийн орлогод нэмэр болох зорилгоор 5089 хүүхэд сургуульд хамрагдаагүй байгаа ба мөн гэрийн ажилд туслах, ном сурах бичиг, сургуулийн дүрэмт хувцас зэрэг сургалтын зардлыг төлөх чадваргүй өөрөөр хэлбэл хичээлийн хэрэглэл, хувцас зэргийн зардлыг гаргаж чадахгүй, шилжин ирсэн болон шилжиж явсны улмаас сургууль завсардсан хүүхдүүд нилээд хувь буюу 13.4 хувийг эзэлж байна. Дээрх дүнгээс харахад сурах сонирхолгүй хүүхэд сургуульд хамрагдаагүй байгаа хүүхдийн 7.1 хувийг эзэлж буй нь манай орны сургалтын систем, багш нарын заах арга, сургалтын орчин нөхцлийг өөрчлөх шаардлага байгааг харуулж байна гэж үзэж байна.


**Зураг 4. 5-17 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдаагүй шалтгаан, хувиар**



Түүнчлэн сургууль хол (2546 хүүхэд), өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэйн улмаас сургуульд яваагүй гэж хариулсан хүүхдүүд 1504, бусад шалтгаанаар 954 хүүхэд сургууль завсарджээ. Хүүхдүүдийн сургуульд хамрагдаагүйн шалтгааны бүтцийг Зураг 4-өөс харна уу.

Түүнчлэн нийт хүүхдийн аравны нэг нь (13.7 хувь) буюу 85329 нь ямар нэгэн сургууль, курст огт суралцаж байгаагүй хүүхдүүд байгаа бөгөөд тэдний дийлэнх нь 5-9 насныхан байгаа нь өмнө дурдсанаар сургуульд орох настай холбоотой юм. Харин 10-14 болон 15-17 насны хүүхдүүдийн 3.6-3.8 хувь нь сургуульд огт суралцаж байгаагүй хүүхдүүд байна (Зураг 5).

Зураг 5. Сургуульд огт суралцаж байгаагүй хүүхэд,  
насны бүлгээр



### 5.3 5-17 насны хүүхдийн эдийн засгийн идэвхийн байдал

Энэ хэсэгт 5-17 насны хүүхдийн эдийн засгийн идэвхийг тухайн үеийн (сүүлийн 7 хоногт) болон байнгын (сүүлийн 12 сард) идэвхийн байдлаар тооцож болох бөгөөд ойлгоход амар байх үүднээс энэ бүлэгт ангиллыг зөвхөн тухайн үеийн эдийн засгийн идэвхээр тооцсон. Ингээд нийт хүүхдийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн (түүнчлэн гэрийн ажил хийхэд оролцсон хүүхэд ч байж болно), зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон (эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн), зөвхөн сургуульд суралцсан, юунд ч оролцоогүй буюу эдийн засгийн идэвхгүй (өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг хүүхдүүдийг оруулан) гэсэн бүлгүүдэд болон сургуульд суралцсан, сургуульд суралцаагүй гэсэн бүлгүүдэд хуваасан.

5-17 насны нийт хүүхдийг сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн, зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон, зөвхөн сургуульд суралцсан, эдийн засгийн үйл ажиллагаа болон эдийн засгийн бус үйл ажиллагаа (гэрийн ажил)-нд оролцоогүй, мөн сургуульд сураагүй байдлаар ангилан насны бүлэг, хүйсээр тооцон гаргалаа. Тооцооноос харахад энэ насны дийлэнх хүүхэд сургуульд сурч байна.

Судалгаанд хамрагдсан 5-17 насны 621612 хүүхдээс сүүлийн 7 хоногийн байдлаар 80.9 хувь буюу 502671 нь сургуульд сурч байна.

Насны бүлгээр тооцоход сургуульд суралцаж байгаа хүүхдийн эзлэх хувь 10-14 насанд хамгийн өндөр 95.3 хувьтай байна. 15-17 насны сургуульд сурч буй хүүхдийн өөрөөр хэлбэл 149686 хүүхдийн 50.3 хувь (75.309) нь охид, 49.7 хувь (74.377) нь хөвгүүд байна.

Нийт хүүхдийн дийлэнх нь гэрийн ажилд тусалдаг байна. 5-17 насны бүх хүүхдийн 64.6 хувь, үүнээс охидын 67.3 хувь, хөвгүүдийн 62.2 хувь нь гэрийн ажилд тусалжээ. 5-17 насны нийт хүүхдийн 11.2 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаанд татагдан орсон байна. Энэ тоог хүйсээр задлан харуулбал хөвгүүдийнх өндөр буюу 13.0 хувьтай байхад охидынх 9.3 хувь байна.

Ерөнхийдөө бүх насны бүлэгт эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хөвгүүдийн тоо охидынхоос өндөр байгаа бөгөөд энэ нь 15-17 насныхны хувь нилээд өндөр гарчээ. Гэрийн ажилд оролцож буй хүүхдийн нилээд хувийг 10-14 насныхан эзэлж байна.

Сургуульд сурсан болон сураагүй гэж ангилаад, ангилал тус бүрийг дээрх ангиллын дагуу хуваан тодорхойлон гаргалаа. 5-17 насны хүүхдийн 15.0 хувь нь зөвхөн сургуульд сурч байгаа бөгөөд сургуульд (Хүснэгт 17, Хүснэгт 17а) хамрагдсан бүх хүүхдийн 18.6 хувь нь зөвхөн сургуульд сурч (эдийн засгийн ямарваа нэгэн үйл ажиллагаа эрхэлдэггүй, гэрийн ажил хийхэд оролцдоггүй), 8.7 хувь нь сурахын хажуугаар ажил эрхэлж байна.

**Хүснэгт 17. Сүүлийн 7 хоногт сургуульд сурсан болон сураагүй хүүхдийн тоо, эдийн засгийн идэвхийн байдал, хүйс, насны бүлгээр**

		Үүнээс:							
Насны бүлэг/ хүйс	Хүүхдийн тоо-бүгд	Сургуульд сурсан				Сургуульд сураагүй			
		Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн	Зөвхөн гэрийн ажилд оролцсон	Зөвхөн сурсан	Дүн	Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн	Зөвхөн гэрийн ажилд оролцсон	Алиныг нь ч хийгээгүй	Дүн
<b>Нийт</b>	621,612	43,550	365,798	93,324	502,671	26,128	35,934	56,878	118,941
5-9	209,127	9,956	76,348	40,754	127,058	7,834	22,026	52,210	82,069
10-14	237,149	20,411	169,504	36,013	225,928	4,128	5,066	2,027	11,221
15-17	175,336	13,183	119,946	16,557	149,686	14,166	8,843	2,642	25,650
<b>Эрэгтэй</b>	325,631	25,538	183,282	49,549	258,368	16,636	19,242	31,385	67,263
5-9	108,089	5,914	37,424	21,351	64,690	4,185	10,497	28,717	43,399
10-14	126,485	12,181	86,868	20,252	119,302	2,618	3,571	994	7,183
15-17	91,058	7,442	58,989	7,946	74,377	9,833	5,174	1,674	16,681
<b>Эмэгтэй</b>	295,981	18,012	182,516	43,774	244,303	9,492	16,692	25,494	51,678
5-9	101,039	4,041	38,924	19,403	62,368	3,650	11,529	23,492	38,671
10-14	110,664	8,230	82,635	15,761	106,626	1,510	1,495	1,033	4,038
15-17	84,278	5,741	60,957	8,611	75,309	4,333	3,668	968	8,969



Сургуулийн сурагчдын дийлэнх (72.8 хувь) нь сургуульд сурахын зэрэгцээ гэрийн ажилд тусалж байна.

Харин сургуульд сураагүй хүүхэд нийт хүүхдийн 19.1 хувийг эзэлж байгаа бөгөөд эдгээр хүүхдийн бараг тал нь буюу 47.8 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаанд ч оролцдоггүй, гэрийн ажил ч хийдэггүй хүүхдүүд байна. Энд зөвхөн гэрийн ажилд оролцдог хүүхэд 30.2 хувьтай байгаа бөгөөд сурахын хажуугаар гэрийн ажилд оролцдог хүүхдүүдтэй харьцуулахад бараг 2.5 дахин бага хувьтай байна. Харин сургуульд сураагүй хүүхдүүдийн нилээд хувь буюу 22.0 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцжээ.

**Хүснэгт 17а. Сүүлийн 7 хоногт сургуульд сурсан болон сураагүй хүүхэд, дүнд эзлэх хувиар**

Насны бүлэг/ хүйс	Хүүхдийн тоо-бүгд	Үүнээс:							
		Сургуульд сурсан				Сургуульд сураагүй			
		Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн	Зөвхөн гэрийн ажилд оролцсон	Зөвхөн сурсан	Дүн	Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн	Зөвхөн гэрийн ажилд оролцсон	Алиныг нь ч хийгээгүй	Дүн
<b>Нийт</b>	621,612	8.7	72.8	18.6	100.0	22.0	30.2	47.8	100.0
5-9	209,127	7.8	60.1	32.1	100.0	9.5	26.8	63.6	100.0
10-14	237,149	9.0	75.0	15.9	100.0	36.8	45.1	18.1	100.0
15-17	175,336	8.8	80.1	11.1	100.0	55.2	34.5	10.3	100.0
<b>Эрэгтэй</b>	325,631	9.9	70.9	19.2	100.0	24.7	28.6	46.7	100.0
5-9	108,089	9.1	57.9	33.0	100.0	9.6	24.2	66.2	100.0
10-14	126,485	10.2	72.8	17.0	100.0	36.4	49.7	13.8	100.0
15-17	91,058	10.0	79.3	10.7	100.0	58.9	31.0	10.0	100.0
<b>Эмэгтэй</b>	295,981	7.4	74.7	17.9	100.0	18.4	32.3	49.3	100.0
5-9	101,039	6.5	62.4	31.1	100.0	9.4	29.8	60.7	100.0
10-14	110,664	7.7	77.5	14.8	100.0	37.4	37.0	25.6	100.0
15-17	84,278	7.6	80.9	11.4	100.0	48.3	40.9	10.8	100.0

**5.4 Ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, байршил, бүсээр**

Энэ бүлэгт ажил эрхэлж буй хүүхдийн нийгэм, эдийн засгийн байдал болон өрх, гэр бүлийн байдлын талаарх зарим гол үр дүнг нарийвчлан тооцов. Судалгаагаар 5-17 насны хүүхдийг насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, боловсролын түвшингээр, гэр бүлийн байдал, сургуульд хамрагдалт, сургуульд хамрагдаагүй шалтгаан зэргээр тооцсон ба бусад дэлгэрэнгүй тоо мэдээллүүд хавсралт хүснэгтэд орсон.

Судалгаанд хамрагдсан 5-17 насны нийт хүүхдээс ажил эрхэлж буй хүүхэд 71330 буюу нийт хүүхдийн 11.5 хувьтай тэнцэж байна. Эдгээр хүүхдийн 60.3 хувь буюу 43037 нь эрэгтэй, 39.7 хувь буюу 28292 нь эмэгтэй хүүхэд байна. Насны бүлгээр авч үзвэл ажил эрхэлж буй хүүхдийн дөрөвний нэг нь буюу 25.4 хувийг 5-9 насны хүүхдүүд байгаа нь бага насны хүүхэд ихээр ажил хийж байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Энэ дүн нь хүйсийн хувьд буюу охид, хөвгүүдийн хувьд ч ойролцоо гарчээ.

**Хүснэгт 18. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр**

Насны бүлэг	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
5-9	18,116	10,332	7,784	964	388	576	17,152	9,943	7,209
10-14	25,016	14,929	10,087	2,559	1,382	1,177	22,457	13,548	8,909
15-17	28,198	17,776	10,421	4,052	2,561	1,491	24,146	15,215	8,931
<b>Дүн</b>	<b>71,330</b>	<b>43,037</b>	<b>28,292</b>	<b>7,575</b>	<b>4,331</b>	<b>3,244</b>	<b>63,755</b>	<b>38,706</b>	<b>25,049</b>

Ажил эрхэлж буй нийт хүүхдийн дийлэнх нь буюу 89.4 хувь нь хөдөө, орон нутгийн харин 10.6 хувь буюу 7575 нь хот, суурин газрын хүүхдүүд байна. Дээрх харьцаа нь насны хувьд ч хадгалагдаж байна. Харин бага насныхан буюу 5-9 насны хүүхдийн 94.7 хувь нь хөдөөгийн хүүхдүүд байна.

Ажил эрхэлж буй хүүхдийг насны ангилалаар авч үзвэл 15-17 насныхан 39.5 хувь, 10-14 насныхан 35.1 хувь, харин 5-9 насныхан 25.4 хувийг эзэлж байна. Эндээс харахад ажил хийж буй дөрвөн хүүхдийн нэг нь 5-9 насныхан байгаа нь анхаарал татаж байна. Энэ харьцаа нь хөдөөний хүүхдийн хувьд илүү өндөр гарсан байгаа нь хөдөөний хүүхдүүд мал аж ахуй болон газар тариалангийн ажилд нилээд оролцдогийг харуулж байна. Харин хот, суурин газрын хүүхдүүдийн хувьд талаас илүү хувийг нь 15-17 насныхан эзэлж байна.

**Хүснэгт 19. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, бүсээр**

Насны бүлэг	Бүгд			Бүсээр				
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
5-9	18,116	10,332	7,784	4,795	9,649	3,020	652	0
10-14	25,016	14,929	10,087	6,313	13,090	4,395	1,198	20
15-17	28,198	17,776	10,421	6,527	12,389	5,694	2,183	1,405
<b>Дүн</b>	<b>71,330</b>	<b>43,037</b>	<b>28,292</b>	<b>17,635</b>	<b>35,128</b>	<b>13,109</b>	<b>4,033</b>	<b>1,425</b>

Харин бүс нутгаар авч үзвэл ажил эрхэлж буй хүүхдийн бараг тал нь буюу 49.2 хувь нь хангайн бүсэд байхад Улаанбаатар хот болон зүүн бүсэд 2.0-5.7 хувь нь хамрагдаж байна (Хүснэгт 19, 19а). Энэ тоо нь бүс нутгийн хүн амын тоотой хамааралтай гарсан байна.

Энэ нь насны бүлгийн хувьд мөн хадгалагдаж байна. Нийт ажил эрхэлж буй хүүхдийг бүс нутгийн хувьд насны бүтцээр нь харахад баруун, хангай болон төвийн бүсийн хувьд нийт хүүхдийн 35.3-43.4 хувийг 15-17 насныхан, 33.5-37.3 хувийг 10-14 насныхан, харин 23.0-27.5 хувийг 5-9 насныхан эзэлж байхад, Улаанбаатар хот болон зүүн бүсийн хувьд өөр хандлагатай байна.

**Хүснэгт 19а. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, насны бүлэг, хүйс, бүсээр**

Насны бүлэг	Бүгд			Бүсээр				
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
5-9	100.0	57.0	43.0	26.5	53.3	16.7	3.6	0.0
10-14	100.0	59.7	40.3	25.2	52.3	17.6	4.8	0.1
15-17	100.0	63.0	37.0	23.1	43.9	20.2	7.7	5.0
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>60.3</b>	<b>39.7</b>	<b>24.7</b>	<b>49.2</b>	<b>18.4</b>	<b>5.7</b>	<b>2.0</b>

Улаанбаатар хотод ажил хийж буй 5-9 насны хүүхэд бий, гэхдээ тоо нь харьцангуй бага учир нийт тоонд эзлэх хувь нь тэг гарсан байна. Харин зүүн бүсийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн 16.2 хувь нь 5-9 насныхан байна. Мөн Улаанбаатар хотод ажил эрхэлж буй хүүхдийн 1.4 хувь нь 10-14 насныхан, ихэнхийг нь буюу 98.6 хувийг 15-17 насныхан эзэлж байна. Эндээс харахад Улаанбаатар хотод бага насны хүүхэд ажил эрхлэх нь харьцангуй нилээд бага байна гэсэн эерэг дүн харагдаж байна.

**Хүснэгт 19б. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, насны бүлэг, хүйс, бүсээр**

Насны бүлэг	Бүгд			Бүсээр				
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
5-9	25.4	24.0	27.5	27.2	27.5	23.0	16.2	0.0
10-14	35.1	34.7	35.7	35.8	37.3	33.5	29.7	1.4
15-17	39.5	41.3	36.8	37.0	35.3	43.4	54.1	98.6
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

**5.5 Ажил эрхэлж буй хүүхэд тэдний өрх, гэр бүлийн бүтэц**

Ажил эрхэлж буй нийт 71330 хүүхдүүдийн 62817 буюу ихэнх нь эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй гэрт, 8513 буюу 11.9 хувь нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй

өрхөд амьдарч байна. Харин насны бүлгийн хувьд авч үзэхэд насны бүлэг дээшлэх тусам эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийн ажил эрхэлж буй хүүхдийн тоо нэмэгдэж байна. Байршлын хувьд ч мөн энэ нь хадгалагдаж байна. Хот, хөдөөгийн хувьд энэ байдал ерөнхийдөө хадгалагдаж байна (Хүснэгт 20, 20а).

**Хүснэгт 20. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, өрхийн тэргүүлэгчийн хүйс, хот, хөдөөгөөр**

Насны бүлэг	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй тэргүүлэгчтэй	Эмэгтэй тэргүүлэгчтэй	Бүгд	Эрэгтэй тэргүүлэгчтэй	Эмэгтэй тэргүүлэгчтэй	Бүгд	Эрэгтэй тэргүүлэгчтэй	Эмэгтэй тэргүүлэгчтэй
5-9	18,116	16,390	1,727	964	838	126	17,152	15,552	1,600
10-14	25,016	22,548	2,468	2,559	1,911	648	22,457	20,637	1,820
15-17	28,198	23,879	4,318	4,051	2,432	1,619	24,146	21,447	2,699
<b>Дүн</b>	<b>71,330</b>	<b>62,817</b>	<b>8,513</b>	<b>7,575</b>	<b>5,181</b>	<b>2,393</b>	<b>63,755</b>	<b>57,635</b>	<b>6,120</b>

Харин хот, суурин газрын ажил эрхэлж буй гурван хүүхдийн нэг нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд амьдарч байгаа бол хөдөө орон нутагт арван хүүхдийн нэг нь амьдарч байна.

**Хүснэгт 20а. 5-17 насны хөдөлмөр эрхэлж буй хүүхэд, насны бүлэг, өрхийн тэргүүлэгчийн хүйс, хот, хөдөөгөөр**

Насны бүлэг	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй тэргүүлэгчтэй	Эмэгтэй тэргүүлэгчтэй	Бүгд	Эрэгтэй тэргүүлэгчтэй	Эмэгтэй тэргүүлэгчтэй	Бүгд	Эрэгтэй тэргүүлэгчтэй	Эмэгтэй тэргүүлэгчтэй
5-9	100.0	90.5	9.5	100.0	86.9	13.1	100.0	90.7	9.3
10-14	100.0	90.1	9.9	100.0	74.7	25.3	100.0	91.9	8.1
15-17	100.0	84.7	15.3	100.0	60.0	40.0	100.0	88.8	11.2
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>88.1</b>	<b>11.9</b>	<b>100.0</b>	<b>68.4</b>	<b>31.6</b>	<b>100.0</b>	<b>90.4</b>	<b>9.6</b>
5-9	25.4	26.1	20.3	12.7	16.2	5.3	26.9	27.0	26.2
10-14	35.1	35.9	29.0	33.8	36.9	27.1	35.2	35.8	29.7
15-17	39.5	38.0	50.7	53.5	46.9	67.6	37.9	37.2	44.1
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

**5.6 Ажил эрхэлж буй хүүхдүүдийн гэр бүлийн нийгэм, эдийн засгийн байдал**

Энэ хэсэгт ажил эрхэлж буй хүүхдийн нийгэм эдийн засгийн байдлыг харуулахын тулд тэдгээр хүүхдүүдийн амьдарч буй байр, сууцны төрөл, эзэмшлийн хэлбэр, өрхийн орлого зэргийг тусгалаа.

**Хүснэгт 21. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо,  
насны бүлэг, амьдарч байгаа сууцны өмчлөлийн  
хэлбэрээр**

Насны бүлэг	Ажил эрхэлж буй хүүхдийн тоо	Сууцны өмчлөл		
		Улсын	Хувийн	Байгууллагын
5-9	18,116	95	17,808	213
10-14	25,016	104	24,395	517
15-17	28,198	271	27,380	546
<b>Нийт 5-17</b>	<b>71,330</b>	<b>470</b>	<b>69,583</b>	<b>1,277</b>

Ажил эрхэлж байгаа нийт хүүхдийн ихэнх нь буюу 97.1 хувь нь хувийн байр сууцанд амьдарч байхад улсын байранд 1.0 хувь нь, байгууллагын байранд 1.9 хувь нь амьдарч байна. Харин хот суурин газар, хөдөө болон бүс нутгийн хувьд өөр байдал гарчээ.

Ажил эрхэлж буй хүүхдүүдийн амьдарч байгаа сууцны төрөл нь байршлын хувьд өөрөөр хэлбэл хотын хүүхдүүд бараг бүгдээрээ буюу 99.9 хувь нь хувийн буюу өөрийн сууцанд амьдардаг байхад хөдөөгийн хүүхдийн 2.0 хувь нь байгууллагын сууцанд, 0.7 хувь нь улсын сууцанд харин хувийн сууцанд 97.3 хувь нь амьдардаг байна

Сууцны өмчлөлийг бүс нутгаар авч үзэхэд Улаанбаатар хотын хувьд улсын болон байгууллагын сууцанд амьдардаг хүүхэд нэг ч байхгүй байхад төвийн бүсийн аймгуудын ажил эрхэлж байгаа хүүхдүүдийн 92.3 хувь нь хувийн сууцанд, 5.4 хувь нь байгууллагын сууцанд, 2.3 хувь нь улсын эзэмшлийн сууцанд амьдарч байгаа нь бусад бүсүүдээс нилээд онцлогтой харагдаж байна.

Харин баруун болон зүүн бүсийн хувьд нилээд ойролцоо дүн гарчээ.

### **5.7 Ажил эрхэлж буй хүүхдүүдийн боловсролын түвшин**

5-17 насны хүүхэд сургууль, цэцэрлэгт явж, эрүүл саруул өсч бойжин, нийгэмдээ хэрэгтэй хүн болж хөгжих ёстой. Ийм ч учраас хүүхдийн хөдөлмөрийг судлахад боловсрол маш чухал үзүүлэлтийн нэг болдог. Олон орны туршлагаас харахад сургуульд суралцах бололцоо хомс, суралцаж хөгжих гэр орны таатай нөхцөл байхгүй зэрэг нь хүүхдийн хөдөлмөр бий болж, нэмэгдэх үндсэн хүчин зүйлийн нэг болдог аж.

Энэ удаагийн судалгааны давуу тал гэвэл өмнөх судалгаа (2002-2003 оны)-тай харьцуулахад судалгаанд хамрагдсан өрхийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг оруулж өгснөөрөө нилээд ач холбогдолтой болсон. Ер нь ядуурал нь хүүхдийн хөдөлмөртэй холбоотой байдаг. Иймд өрхийн сарын орлогын мэдээнд үндэслэн ажил эрхэлж буй хүүхдүүдийг (ажил эрхлэхийн хажуугаар

сургуульд сурч буй эсвэл сураагүй) зөвхөн сургуульд сурч буй хүүхдүүдтэй харьцуулах оролдлогыг хийв. Энэ үр дүнг дараагийн буюу 6-р бүлгийн “Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдүүдийн сарын орлого” сэдэвт дэд бүлэгт тодорхой орууллаа.

Ажил эрхэлж байгаа хүүхдүүдийг боловсролын түвшин болон сургуульд суралцсан байдлаар харахад ажил эрхэлж буй нийт хүүхдийн 63.1 хувь буюу 45.0 мянган хүүхэд сургуульд сурдаг бол 14.0 хувь буюу 10.0 мянган хүүхэд огт сургуульд суралцаж байгаагүй, харин 22.9 хувь нь өмнө нь сургуульд сурч байсан байна.

Хүйсийн хувьд дээрх байдал арай өөр байдалтай харагдаж байна. Сургуульд сурч байгаа хүүхдүүд эмэгтэй хүүхдийн дунд арай их буюу 66.0 хувийг эзэлж байхад эрэгтэй хүүхдийн 61.1 хувь нь сургуульд сурч байна.

Мөн сургуульд сурч байгаагүй хүүхэд хөвгүүдийн 12.7 хувийг эзэлж байхад, охидын 6.7 хувийг хамарчээ. Эндээс харахад ажил эрхэлж буй хүүхдүүдийн дунд охидын сургуульд хамрагдалтын хувь их байгаа бөгөөд сургуульд суралцаж байгаагүй хүүхдүүдийн дунд хөвгүүдийн эзлэх хувь охидынхоос өндөр байна.

**Хүснэгт 22. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, насны бүлэг, хүйс, сургуульд суралцсан байдлаар**

Насны бүлэг/ хүйс	Бүгд		Сургуульд суралцсан байдал		
	Хувь	Тоо	Сурч байгаа	Суралцаж байсан	Суралцаж байгаагүй
<b>Нийт</b>	100.0	71,330	63.1	22.9	14.0
5-9	100.0	18,116	56.8	1.4	41.9
10-14	100.0	25,016	83.4	14.7	1.9
15-17	100.0	28,198	49.1	43.9	7.0
<b>Эрэгтэй</b>	100.0	43,037	61.1	26.2	12.7
5-9	100.0	10,332	59.5	1.6	38.9
10-14	100.0	14,929	82.5	16.0	1.5
15-17	100.0	17,776	44.1	49.1	6.7
<b>Эмэгтэй</b>	100.0	28,292	66.0	17.8	16.1
5-9	100.0	7,784	53.1	1.1	45.7
10-14	100.0	10,087	84.7	12.9	2.4
15-17	100.0	10,421	57.6	35.0	7.3
<b>Хот</b>	100.0	7,575	72.7	24.9	2.4
<b>Хөдөө</b>	100.0	63,755	61.9	22.7	15.4

Ажил эрхэлж буй хүүхдүүдийг сургуульд суралцсан байдлаар нь авч үзвэл хот, хөдөөгийн хүүхдийн хувьд нилээд ялгаа гарч байна. Өөрөөр хэлбэл хотын хүүхдүүдийн 72.7 хувь нь сурдаг байхад хөдөөний хүүхдүүдийн 61.9 хувь нь сургуульд сурч байна. Харин ажил эрхэлж буй хүүхдүүдээс сургуульд суралцаж

байгаагүй хүүхэд хот, суурин газарт 2.4 хувь байхад хөдөө, орон нутагт 15.4 хувьтай байна.

Ажил эрхэлж буй хүүхдүүдийг сургуульд суралцсан байдлаас гадна боловсролын түвшингээр авч үзэхэд нийт хүүхдийн бараг тал нь өөрөөр хэлбэл 31.3 мянга буюу 43.9 хувь нь боловсролгүй хүүхдүүд байна. Эдгээр хүүхдийн 57.6 хувь нь 9-өөс доош насныхан байгаатай холбоотой юм. Харин 15-17 насныхны дунд боловсролгүй болон бага боловсролтой хүүхдийн эзлэх хувь 46.9 байгаад анхаарал хандуулах хэрэгтэй.

**Хүснэгт 23. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, насны бүлэг, хүйс, боловсролын түвшингээр**

Насны бүлэг/ хүйс	Хүүхэд		Боловсролын түвшин					
	Хувь	Тоо	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Мэргэжлийн анхан шатны	Дипломын дээд, тусгай мэргэжлийн дунд
<b>Нийт</b>	100.0	71,330	43.9	33.8	21.0	1.1	0.1	0.1
5-9	100.0	18,116	99.6	0.4	-	-	-	-
10-14	100.0	25,016	34.4	61.8	3.8	-	-	-
15-17	100.0	28,198	16.5	30.4	49.7	2.9	0.2	0.3
<b>Эрэгтэй</b>	100.0	43,037	43.0	33.2	22.4	1.1	0.1	0.2
5-9	100.0	10,332	99.5	0.5	-	-	-	-
10-14	100.0	14,929	34.5	60.4	5.1	-	-	-
15-17	100.0	17,776	17.4	29.2	50.0	2.6	0.3	0.4
<b>Эмэгтэй</b>	100.0	28,292	45.1	34.8	18.7	1.3	-	0.0
5-9	100.0	7,784	99.7	0.3	-	-	-	-
10-14	100.0	10,087	34.3	63.9	1.8	-	-	-
15-17	100.0	10,421	14.8	32.5	49.1	3.4	-	0.1
<b>Хот</b>	100.0	7,575	23.4	37.6	34.7	4.0	0.1	0.2
<b>Хөдөө</b>	100.0	63,755	46.3	33.4	19.3	0.8	0.1	0.1

Энэ нь байдал нь хүйсийн хувьд буюу 15-17 насны охид, хөвгүүдийн нилээд ойролцоо өөрөөр хэлбэл 46.6-47.3 хувьтай байна /Хүснэгт 23, 23a/. Ажил эрхэлж буй арван хүүхэд тутмын ес нь харин боловсролгүй таван хүүхэд тутмын дөрөв нь хөдөө, орон нутагт байна.

**Хүснэгт 23а. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, насны бүлэг, хүйс, боловсролын түвшингээр**

Насны бүлэг/ хүйс	Бүгд	Боловсролын түвшин					Дипломын дээд, тусгай мэргэжлийн дунд
		Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Мэргэжлийн анхан шатны	
<b>Нийт</b>	(71,330)	(31,290)	(24,130)	(14,947)	(813)	(60)	(89)
	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
5-9	25.4	57.6	0.3	-	-	-	-
10-14	35.1	27.5	64.1	6.3	-	-	-
15-17	39.5	14.8	35.6	93.7	100.0	100.0	100.0
<b>Эрэгтэй</b>	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
5-9	24.0	55.5	0.4	-	-	-	-
10-14	34.7	27.8	63.2	7.8	-	-	-
15-17	41.3	16.7	36.4	92.2	100.0	100.0	100.0
<b>Эмэгтэй</b>	100.0	100.0	100.0	100.0	100.0	-	100.0
5-9	27.5	60.8	0.3	-	-	-	-
10-14	35.7	27.1	65.3	3.5	-	-	-
15-17	36.8	12.1	34.4	96.5	100.0	-	100.0
<b>Хот</b>	10.6	5.7	11.8	17.6	37.3	13.3	14.2
<b>Хөдөө</b>	89.4	94.3	88.2	82.4	62.7	86.7	85.8

### 5.8 Хүүхдийн чөлөөт цаг

Хүүхэд нийгмийн өв тэгш иргэн болж өсч, хөгжихөд чөлөөт цаг ихээхэн чухал үүрэгтэй. Ийм ч учраас 5-17 насны хүүхдэд өдөрт дунджаар хичнээн хэмжээний чөлөөт цаг гардаг талаар мэдээлэл цуглуулсан. Хүснэгт 24-өөс харахад судалгаанд хамрагдсан 5-17 насны хүүхдүүдийн ихэнх нь буюу 618178 (99.4 хувь) хүүхдэд нь чөлөөт цаг гардаг байна. Ийм хүүхдийн 14.1 хувь нь өдөрт 1-3 цагийг, 10.1 хувь нь 9-өөс дээш цагийг чөлөөт цагтаа зарцуулжээ. Олонх хүүхдийн (53.5 хувь) хувьд өдрийн 3-6 цаг нь чөлөөт цаг болдог байна. Үүний дараа буюу 21.9 хувь нь өдрийн 6-9 цагийг чөлөөт цагтаа зарцуулдаг гэж гарчээ. Энэ үзүүлэлт хүйсийн хувьд нэг их ялгаатай бус, харин насны бүлгүүдээр ялгаатай харагдаж байна. Насны бүлэг дээшлэх тусам өдөрт гардаг чөлөөт цаг нь багасаж байна. Ер нь бүх насныхны хувьд ихэвчлэн өдөрт 3-6 цагийг чөлөөт цагтаа зарцуулдаг байхад, 5-9 насныхны бараг 30.0 хувь нь 6-9 цагийг чөлөөт цагтаа зарцуулж, харин 15-17 насныхны 15.7 хувьд нь л ийм чөлөөт цаг гардаг байна.

Нийт хүүхдийн 0.6 хувь нь буюу 3434 нь чөлөөт цаг гардаггүй гэж хариулсан байна. 5-9 насны хүүхдийн 0.1 хувь нь чөлөөт цаг гардаггүй гэсэн байхад, 15-17 насны хүүхдийн 1.4 хувьд нь чөлөөт цаг гардаггүй ажээ.



Хүснэгт 24. Өдөрт чөлөөт цаг гардаг хүүхдийн дүнд эзлэх хувь

Насны бүлэг/ хүйс	Нийт хүүхдийн тоо	Үүнээс:		Өдөрт гардаг дундаж чөлөөт цаг					Хариулаагүй
		Чөлөөт цаг гардаггүй хүүхэд	Чөлөөт цаг гардаг хүүхэд	1-3	3-6	6-9	9-13	13+	
<b>Нийт:</b>	<b>621,612</b>	<b>0.6</b>	<b>99.4</b>	<b>14.1</b>	<b>53.5</b>	<b>21.9</b>	<b>9.3</b>	<b>0.8</b>	<b>0.3</b>
5-9	209,127	0.1	99.9	7.3	48.1	29.1	13.7	1.4	0.4
10-14	237,149	0.3	99.7	13.8	57.7	20.2	7.6	0.5	0.2
15-17	175,336	1.4	98.6	22.9	54.4	15.7	6.2	0.4	0.4
<b>Эрэгтэй</b>	<b>325,631</b>	<b>0.6</b>	<b>99.4</b>	<b>13.3</b>	<b>54.0</b>	<b>22.6</b>	<b>8.9</b>	<b>0.8</b>	<b>0.3</b>
5-7	108,089	0.1	99.9	7.0	47.3	30.5	13.4	1.3	0.5
10-14	126,485	0.4	99.6	12.3	58.7	20.6	7.6	0.5	0.3
15-17	91,058	1.5	98.5	22.3	55.5	16.0	5.4	0.5	0.2
<b>Эмэгтэй</b>	<b>295,981</b>	<b>0.5</b>	<b>99.5</b>	<b>15.1</b>	<b>53.0</b>	<b>21.2</b>	<b>9.6</b>	<b>0.8</b>	<b>0.3</b>
5-7	101,039	0.1	99.9	7.6	49.1	27.5	14.0	1.5	0.3
10-14	110,664	0.2	99.8	15.6	56.5	19.7	7.6	0.5	0.1
15-17	84,278	1.3	98.7	23.5	53.2	15.4	7.0	0.3	0.6

## БҮЛЭГ 6. АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ХҮҮХДҮҮДИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

### 6.1 Удиртгал

Судалгаагаар ажил эрхэлж байгаа буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 5-17 насны хүүхдүүдийг хүйс, байршил, насны бүлгээр (5-9, 10-14, 15-17) ангилан байнгын болон тухайн үеийн идэвхийн аргачлалаар тооцож гаргасан. 2006-2007 онд ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдүүдийн талаар дэлгэрэнгүй тооцсон дүнг энэ бүлэгт танилцуулж байна. Түүнчлэн Бүлэг 5-д дурдсанаар сургуульд хамрагдсан болон хамрагдаагүй нийт хүүхдийн дийлэнх нь гэрийн ажилд оролцож байна. Иймд энэ бүлэгт мөн хүүхдүүдийн эдийн засгийн бус үйл ажиллагааг тооцож, дүнг нь гаргаж харуулсан.

Бүлэг 5-д дурьдсанчлан эдийн засгийн идэвхийг:

- Байнгын идэвхи буюу сүүлийн 12 сарын байдлаар
- Тухайн үеийн идэвхи буюу судалгааны өмнөх сүүлийн 7 хоногийн байдлаар гэж тодорхойлно.

Ажил эрхэлж буй хүүхэд гэдэг нь ажил болон хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг хамруулсан өргөн хүрээний ойлголт юм. Хувиараа хөдөлмөр эрхэлж буй, эсвэл бусдад хөлстэй болон хөлсгүй, байнгын болон түр зуурын ажил хийж буй, хууль бусаар хөдөлмөр эрхэлж буй, албан болон албан бус секторт ажиллаж буй хүүхдүүдийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзнэ. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн гэдэг нь ажил эрхлэлтийг тооцох олон улсын жишиг ойлголт юм<sup>5</sup>.

Сургуульд сурч байгаа болон сураагүй байгаа хүүхдүүдийн эдийн засгийн идэвхийг өмнөх бүлэгт тодорхойлсон. Энэ хэсэгт тухайн үеийн болон байнгын идэвхтэй байсан хүүхдүүдийг харьцуулан бүх төрлийн эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангилал болон ажил эрхлэлтийн байдал зэргээр нарийвчлан гаргалаа.

Хүүхдийн өөрийн гэртээ хийж буй ойр зуурын (ахуйн) ажлыг эдийн засгийн үйл ажиллагаанд оруулдаггүй тул ДНБ-ийг тооцдог НҮБ-ын ҮТС-ийн 1993 оны аргачлалаар тодорхойлогдсон “үйлдвэрлэлийн хүрээ”-нд хамруулдаггүй болно. Тиймээс ажил эрхэлж буй хүүхдүүдийн тооцоонд эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүдийг хамруулаагүй болно.

<sup>5</sup> Эдийн засгийн идэвхитэй хүүхэд, ажил эрхлэлт, ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлт, Хавсралт ОУХБ, Женев хот, 1990.


Тухайн үед ажил эрхэлсэн нийт хүүхэд 71330 байгаа бөгөөд эдгээр хүүхдийн нийт хүүхдэд эзлэх дүнг насны бүлгээр нь доорх хүснэгтэд нарийвчлан гаргалаа.

**Хүснэгт 25. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйсээр**

Хүйс, насны бүлэг	Нийт хүүхэд	Ажил эрхэлж буй хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь (%)
<b>Нийт</b>	621,612	71,330	11.5
5-9	209,127	18,116	8.7
10-14	237,149	25,016	10.5
15-17	175,336	28,198	16.1
<b>Эрэгтэй</b>	325,631	43,037	13.2
5-9	108,089	10,332	9.6
10-14	126,485	14,929	11.8
15-17	91,058	17,776	19.5
<b>Эмэгтэй</b>	295,981	28,292	9.6
5-9	101,039	7,784	7.7
10-14	110,664	10,087	9.1
15-17	84,278	10,421	12.4

Хүснэгт 25-аас харахад нийт хүүхдийн 11.5 хувь нь ажил эрхэлж, харин үлдсэн 88.5 хувийг ажил эрхлээгүй буюу эдийн засгийн идэвхгүй хүүхэд эзэлж байна. 5-9 насны бүлэгт ажил эрхэлж буй хүүхдийн эзлэх хувь 8.7; 10-14 насанд 10.5 хувь; харин 15-17 насанд нэлээд өндөр 16.1 хувьтай байна.

**Зураг 6. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйсээр**



2006-2007 оны Хүүхдийн хөдөлмөрийн судалгаагаар гарсан дүнг 2002-2003 онд явагдсан Хүүхдийн хөдөлмөрийн судалгааны дүнтэй харьцуулахад ажил эрхэлж буй хүүхдийн эзлэх хувь өссөн байгаа ба мөн насны бүлгээр харахад 5-14 насныхан буюу бага насны хүүхдүүд ажил эрхлэх явдал багагүй нэмэгдсэн байна.

Өөрөөр хэлбэл 5-9 насанд 1.5 пунктээр, 10-14 насанд 3.2 пунктээр нэмэгдсэн байгаа нь анхаарал татаж байна. Харин ажил эрхэлж буй 15-17 насны хүүхдийн нийт дүнд эзлэх хувь өмнөх судалгаатай харьцуулахад 2.4 пунктээр буурчээ. Монгол Улсын хуулинд 15-16 наснаас эхлэн тодорхой хязгаарлалттайгаар эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн байдаг.

## 6.2 Хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагаа

5-17 насны ажил эрхэлж буй хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагааг байнгын болон тухайн үеийн эдийн засгийн идэвхийн байдлаар тодорхойлон дэд бүлгүүдэд ангиллаар нарийвчлан гаргалаа. Хүүхдийн хөдөлмөрийн судалгааны нэгдсэн дүнгээр тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд 71330 байна. Мөн байнгын эдийн засгийн идэвхтэй буюу байнга ажил эрхэлж буй 31051 хүүхэд байна.

## 6.3 Ажил эрхэлж буй хүүхдийн тоо, тухайн үеийн идэвхиэр

Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн тоог ажил эрхлэлтийн байдал, долоо хоногт үндсэн ажил эрхлэлтэнд зарцуулсан дундаж цагаар тооцсоноос харахад тухайн үеийн байдлаар ажил хийж байгаа нийт 71330 хүүхдийн 1652 нь ажлын байртай ч гэсэн сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй буюу ажил хийгээгүй хүүхдүүд байна.

Иймд энэ тайланд сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийж буй 69678 хүүхдийн талаарх үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй тооцож оруулсан. *Хүснэгт 26*-аас үзэхэд сүүлийн 7 хоногт ажил хийсэн 69678 хүүхдийн 1184 нь цалин хөлстэй ажил, дийлэнх болох 68494 хүүхэд хувиараа хөдөлмөр эрхэлсэн эсвэл өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй ажилласан байна. Нас болон хүйсийн бүтцээр харахад цалин хөлстэй ажил хийсэн хөвгүүдийн тоо (890) охидынхоос (294) өндөр байна. Ийм хандлага хувиараа хөдөлмөр эрхлэлт болон цалин хөлсгүй ажил хийж байгаа нийт хүүхдэд ч ажиглагдав (41283 хөвгүүд, 27210 охид). Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдийн дийлэнх (1130) нь 15-17 насныхан байна. 5-9 насны зарим хөвгүүд (15) цалин хөлстэй ажил хийсэн бол, 10-14 насны 20 охин цалин хөлстэй ажил хийсэн байна. Эндээс харахад цалин хөлстэй ажил хийсэн хүүхдүүдийн ихэнх нь 15-17 насныхан байна. Цалин хөлстэй ажил хийсэн 15-17 насны охид, хөвгүүд дунджаар 54 цагийг 7 хоногт энэ ажилдаа зарцуулсан нь ОУХБ-аас тогтоосон “Хүүхдийн хөдөлмөр” гэсэн ангилалд тооцох цагаас үлэмж дээгүүр байгаа юм<sup>6</sup>.

<sup>6</sup> Бүлэг 3.5-д байгаа ойлголт, тодорхойлолтыг үзнэ үү.

**Хүснэгт 26. Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, 7 хоногт ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйсээр**

Насны бүлэг/Хүйс	Хүүхдийн тоо-бүгд	Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн хүүхдийн тоо			Долоо хоногт үндсэн ажил эрхлэлтэнд зарцуулсан дундаж цаг	
		Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн	Цалин хөлстэй ажил эрхэлсэн	Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч	Цалин хөлстэй ажил эрхэлсэн	Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч
<b>Нийт хүүхэд</b>	<b>621,612</b>	69,678	1,184	68,494		
5-9	209,127	17,790	15	17,775	20.0	12.5
10-14	237,149	24,540	39	24,501	64.8	21.5
15-17	175,336	27,348	1,130	26,218	54.3	32.1
<b>Эрэгтэй</b>	<b>325,631</b>	42,174	890	41,283		
5-9	108,089	10,099	15	10,084	20.0	13.5
10-14	126,485	14,800	19	14,780	52.2	24.2
15-17	91,058	17,275	856	16,419	54.4	35.0
<b>Эмэгтэй</b>	<b>295,981</b>	27,504	294	27,210		
5-9	101,039	7,691	-	7,691	0.0	11.2
10-14	110,664	9,740	20	9,720	77.0	17.3
15-17	84,278	10,073	274	9,799	53.9	27.4

Түүнчлэн цалин хөлстэй ажил хийж буй насанд хүрэгчдийн долоо хоногт зарцуулж буй цагаас ч өндөр байгаа бөгөөд цалин хөлстэй ажил хийж буй 10-14 насныхан 7 хоногт 64 цаг (охид 77 цаг, хөвгүүд 52 цаг) ажилладаг гэж хариулсан тул энэ асуудал дээр маш их анхаарал хандуулах цаг болсон байна.

**Хүснэгт 27. Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, 7 хоногт ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, байршлаар**

Насны бүлэг/Хүйс	Хүүхдийн тоо	Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн хүүхдийн тоо			Долоо хоногт үндсэн ажил эрхлэлтэнд зарцуулсан дундаж цаг	
		Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн	Цалин хөлстэй ажил эрхэлсэн	Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч	Цалин хөлстэй ажил эрхэлсэн	Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч
<b>Хот</b>	<b>350,471</b>	<b>7,225</b>	<b>1,048</b>	<b>6,177</b>	<b>54.3</b>	<b>22.0</b>
Бүгд	621,612	69,678	1,184	68,494		
5-9	107,999	910	15	895	20.0	14.6
10-14	133,880	2,371	-	2,371	.	17.4
15-17	108,592	3,944	1,033	2,911	54.8	27.9
<b>Хөдөө</b>	<b>271,140</b>	<b>62,453</b>	<b>136</b>	<b>62,317</b>	<b>53.3</b>	<b>23.4</b>
5-9	101,128	16,879	-	16,879	.	12.4
10-14	103,268	22,169	39	22,130	64.8	21.9
15-17	66,744	23,405	97	23,308	48.7	32.6

Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн хүүхдийн дүнд эзлэх хувийг насны

бүлэг, хүйс, ажил эрхлэлтийн байдлаар тооцож, ажил эрхэлж буй хүүхдийн тоог хот, хөдөөгөөр *Хүснэгт 27*-д харуулав.

Нийт ажил эрхэлж буй хүүхдийн дийлэнх нь хөдөө орон нутагт (62453) байхад хот, суурин газарт ажил эрхэлж буй хүүхэд ердөө 7225 байна. Цалин хөлстэй ажил эрхэлж буй хүүхдийн ихэнх нь хот, суурин газарт байна. Хот, суурин газарт ажил эрхэлж буй хүүхдийн 14.5 хувийг цалин хөлстэй ажил эрхэлж буй хүүхэд эзэлж байхад хөдөө орон нутагт энэ үзүүлэлт 0.2 хувьтай (62453 хүүхдийн 136 нь) байна.

#### **6.4 Сургууль, боловсролоос гадуурх үйл ажиллагаанд зарцуулсан цаг**

Сургууль, боловсролоос гадуурх үйл ажиллагаанд (боловсрол, урлаг соёлын ажил, тоглоом зэрэг сургууль боловсролын үйл ажиллагааны нэг хэсгийг оруулаад):

1. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн. Үүнд:
  - а. Зөвхөн эдийн засгийн үйл ажиллагаа,
  - б. Эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаа (гэрийн ажил)
2. Зөвхөн эдийн засгийн бус үйл ажиллагаа (гэрийн ажил) зэрэг орно.

*Хүснэгт 28*-д хүүхдүүд гэрийн ажил хийхэд долоо хоногт зарцуулж буй цагийг насны бүлэг, хүйсээр харуулав. Бүх хүүхдийн талаас илүү нь (58.4 хувь) гэрийн ажил хийхэд долоо хоногт 10 хүртэлх цагийг, 10.5 хувь нь 25-аас илүү цагийг тус тус зарцуулсан байна. Энэ үзүүлэлт хүйсээр ялгаатай байгаа бөгөөд гэрийн ажил хийхэд оролцож буй охидын 12.9 хувь, хөвгүүдийн зөвхөн 8.3 хувь нь долоо хоногт 25-аас илүү цагийг зарцуулсан байна. Хүснэгтээс харахад 5-9 насны хүүхдүүд гэрийн ажилд нэлээд тусалцаж байна. Гэхдээ ийм хүүхдүүдийн 82.2 хувь нь долоо хоногт 9 хүрэхгүй цагийг гэрийн ажилд туслахад зарцуулж байна. Насны бүлэг дээшлэх тусам гэрийн ажилд туслах нь нэмэгдэж байна. Үүнд: 10-14 насны хүүхдүүдийн тавны хоёр нь (40.3 хувь), 15-17 насны хүүхдүүдийн бараг тавны гурав нь (55.3 хувь) нь долоо хоногт 10-41 цагийг гэрийн ажилд туслахад зарцуулж байна. Долоо хоногт 42 гаруй цагийг гэрийн ажил хийхэд зарцуулсан охидын тоо (5503) хөвгүүдийнхээс (4011) нилээд их байна. 10-14; 15-17 насныхан гэрийн ажлыг хийхэд нилээд олон цаг зарцуулж буй нь хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 28. Хүүхдүүдийн гэрийн ажил хийхэд долоо хоногт зарцуулсан цаг, насны бүлэг, хүйсээр

Долоо хоногт зарцуулсан цаг /хүйс	Гэрийн ажил хийхэд оролцсон хүүхэд		Насны бүлгээр					
			5-9	10-14	15-17	5-9	10-14	15-17
	Тоо	%	%			Тоо		
<b>Нийт хүүхэд</b>	464,978	100.0	100.0	100.0	100.0	113,191	197,355	154,432
5 хүртэл	135,826	29.2	57.3	25.7	13.1	64,868	50,729	20,228
5 – 9	135,739	29.2	25.5	31.9	28.4	28,901	63,046	43,793
10 – 14	76,013	16.3	9.3	17.9	19.6	10,509	35,233	30,272
15 – 24	68,347	14.7	5.4	14.6	21.6	6,130	28,799	33,419
25 – 34	30,251	6.5	1.5	6.3	10.4	1,727	12,518	16,007
35 – 41	9,287	2.0	0.5	1.5	3.7	569	3,031	5,687
42 – 48	2,868	0.6	0.2	0.5	1.1	229	949	1,690
49 – 55	2,146	0.5	0.1	0.5	0.6	149	994	1,003
56+	4,501	1.0	0.1	1.0	1.5	110	2,057	2,334
<b>Эрэгтэй</b>	240,447	100.0	100.0	100.0	100.0	56,622	103,812	80,014
5 хүртэл	78,089	32.5	59.6	29.3	17.4	33,774	30,431	13,884
5 – 9	74,971	31.2	23.7	33.0	34.1	13,397	34,281	27,294
10 – 14	37,656	15.7	9.4	16.7	18.7	5,328	17,353	14,975
15 – 24	29,710	12.4	4.5	12.7	17.4	2,572	13,180	13,958
25 – 34	12,155	5.1	1.5	5.3	7.3	845	5,491	5,819
35 – 41	3,856	1.6	0.8	1.1	2.9	434	1,122	2,300
42 – 48	1,197	0.5	0.2	0.4	0.8	124	407	666
49 – 55	1,081	0.4	0.3	0.6	0.4	149	642	290
56+	1,733	0.7	0.0	0.9	1.0	0	904	829
<b>Эмэгтэй</b>	224,531	100.0	100.0	100.0	100.0	56,569	93,543	74,419
5 хүртэл	57,737	25.7	55.0	21.7	8.5	31,094	20,298	6,344
5 – 9	60,768	27.1	27.4	30.8	22.2	15,504	28,765	16,500
10 – 14	38,358	17.1	9.2	19.1	20.6	5,181	17,880	15,297
15 – 24	38,638	17.2	6.3	16.7	26.2	3,558	15,618	19,461
25 – 34	18,097	8.1	1.6	7.5	13.7	881	7,027	10,188
35 – 41	5,431	2.4	0.2	2.0	4.6	135	1,909	3,387
42 – 48	1,671	0.7	0.2	0.6	1.4	105	541	1,024
49 – 55	1,065	0.5	0.0	0.4	1.0	0	352	713
56+	2,768	1.2	0.2	1.2	2.0	110	1,153	1,505

## 6.5 Ажил эрхэлж буй хүүхдийн тоо

### 6.5.1 Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Тухайн үед эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүдийг насны бүлэг, хүйсээр ангилан эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар тооцож доорх хүснэгтэд харуулав. Хүснэгт 29-өөс харахад ажил эрхэлж буй 5-17 насны нийт 71330 хүүхэд байгаагийн дийлэнх буюу 63428 хүүхэд хөдөө аж ахуйн салбарт ажилласан байна. Харин нийт дүнд эзлэх хувийг Хүснэгт 29а-д үзүүлээ. Ажил эрхэлсэн хүүхдүүдийн 88.9 хувь нь хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт ажиллаж байна.

**Хүснэгт 29. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар**

Үүнээс: Салбарын ангиллаар

Насны бүлэг/хүйс	Бүгд	ХАА, ан агнуур, ойн аж ахуй	Уул уурхайн олборлох аж үйлдвэр	Боловсруулах аж үйлдвэр	Цахилгаан эрчим хүч	Барилга	Бөөний болон жижиглэн худалдаа	Зочид буудал, зоогийн газар	Тээвэр, холбоо, агуулахын аж ахуй	Үл хөдлөх хөрөнгө	Төрийн захиргаа	Эрүүл мэнд	Нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуйд
<b>Нийт</b>	71,330	63,428	689	1,028	57	928	3,651	833	328	145	5	4	28	207
5-9	18,116	17,466	-	39	-	110	383	108	-	-	-	-	-	10
10-14	25,016	22,447	391	70	-	296	1,448	231	110	8	5	-	3	7
15-17	28,198	23,514	298	920	57	522	1,820	494	218	137	-	4	24	190
<b>Эрэгтэй</b>	43,037	37,813	537	697	57	597	2,246	600	209	124	5	-	11	141
5-9	10,332	10,131	-	-	-	-	151	50	-	-	-	-	-	-
10-14	14,929	13,108	258	51	-	243	1,007	206	45	-	5	-	-	7
15-17	17,776	14,574	279	646	57	354	1,088	344	164	124	-	-	11	134
<b>Эмэгтэй</b>	28,292	25,614	151	331	-	331	1,405	233	119	21	-	4	16	66
5-9	7,784	7,335	-	39	-	110	232	58	-	-	-	-	-	10
10-14	10,087	9,339	132	19	-	53	441	25	65	8	-	-	3	-
15-17	10,421	8,940	19	273	-	167	732	150	54	13	-	4	13	56

Нийт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүдийн 5.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн засвар үйлчилгээний салбарт, 1.4 хувь нь боловсруулах аж үйлдвэрт, 1.3 хувь нь барилгын салбарт, 1.2 хувь нь зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагааны салбарт, 1.0 хувь нь уул уурхайн олборлох аж үйлдвэрийн салбарт ажиллаж байна.

**Хүснэгт 29а. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн дүнд эзлэх хувь, насны бүлэг, хүйс, бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар**

Үүнээс: Салбарын ангиллаар

Насны бүлэг/хүйс	Бүгд	ХАА, ан агнуур, ойн аж ахуй	Уул уурхайн олборлох аж үйлдвэр	Боловсруулах аж үйлдвэр	Цахилгаан эрчим хүч	Барилга	Бөөний болон жижиглэн худалдаа	Зочид буудал, зоогийн газар	Тээвэр, холбоо, агуулахын аж ахуй	Үл хөдлөх хөрөнгө	Төрийн захиргаа	Эрүүл мэнд	Нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	Өөрийн өрхийн аж ахуйд
<b>Нийт</b>	100.0	88.9	1.0	1.4	0.1	1.3	5.1	1.2	0.5	0.2	0.0	0.0	0.0	0.3
5-9	100.0	96.4	0.0	0.2	0.0	0.6	2.1	0.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.1
10-14	100.0	89.7	1.6	0.3	0.0	1.2	5.8	0.9	0.4	0.0	0.0	0.0	0.0	0.0
15-17	100.0	83.4	1.1	3.3	0.2	1.8	6.5	1.8	0.8	0.5	0.0	0.0	0.1	0.7
<b>Эрэгтэй</b>	100.0	87.9	1.2	1.6	0.1	1.4	5.2	1.4	0.5	0.3	0.0	0.0	0.0	0.3
5-9	100.0	98.1	0.0	0.0	0.0	0.0	1.5	0.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
10-14	100.0	87.8	1.7	0.3	0.0	1.6	6.7	1.4	0.3	0.0	0.0	0.0	0.0	0.0
15-17	100.0	82.0	1.6	3.6	0.3	2.0	6.1	1.9	0.9	0.7	0.0	0.0	0.1	0.8
<b>Эмэгтэй</b>	100.0	90.5	0.5	1.2	0.0	1.2	5.0	0.8	0.4	0.1	0.0	0.0	0.1	0.2
5-9	100.0	94.2	0.0	0.5	0.0	1.4	3.0	0.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.1
10-14	100.0	92.6	1.3	0.2	0.0	0.5	4.4	0.3	0.6	0.1	0.0	0.0	0.0	0.0
15-17	100.0	85.8	0.2	2.6	0.0	1.6	7.0	1.4	0.5	0.1	0.0	0.0	0.1	0.5



Эндээс харахад ажил эрхэлж буй нийт хүүхдийн дийлэнх нь хөдөө аж ахуй, бөөний болон жижиглэн худалдааны салбарт ажиллаж байна. Хөдөө аж ахуйн салбарт ажиллаж буй нийт хүүхдийн 27.5 хувь буюу 17.5 мянга нь 5-9 насныхан байгаа бол, 10-14 болон 15-17 насныхан ойролцоо хувьтай байна.


**Хүснэгт 29б. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн дүнд эзлэх хувь, насны бүлэг, хүйс, бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар**

Үүнээс: Салбарын ангиллаар

Насны бүлэг/ хүйс	Бүгд	ХАА, ан агнуур, ойн аж ахуй	Уул уурхайн олборлох аж үйлдвэр	Боловсруулах аж үйлдвэр	Цахилгаан эрчим хүч	Барилга	Бөөний болон жижиглэн худалдаа	Зочид буудал, зоогийн газар	Тээвэр, холбоо, агуулахын аж ахуй	Үл хөдлөх хөрөнгө	Төрийн захиргаа	Эрүүл мэнд	Нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	Өөрийн өрхийн аж ахуйд
<b>Нийт</b>	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
5-9	25.4	27.5	0.0	3.8	0.0	11.9	10.5	12.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	4.9
10-14	35.1	35.4	56.8	6.8	0.0	31.9	39.7	27.8	33.6	5.4	100.0	0.0	12.0	3.3
15-17	39.5	37.1	43.2	89.4	100.0	56.2	49.9	59.3	66.4	94.6	0.0	100.0	88.0	91.8
<b>Эрэгтэй</b>	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	0.0	100.0	100.0
5-9	24.0	26.8	0.0	0.0	0.0	0.0	6.7	8.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
10-14	34.7	34.7	48.1	7.3	0.0	40.7	44.9	34.3	21.5	0.0	100.0	0.0	0.0	4.9
15-17	41.3	38.5	51.9	92.7	100.0	59.3	48.4	57.3	78.5	100.0	0.0	0.0	100.0	95.1
<b>Эмэгтэй</b>	100.0	100.0	100.0	100.0	0.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	0.0	100.0	100.0	100.0
5-9	27.5	28.6	0.0	11.7	0.0	33.3	16.5	24.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	15.5
10-14	35.7	36.5	87.5	5.8	0.0	16.1	31.4	10.9	54.6	38.3	0.0	0.0	20.3	0.0
15-17	36.8	34.9	12.5	82.5	0.0	50.5	52.1	64.3	45.4	61.7	0.0	100.0	79.7	84.5

Ер нь 5-9 насныхан хөдөө аж ахуй, боловсруулах аж үйлдвэр, барилга, бөөний болон жижиглэн худалдаа, зочид буудал, зоогийн газар болон өөрийн өрхийн аж ахуйд ажил эрхэлж байна. Харин цахилгаан эрчим хүч, эрүүл мэндийн салбарт ажиллаж буй хүүхдүүд бүгд 15-17 насныхан байна.

**Зураг 7. Ажил эрхэлсэн хүүхэд, бүх төрлийн эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, хувиар**



Мөн боловсруулах аж үйлдвэр, үл хөдлөх хөрөнгө, нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ болон өрхийн аж ахуйд ажиллагчдын дийлэнх буюу 88.0-94.6 хувь нь 15-17 насныхан байна.

Энэ байдал нь хүйс болон насны бүлгүүдийн хувьд онцын ялгаа байхгүй, нэг түвшинд хадгалагдаж байна. Гэвч насны бүлэг өсөх тусам хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын хувь буурч, харин бөөний болон жижиглэн худалдааны салбар, боловсруулах аж үйлдвэрийн салбар, уул уурхайн олборлох аж үйлдвэрийн салбар, зочид буудал, зоогийн газарт ажиллагчдын хувь өссөн байна. Энэ өсөлт, бууралтын харьцаа нь охид, хөвгүүдийн хувьд мөн адил хадгалагдаж байна.

### 6.5.2 Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, ажил эрхлэлтийн байдлаар

Ажил эрхэлж буй нийт хүүхдийн дийлэнх хүүхэд (90.0 орчим хувь) өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч байж, түүний дараагаар хувиараа хөдөлмөр эрхлэгчид (8.8 хувь) орж байна. Хүйсийн хувьд онцын их ялгаа ажиглагдсангүй.

Зураг 8. Ажил эрхэлсэн хүүхэд, ажил эрхлэлтийн байдлаар, хувиар



### 6.5.3 Ажил эрхэлж буй хүүхдүүд, ажил мэргэжлийн ангиллаар


Хүснэгт 30-д тухайн үед хөдөлмөр эрхэлсэн хүүхдүүдийг ажил мэргэжлийн үндсэн ангилал, насны бүлэг, хүйсээр тооцов. Дийлэнх хүүхэд (84.6 хувь) хөдөө аж ахуйн холбогдолтой ажил эрхэлж байна. Түүний дараагаар энгийн ажил (5.8 хувь) хийсэн хүүхдүүд, үйлчилгээний ажил хийсэн хүүхдүүд (5.1 хувь), үйлдвэр, худалдааны ажил (3.5 хувь) хийсэн хүүхдүүд орж байна. Хүйсээр харахад онцын ялгаа ажиглагдсангүй, харин насны бүлгээр авч үзвэл 5-9 насныхан ихэнхдээ

хөдөө аж ахуйн холбогдолтой болон үйлчилгээний төрлийн ажил эрхэлжээ. Харин бусад төрлийн ажилд ахлах насны хүүхдүүд ихээр ажиллаж байна.

**Хүснэгт 30. 5-17 насны ажил эрхэлсэн хүүхэд, насны бүлэг, хүйс, ажил мэргэжлийн ангиллаар, дүнд эзлэх хувиар**

Насны бүлэг/ хүйс	Бүгд	Үйлчилгээний ажилтан	ХАА, загасны аж ахуйн ажилтан	Үйлдвэрийн ба худалдааны ажилтан	Машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагч	Энгийн ажил мэргэжил	Бусад
<b>Нийт</b>	100.0	5.1	84.6	3.5	0.2	5.8	0.8
5-9	100.0	2.2	89.1	0.9	-	7.6	0.3
10-14	100.0	5.7	86.1	2.8	-	5.1	0.3
15-17	100.0	6.3	80.4	5.8	0.6	5.2	1.7
<b>Эрэгтэй</b>	100.0	5.3	83.8	3.5	0.4	6.0	0.9
5-9	100.0	1.3	92.8	-	-	5.6	0.3
10-14	100.0	7.0	82.6	3.7	-	6.4	0.2
15-17	100.0	6.2	79.7	5.4	0.9	6.0	1.8
<b>Эмэгтэй</b>	100.0	4.7	85.8	3.4	-	5.4	0.7
5-9	100.0	3.3	84.2	2.0	-	10.1	0.3
10-14	100.0	3.8	91.3	1.4	-	3.3	0.3
15-17	100.0	6.6	81.7	6.5	-	3.8	1.4

**Зураг 9. Ажил эрхэлсэн хүүхэд, ажил мэргэжлийн ангиллаар, хувиар**



5-17 насны ажил эрхэлсэн хүүхдийн тоог үндсэн ажлаараа ажилласан хугацаа, насны бүлэг, хүйсээр Хүснэгт 31-д, харин 31а-д энэ үзүүлэлтийг хувиар гаргаж харуулав. Зарим хүүхэд харьцангуй бага наснаас эхлэн эдийн засгийн үйл

ажиллагаанд оролцсон байна. Тухайлбал, ажил эрхэлж буй 15-17 насны хүүхдийн 5.2 хувь нь арваас дээш жил ажиллажээ. Хүйсээр онцын ялгаа ажиглагдсангүй.

**Хүснэгт 31. 5-17 насны хүүхдүүдийн үндсэн ажлаараа ажилласан хугацаа, насны бүлэг, хүйсээр**

Насны бүлэг/ хүйс	Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн	Ажилласан хугацаагаар				
		1 жил хүртэл	1-2 жил	3-4 жил	5-9 жил	10-аас дээш жил
<b>Ажил эрхэлсэн хүүхдийн тоо</b>	<b>71,330</b>	<b>48,189</b>	<b>8,044</b>	<b>7,714</b>	<b>5,702</b>	<b>1,681</b>
Үүнээс: 5-9	18,116	16,805	963	291	57	-
10-14	25,016	18,321	2,011	3,360	1,099	226
15-17	28,198	13,063	5,071	4,063	4,546	1,455
<b>Эрэгтэй</b>	<b>43,037</b>	<b>28,230</b>	<b>5,150</b>	<b>4,707</b>	<b>3,917</b>	<b>1,034</b>
5-9	10,332	9,514	544	217	57	-
10-14	14,929	10,882	1,104	2,122	794	27
15-17	17,776	7,833	3,502	2,368	3,067	1,006
<b>Эмэгтэй</b>	<b>28,292</b>	<b>19,959</b>	<b>2,894</b>	<b>3,007</b>	<b>1,785</b>	<b>648</b>
5-9	7,784	7,291	419	74	-	-
10-14	10,087	7,438	907	1,238	305	199
15-17	10,421	5,229	1,568	1,695	1,479	449

**Хүснэгт 31а. 5-17 насны хүүхдүүдийн үндсэн ажлаараа ажилласан хугацаа, насны бүлэг, хүйсээр, хувиар**

Насны бүлэг/ хүйс	Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн	Ажилласан хугацаагаар				
		1 жил хүртэл	1-2 жил	3-4 жил	5-9 жил	10-аас дээш жил
<b>Ажил эрхэлсэн хүүхдийн тоо</b>	<b>100.0</b>	<b>67.6</b>	<b>11.3</b>	<b>10.8</b>	<b>8.0</b>	<b>2.4</b>
Үүнээс: 5-9	100.0	92.8	5.3	1.6	0.3	-
10-14	100.0	73.2	8.0	13.4	4.4	0.9
15-17	100.0	46.3	18.0	14.4	16.1	5.2
<b>Эрэгтэй</b>	<b>100.0</b>	<b>65.6</b>	<b>12.0</b>	<b>10.9</b>	<b>9.1</b>	<b>2.4</b>
5-9	100.0	92.1	5.3	2.1	0.6	-
10-14	100.0	72.9	7.4	14.2	5.3	0.2
15-17	100.0	44.1	19.7	13.3	17.3	5.7
<b>Эмэгтэй</b>	<b>100.0</b>	<b>70.5</b>	<b>10.2</b>	<b>10.6</b>	<b>6.3</b>	<b>2.3</b>
5-9	100.0	93.7	5.4	1.0	-	-
10-14	100.0	73.7	9.0	12.3	3.0	2.0
15-17	100.0	50.2	15.0	16.3	14.2	4.3

**6.5.4 Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдүүдийн сарын орлого**

Хүснэгт 32-д цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдүүдийн сарын орлогыг тооцов. Гэхдээ цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдийн тоо цөөн байгаа тул аливаа дүгнэлт хийхдээ болгоомжтой хандах нь зүйтэй. Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдүүдийн 56.1 хувь нь сургуульд сурч, 43.9 хувь нь сургуульд сурдаггүй хүүхдүүд байна. Сургуульд сурахын зэрэгцээ цалин хөлстэй ажил хийдэг

хүүхдүүдийн 25.2 хувь нь 10000 хүртэлх төгрөгийн, ихэнх нь буюу 46.1 хувь нь 11000-20000 төгрөгийн, харин үлдсэн 28.7 хувь нь 21000 төгрөгөөс дээш орлого олж байгаа нь хамгийн өндөр орлого олдог хүүхдүүдийн тавны хоёрыг эзэлж байна. Хүйсийн хувьд онцын ялгаагүй байна, гагцхүү сарын орлого нь өндөр буюу 30000-аас дээш төгрөгний орлоготой хүүхдүүд нь дандаа хөвгүүд байна.

**Хүснэгт 32. Тухайн үед цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдүүдийн сарын орлого, төгрөгөөр**

Сүүлийн сард олсон орлого (бэлэн мөнгө болон биет хэлбэрээр)	Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхэд					
	Тоо			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Сургуульд сурдаг	Сургуульд сурдаггүй	Бүгд	Сургуульд сурдаг	Сургуульд сурдаггүй
<b>Нийт хүүхэд:</b>	<b>915</b>	<b>513</b>	<b>402</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
10000 хүртэл	181	129	52	19.8	25.2	12.9
11000 - 20000	378	236	142	41.3	46.1	35.3
21000 - 30000	297	104	193	32.4	20.3	47.9
31000 - 40000	19	3	16	2.0	0.5	4.0
41000-ээс дээш	40	40	0	4.4	7.9	0.0
<b>Эрэгтэй:</b>	<b>665</b>	<b>308</b>	<b>358</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
10000 хүртэл	158	126	32	23.7	40.8	9.0
11000 - 20000	209	92	117	31.4	29.9	32.8
21000 - 30000	240	47	193	36.0	15.4	53.8
31000 - 40000	19	3	16	2.8	0.9	4.4
41000-ээс дээш	40	40	0	6.1	13.1	0.0
<b>Эмэгтэй:</b>	<b>250</b>	<b>205</b>	<b>44</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
10000 хүртэл	24	4	20	9.5	1.9	44.6
11000 - 20000	169	144	25	67.7	70.4	55.4
21000-30000	57	57	0	22.8	27.7	0.0

**6.6 Эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд**

Ихэнх хүүхдүүд ямар нэгэн хэмжээгээр гэрийнхээ ажилд тусалдаг байна. Энэ хэсэгт хүүхдүүдийн эдийн засгийн бус ажиллагааг насны бүлэг, хүйсээр тооцсон дүнг харуулав. Хүснэгт 33-аас харахад хүүхдүүд дараах эдийн засгийн бус үйл ажиллагаа буюу гэрийн ажлуудыг хийж байна.

- Хоол цай хийх, аяга таваг угаах
- Гэр орон цэвэрлэх
- Хувцас угаах, индүүдэх
- Гэр байшин, эд хогшил сэргээн засах
- Гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдаж авах, дэлгүүр явах
- Хувцас, бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх
- Ус авах
- Түлээ, түлш бэлтгэх

- Өндөр настан, өвчтэй хүн асрах
- Хүүхэд асрах
- Гэрийн тэжээвэр амьтан арчлах, ашиг олох зорилгоор бус цэцэг ногоо тарих, арчлах
- Олон нийтийн болон сайн дурын ажилд үнэ хөлсгүйгээр оролцох

Хүүхэд хэд хэдэн төрлийн гэрийн ажил хийсэн байж болохыг тэмдэглэх хэрэгтэй. Гэрийн ажил хийхэд оролцсон хүүхдүүдийн тоог хувиар гаргаж *Хүснэгт 33а*-д харуулав. Хамгийн олон хүүхэд хоол цай хийж, аяга таваг угааж, түүний дараагаар гэр орон цэвэрлэх, ус авах, түлээ түлш бэлтгэх, хувцас угаах, индүүдэх, гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдан авах, дэлгүүр хоршоо явах ажлууд орж байна. Тухайлбал, хүүхдүүдийн 71.9 хувь нь хоол унд хийх, аяга таваг угаахад, 70.7 хувь нь гэр орон цэвэрлэхэд, 23.9 хувь нь гэр орныхоо хэрэгцээт зүйлсийг худалдан авахаар дэлгүүр хоршоогоор явсан байна. Гэрийн ажил буюу эдийн засгийн бус үйл ажиллагаан дахь оролцоог насны бүлэг, хүйсээр харахад нэлээд ялгаа ажиглагдав. Хоол унд хийх, аяга таваг угаах, гэр орон цэвэрлэх ажлыг хийсэн охидын эзлэх хувь (үнэмлэхүй тоогоор ч гэсэн) хөвгүүдийнхээс өндөр байна. Энэ хоёр ажлыг хийсэн охидын тоо насны бүлэг дээшлэх тусам нэмэгдэж байгаа нь хоол унд хийх, гэр орон цэвэрлэх ажлыг уламжлал ёсоор эмэгтэйчүүд хийж ирсэнтэй зарим талаар холбоотой байж болох юм.

Хүснэгт 33. Гэрийн (эдийн засгийн бус үйл ажиллагаа) ажил хийхэд оролцсон хүүхдүүдийн тоо, насны бүлэг, хүйс, хийсэн ажлын төрлөөр

(Тоогоор)

Гэрийн ажил буюу эдийн засгийн бус үйл ажиллагаа **													
Насны бүлэг/ хүйс	Нийт оролцсон хүүхэд	Хоол цай хийх, аяга таваг угаах	Гэр орон цэвэрлэх	Хувцас угаах, индүүдэх	Сууц, эд хогшил сэргээн засах	Гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдаж авах, дэлгүүр явах	Хувцас, бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах	Ус авах	Түлээ, түлш бэлтгэх	Өндөр настан, өвчтөн асрах	Хүүхэд асрах	Ашиг олох зорилгоор бус гэрийн тэжээвэр амьтан тэжээх, цэцэг ногоо тарих, арчлах	Олон нийтийн болон сайн дурын ажилд үнэ хөлсгүйгээр оролцох
<b>Бүгд</b>	464978	334544	328930	223839	20009	111099	17429	266760	208128	8395	30002	15037	13780
5-9	113191	74022	68415	19425	1454	14633	1477	48477	40298	1025	7874	2648	1450
10-14	197355	141383	144043	94505	8057	47457	6547	122650	91563	4054	14041	6007	6859
15-17	154432	119139	116472	109910	10499	49009	9406	95633	76267	3316	8087	6382	5471
<b>Хөвгүүд</b>	240447	149775	144247	96034	15568	53192	4418	155757	127417	4124	12802	8384	6744
5-9	56622	32398	29838	6916	1157	7587	439	27989	23181	555	3625	1456	726
10-14	103812	64303	64231	40203	5808	23504	1762	72480	56641	1963	5839	3417	3186
15-17	80013	53074	50178	48915	8603	22101	2216	55289	47595	1606	3338	3511	2832
<b>Охид</b>	224531	184769	184684	127805	4441	57907	13011	111003	80711	4271	17200	6653	7036
5-9	56569	41624	38578	12509	296	7046	1038	20488	17117	469	4249	1192	724
10-14	93543	77080	79812	54302	2249	23953	4785	50171	34922	2092	8202	2590	3674
15-17	74419	66064	66295	60995	1896	26908	7189	40345	28671	1710	4749	2871	2638

Хүснэгт 33а. Гэрийн (эдийн засгийн бус үйл ажиллагаа) ажил хийхэд оролцсон хүүхэд, насны бүлэг, хүйс, хийсэн ажлын төрлөөр

(Хувиар)

Гэрийн ажил буюу эдийн засгийн бус үйл ажиллагаа \*\*

Насны бүлэг/ хүйс	Нийт оролцсон хүүхэд	Хоол цай хийх, аяга таваг угаах	Гэр орон цэвэрлэх	Хувцас угаах, индүүдэх	Сууц, эд хогшил сэргээн засах	Гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдаж авах, дэлгүүр явах	Хувцас, бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах	Ус авах	Түлээ, түлш бэлтгэх	Өндөр настан, өвчтөн асрах	Хүүхэд асрах	Ашиг олох зорилгоор бус гэрийн тэжээвэр амьтан тэжээх, цэцэг ногоо тарих, арчлах	Олон нийтийн болон сайн дурын ажилд үнэ хөлсгүйгээр оролцох
<b>Бүгд</b>	100.0	71.9	70.7	48.1	4.3	23.9	3.7	57.4	44.8	1.8	6.5	3.2	3.0
5-9	100.0	65.4	60.4	17.2	1.3	12.9	1.3	42.8	35.6	0.9	7.0	2.3	1.3
10-14	100.0	71.6	73.0	47.9	4.1	24.0	3.3	62.1	46.4	2.1	7.1	3.0	3.5
15-17	100.0	77.1	75.4	71.2	6.8	31.7	6.1	61.9	49.4	2.1	5.2	4.1	3.5
<b>Хөвгүүд</b>	100.0	62.3	60.0	39.9	6.5	22.1	1.8	64.8	53.0	1.7	5.3	3.5	2.8
5-9	100.0	57.2	52.7	12.2	2.0	13.4	0.8	49.4	40.9	1.0	6.4	2.6	1.3
10-14	100.0	61.9	61.9	38.7	5.6	22.6	1.7	69.8	54.6	1.9	5.6	3.3	3.1
15-17	100.0	66.3	62.7	61.1	10.8	27.6	2.8	69.1	59.5	2.0	4.2	4.4	3.5
<b>Охид</b>	100.0	82.3	82.3	56.9	2.0	25.8	5.8	49.4	35.9	1.9	7.7	3.0	3.1
5-9	100.0	73.6	68.2	22.1	0.5	12.5	1.8	36.2	30.3	0.8	7.5	2.1	1.3
10-14	100.0	82.4	85.3	58.1	2.4	25.6	5.1	53.6	37.3	2.2	8.8	2.8	3.9
15-17	100.0	88.8	89.1	82.0	2.5	36.2	9.7	54.2	38.5	2.3	6.4	3.9	3.5



**Хүснэгт 34. Гэрийн ажил хийсэн болон ус авсан, түлээ түлш бэлтгэсэн хүүхдүүдийн тоо, насны бүлэг, хүйс, 7 хоногт зарцуулсан цагаар**

Гэрийн ажил хийсэн хүүхдүүд				Ус авч, түлээ түлш бэлтгэсэн хүүхдүүд				
Долоо хоногт зарцуулсан цаг	Гэрийн ажил хийсэн нийт хүүхэд	Зөвхөн гэрийн ажил хийсэн хүүхэд	Ажил эрхэлсэн болон гэрийн ажил хийсэн хүүхдүүд	Зарцуулсан цаг	Ус авч, түлээ түлш бэлтгэсэн нийт хүүхэд	Насны бүлгээр:		
						5-11 нас	12-14 нас	15-17 нас
Бүгд	464,978	401,732	63,246	Бүгд	294,233	105,524	86,893	101,816
<5	135,826	122,371	13,455	<5	191,076	75,673	55,361	60,042
5 – 9	135,739	118,460	17,279	5 – 9	67,095	19,892	20,259	26,943
10 – 14	76,013	64,980	11,033	10 – 14	22,210	6,539	7,169	8,502
15 – 24	68,347	57,348	10,999	15 – 24	10,553	2,560	3,246	4,747
25 – 34	30,251	24,688	5,564	25 – 34	2,429	610	831	988
35 – 42	9,287	6,922	2,365	35 – 42	320	0	4	316
43 – 48	2,868	1,968	900	43 – 48	253	50	15	187
49 – 55	2,146	1,639	506	49 – 55	90	0	0	90
56 +	4,501	3,355	1,145	56 +	209	201	8	0
				Эрэгтэй:	169,743	61,474	50,014	58,255
				<5	101,279	42,020	28,745	30,513
				5 – 9	43,363	13,247	12,606	17,510
				10 – 14	15,007	4,007	5,490	5,510
				15 – 24	7,741	1,491	2,652	3,599
				25 – 34	1,568	498	494	575
				35 – 42	275	0	4	271
				43 – 48	253	50	15	187
				49 – 55	90	0	0	90
				56 +	168	161	8	0
				Эмэгтэй:	124,490	44,051	36,879	43,561
				<5	89,798	33,653	26,616	29,529
				5 – 9	23,732	6,645	7,653	9,434
				10 – 14	7,202	2,531	1,679	2,992
				15 – 24	2,812	1,069	594	1,148
				25 – 34	861	111	337	413
				35 – 42	45	0	0	45
				56 +	40	40	0	0

Хүснэгтээс харахад ус авах, түлээ түлш бэлтгэх ажлыг хөвгүүд илүүтэй хийж байгаа нь биеийн хүч шаарддаг, магадгүй хол зам туулахад хүрдэг зэрэгтэй холбоотой байж болох юм. Гэр орныхоо хэрэгцээт зүйлсийг худалдан авах, дэлгүүр явахын хувьд охид, хөвгүүдийн аль аль нь оролцож байна.

Гэр байшин, эд хогшил сэргээн засах, хувцас, бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах зэрэг зарим ур чадвар шаардсан ажлыг ахлах насны хүүхдүүд хийж байна. Нөгөө талаар, хүүхэд харах зэрэг ур чадвар шаардахгүй ажлыг бага насны

хүүхдээр их хийлгүүлж байна.

Ус авах, түлээ түлш бэлтгэх ажлыг хийхэд олон хүүхэд оролцсоныг харгалзан тусгайд нь хүснэгт боловсруулан долоо хоногт зарцуулсан цаг, насны бүлэг, хүйсээр тооцов. НҮБ-ын ҮТС-ийн хүрээнд дээрх хоёр ажлыг эдийн засгийн үйл ажиллагаанд тооцон, ажил мэргэжлийн олон улсын ангиллын 6210-р бүлэгт (амиа аргацаасан хөдөө аж ахуй, загас ан агнуур эрхлэх) бүртгэдэг. Гэвч ҮТС-ийг тооцохдоо ус авах, түлээ түлш бэлтгэх ажлыг ҮТС-д хамруулах асуудлыг тухайн улс орон өөрийн онцлог нөхцөл байдалд тохируулан харилцан адилгүй шийддэг. *Хүснэгт 34*-д холбогдох мэдээллийг харуулав.

Ус авах, түлээ түлш бэлтгэх ажлыг эдийн засгийн үйл ажиллагаа гэж үзвэл ажил эрхэлж буй хүүхэд, түүний дотор хүүхдийн хөдөлмөр эрс нэмэгдэж гарна. Бүлэг 3<sup>5</sup>-д дурьдсан хүүхдийн хөдөлмөрийн талаар ОУХБ-аас гаргасан зөвлөмжийн дагуу 5-11 насны бүх (105524) хүүхэд, долоо хоногт 14-өөс илүү цагийг дээрх хоёр ажилд зарцуулж байгаа 12-14 насны 4104 хүүхэд, долоо хоногт 43-аас дээш цагийг зарцуулсан 15-17 насны 277 хүүхэд, нийлээд бүгд 109906 хүүхэд хүүхдийн хөдөлмөр эрхэлж байгаа ангилалд багтаж болохоор байна (*Хүснэгт 34*-ийг харна уу). Тухайн үеийн идэвхиэр эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүүхдүүдээс ОУХБ-аас “Хүүхдийн хөдөлмөр”-ийг тооцох талаар гаргасан зөвлөмжийн дагуу хөдөлмөр эрхэлж байгаа гэсэн тодорхойлолтод хамрагдах хүүхдүүд дээр ус авах, түлээ түлш бэлтгэх ажлыг хийхэд нэлээд цаг зарцуулж буй хүүхдүүдийг нэмж тооцох эсэх асуудлыг дараачийн бүлэгт дэлгэрэнгүй өгүүлэх болно.

## БҮЛЭГ 7. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР, ТҮҮНИЙГ ЭРХЛЭХ БОЛСОН ШАЛТГААН

### 7.1 Удиртгал

Монгол Улс нь ОУХБ-ын 138, 182-р Конвенциудад нэгдэн орсон тул ОУХБ-аас баталсан хүүхдийн хөдөлмөрийн ажлын нөхцөл, шинж төлөвийг харгалзан ажил эрхлэх насны доод хязгарыг тогтоох талаарх зөвлөмжийг өөрийн орны нөхцөл байдалтай нийцрүүлэн тус улсад мөрдөгдөж буй хөдөлмөрийн хуулиудад тусгаж өгсөн болно. Гэвч дан ганц хууль гаргаснаар хүүхдийн хөдөлмөрийн олон талт асуудлыг шийдвэрлэхэд төвөгтэй тул энэ асуудлыг үүсгэж буй үндсэн шалтгаан болох ядуурал, тэгш бус байдлыг устгахад чиглэсэн нийгэм, эдийн засгийн арга хэмжээг төлөвлөн, хуулийн хамт хэрэгжүүлэх нь зохистой. Иймд хүүхдийг хөдөлмөр эрхлэхэд хүргэж буй шалтгаан, хөдөлмөр эрхэлснээр хүүхдэд учирч буй хор уршиг зэргийг судлах шаардлагатай юм.

МХХС-ны тайлангийн Бүлэг 6-д танилцуулсан үндсэн үр дүнг ашиглан хүүхдийн ажил эрхлэлт болон хүүхдийн хөдөлмөрийн цар хүрээг тооцсоноос гадна хүүхдүүд эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгаан, түүний үр дагаврын талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийсэн дүнг энэ бүлэгт танилцуулав. Түүнчлэн эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн, эрхлээгүй шалтгаан болон эрхлэх болсноор эрүүл мэнд нь хохирч буй эсэх, хичнээн цагийг өөртөө буюу амрахад зориулж буй талаар хүүхдүүдээс асуун тодруулсан.

### 7.2 Хүүхдийн хөдөлмөрийн тооцоо

Хүүхдийн хөдөлмөр нь ажил эрхэлж буй буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд гэсэн ойлголтоос арай нарийвчилсан ойлголт юм. ОУХБ-ын 138, 182-р конвенцийн дагуу хүүхдийн хөдөлмөрийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

5-11 нас = Энэ насны эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй бүх хүүхэд;

Нэмэх нь:

12-14 нас = Энэ насны эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд [үүнээс хөнгөн ажлыг өдөрт дунджаар 2 цаг хийж буй бүх хүүхдийг хасч тооцно]

Нэмэх нь: 15-17 нас = Аюултай ажил эрхэлж буй болон тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй бүх хүүхэд [Долоо хоногт 43

болон түүнээс дээш цагийг ажилдаа зарцуулж буй хүүхдээр тооцов]

Тухайн үеийн эдийн засгийн идэвхийн байдлын тоо мэдээг ашиглан хүүхдийн хөдөлмөрийг нас, хүйс, хот хөдөөгөөр тооцсон дүнг энэ хэсэгт танилцуулав.

**Хүснэгт 35. Эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан цагт үндэслэн тооцсон хүүхдийн хөдөлмөр, насны бүлэг, хүйсээр**

Долоо хоногт зарцуулсан цаг/хүйс	Бүгд	Насны бүлэг		
		5 - 11	12 - 14	15 - 17
<b>Ажил эрхэлсэн нийт хүүхдийн тоо</b>	<b>69678</b>	<b>26549</b>	<b>15780</b>	<b>27349</b>
5 хүртэлх цаг	4687	3604	612	471
5 - 9 цаг	10208	6632	1305	2272
10 - 14 цаг	16468	7615	4752	4101
15 - 24 цаг	12700	5168	3215	4316
25 - 34 цаг	7078	1400	2375	3303
35 - 43 цаг	8548	1356	1803	5388
43 - 48 цаг	731	179	179	373
49 - 55 цаг	1570	44	131	1395
56 ба түүнээс дээш цаг	7689	550	1409	5730
<b>Үүнээс хөдөлмөр эрхэлсэн</b>	<b>43158</b>	<b>26549</b>	<b>9112</b>	<b>7498</b>
<b>Эрэгтэй</b>	<b>42173</b>	<b>15110</b>	<b>9788</b>	<b>17275</b>
5 хүртэлх цаг	2331	1982	239	111
5 - 9 цаг	5502	3716	818	969
10 - 14 цаг	8902	3965	2393	2544
15 - 24 цаг	7052	2906	1874	2272
25 - 34 цаг	4906	861	1781	2264
35 - 43 цаг	5887	919	1149	3819
43 - 48 цаг	499	179	118	201
49 - 55 цаг	967	44	126	797
56 ба түүнээс дээш цаг	6128	538	1291	4298
<b>Үүнээс хөдөлмөр эрхэлсэн</b>	<b>26746</b>	<b>15110</b>	<b>6339</b>	<b>5297</b>
<b>Эмэгтэй</b>	<b>27505</b>	<b>11439</b>	<b>5992</b>	<b>10074</b>
5 хүртэлх цаг	2356	1623	373	361
5 - 9 цаг	4705	2916	487	1303
10 - 14 цаг	7566	3650	2359	1557
15 - 24 цаг	5648	2262	1341	2045
25 - 34 цаг	2172	540	594	1038
35 - 43 цаг	2661	437	654	1570
43 - 48 цаг	232	0	61	172
49 - 55 цаг	603	0	5	598
56 ба түүнээс дээш цаг	1561	12	118	1432
<b>Үүнээс хөдөлмөр эрхэлсэн</b>	<b>16413</b>	<b>11439</b>	<b>2773</b>	<b>2201</b>

Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүдээс ОУХБ-ын хүүхдийн хөдөлмөрийн талаар гаргасан зөвлөмжийн дагуу хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийг ажилласан цагаар нь тооцож *Хүснэгт 35*-ийн харлуулсан хэсэгт үзүүлж байна. Эндээс харахад сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 69678 хүүхдийн 43159 (62.0 хувь) нь хөдөлмөр эрхэлж байна гэсэн дүн гарч байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан 5-17 насны нийт хүүхдийн 6.9 хувь нь (621612 хүүхдийн 43158 нь) хөдөлмөр эрхэлж байна гэсэн үг юм. Хөдөлмөр эрхэлж буй нийт 43158 хүүхдийн 62.0 хувь нь эрэгтэй, 38.0 хувь нь эмэгтэй хүүхдүүд байгаа бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй нийт хүүхдэд эзлэх хувиар нь тооцвол эрэгтэй хүүхдүүдийн 62.1 хувийг, эмэгтэй хүүхдүүдийн 58.0 хувийг эзэлж байгаагаас харахад хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн эзлэх хувь хүйсийн хувьд ойролцоо байна.

МХХС-нд хараа хяналтгүй, тэнүүчлэн амьдарч буй болон нийтийн байранд суугаа хүүхдүүдийг хамруулаагүй тул хүүхдийн хөдөлмөрийн талаарх дээрх тоо мэдээ нь Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийг бүрэн хамраагүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Үүнээс гадна өрхийн судалгаа нь голдуу далд хэлбэрээр явагддаг тэвчишгүй хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг хамрах боломжгүй байдаг.

### 7.3 Сургуулиас гадуурх үйл ажиллагаа

Сүүлийн 7 хоногт нийт 621612 хүүхдийн 69678 хүүхэд буюу 11.2 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж, 401732 хүүхэд буюу 64.6 хувь нь гэрийн ажил хийж, 93324 хүүхэд буюу 15.0 хувь нь зөвхөн суралцаж, 56878 хүүхэд буюу 9.2 хувь нь юу ч хийгээгүй байна. *Хүснэгт 36*-д нийт хүүхдүүдийн сүүлийн хоногт хийсэн үйл ажиллагааг насны бүлэг, болон хүйсээр ялган харуулав.

Нийт хүүхдүүдээс суралцсан болон ямар нэгэн үйл ажиллагаа хийгээгүй хүүхдийн хувьд хүйсийн ялгаа бараг байхгүй байна. Харин эдийн засгийн үйл ажиллагааг хөвгүүдийн 13.0 хувь нь эрхэлж байхад охидын 9.3 хувь нь, гэрийн ажлыг хөвгүүдийн 62.2 хувь нь хийж байхад охидын 67.3 хувь нь хийж байна. Эндээс үзэхэд орлого олох эдийн засгийн үйл ажиллагааг хөвгүүд охидыг бодвол илүүтэйгээр эрхэлж байна. Насны бүлгээр харахад нас ахих тусам зөвхөн суралцах болон ямар нэгэн үйл ажиллагаа хийхгүй байх нь багасч эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаанд оролцох нь ихэсч байна.

**Хүснэгт 36. Сүүлийн 7 хоногт хийсэн үйл ажиллагаа, насны бүлэг, хүйсээр**

	Бүгд	Үүнээс:			
		Эдийн засгийн үйл ажиллагаа	Гэрийн ажил	Зөвхөн сурсан	Юу ч хийгээгүй
Нийт хүүхэд	621 612	69 678	401 732	93 324	56 878
5-9	209 127	17 790	98 374	40 754	52 210
10-14	237 149	24 540	174 569	36 013	2 027
15-17	175 336	27 349	128 789	16 557	2 642
Хөвгүүд	325 631	42 173	202 524	49 549	31 385
5-9	108 089	10 099	47 921	21 351	28 717
10-14	126 485	14 800	90 440	20 252	994
15-17	91 058	17 275	64 163	7 946	1 674
Охид	295 981	27 505	199 208	43 774	25 494
5-9	101 039	7 691	50 453	19 403	23 492
10-14	110 664	9 740	84 130	15 761	1 033
15-17	84 278	10 074	64 625	8 611	968
		Дүнд эзлэх хувиар			
Нийт хүүхэд	100,0	11,2	64,6	15,0	9,2
5-9	100,0	8,5	47,0	19,5	25,0
10-14	100,0	10,3	73,6	15,2	0,9
15-17	100,0	15,6	73,5	9,4	1,5
Хөвгүүд	100,0	13,0	62,2	15,2	9,6
5-9	100,0	9,3	44,3	19,8	26,6
10-14	100,0	11,7	71,5	16,0	0,8
15-17	100,0	19,0	70,5	8,7	1,8
Охид	100,0	9,3	67,3	14,8	8,6
5-9	100,0	7,6	49,9	19,2	23,3
10-14	100,0	8,8	76,0	14,2	0,9
15-17	100,0	12,0	76,7	10,2	1,1

Хүснэгт 36-д нийт хүүхдүүдийн сүүлийн 7 хоногт хийсэн үйл ажиллагааг харуулсан бол Хүснэгт 37-д нийт хүүхдүүдээс сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийг ялган сүүлийн 7 хоногт хийсэн үйл ажиллагаагаар ангилан харуулав.

Нийт 621612 хүүхдүүдээс сургуульд суралцаагүй 118941 хүүхэд байгаагаас 5-9 насны 82069 хүүхэд, 10-14 насны 11221 хүүхэд, 15-17 насны 25650 хүүхэд байна. Сургуульд суралцах ёстой 10-17 насны хүүхдүүд сургуульд хамрагдаагүй нийт хүүхдийн 31.0 хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Сургуульд суралцаагүй байж эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа нийт хүүхдийн гуравны нэгийг 5-9 насны хүүхдүүд эзэлж байгаа нь 10-14 насныхнаас бараг 2 дахин их байна. Хүйсээр ялган харвал эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хөвгүүдийн 59.1 хувь нь 15-17 насныхан байхад охидын 45.6 хувь нь энэ насныхан эзэлж байна. Харин гэрийн ажлыг 5-9 насныхан зонхилж хийж байгаа бөгөөд гэрийн ажил хийж байгаа хөвгүүдийн 54.6 хувь, охидын 69.1 хувийг энэ насныхан эзэлж байна.

**Хүснэгт 37. Сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн сүүлийн 7 хоногт хийсэн үйл ажиллагаа, насны бүлэг, хүйсээр**

	Бүгд	Үүнээс:		
		Эдийн засгийн үйл ажиллагаа	Гэрийн ажил	Юу ч хийгээгүй
Нийт хүүхэд	118 941	26 128	35 934	56 878
5-9	82 069	7 834	22 026	52 210
10-14	11 221	4 128	5 066	2 027
15-17	25 650	14 166	8 843	2 642
Хөвгүүд	67 263	16 636	19 242	31 385
5-9	43 399	4 185	10 497	28 717
10-14	7 183	2 618	3 571	994
15-17	16 681	9 833	5 174	1 674
Охид	51 678	9 492	16 692	25 494
5-9	38 671	3 650	11 529	23 492
10-14	4 038	1 510	1 495	1 033
15-17	8 969	4 333	3 668	968

	Дүнд эзлэх хувиар			
	Бүгд	Эдийн засгийн үйл ажиллагаа	Гэрийн ажил	Юу ч хийгээгүй
Нийт хүүхэд	100,0	100,0	100,0	100,0
5-9	69,0	30,0	61,3	91,8
10-14	9,4	15,8	14,1	3,6
15-17	21,6	54,2	24,6	4,6
Хөвгүүд	100,0	100,0	100,0	100,0
5-9	64,5	25,2	54,6	91,5
10-14	10,7	15,7	18,6	3,2
15-17	24,8	59,1	26,9	5,3
Охид	100,0	100,0	100,0	100,0
5-9	74,8	38,4	69,1	92,1
10-14	7,8	15,9	9,0	4,1
15-17	17,4	45,6	22,0	3,8

Суралцаж байгаа болон сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагааны талаар БҮЛЭГ 5-д дэлгэрэнгүй дурьдсан болно. Хүснэгт 37-д эцэг эх, өрхийн насанд хүрсэн гишүүний заавраар гэрийн ажилд тусалж эхэлсэн талаарх тоо мэдээг танилцуулж байна. Дийлэнх хүүхэд (61.3 хувь нь) маш бага наснаас буюу 5-9 насанд гэрийн ажилд тусалж эхэлдэг байна.

#### **7.4 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж эхэлсэн нас**

Улсын хэмжээнд 5-17 насны нийт хүүхдийн бараг гуравны нэг нь буюу 201098 хүүхэд өрхийн аж ахуйдаа тусалжээ. Үүнээс 109204 буюу 54.3 хувь нь хөвгүүд, 91894 нь буюу 45.7 хувь нь охид байна. Хүснэгт 38-д хүүхдүүдийн өрхийн аж ахуйдаа тусалж эхэлсэн насыг насны бүлэг, сургуульд хамрагдалт, хот хөдөөгөөр харуулав. Өрхийн аж ахуйдаа тусалж буй хүүхдүүдийн 83.4 хувь нь

сургуульд сурч байна. Энэ үзүүлэлтийг хот хөдөөгөөр авч үзэхэд хотын хүүхдүүдийн 95.1 хувь нь хөдөөгийн хүүхдүүдийн 79.4 хувь өрхийн аж ахуйд туслахын зэрэгцээ суралцаж байна.

**Хүснэгт 38. Өрхийн аж ахуйд тусалж буй хүүхдүүд, тусалж эхэлсэн насны бүлэг, сургуульд хамрагдалт, хот хөдөө, хүйсээр**

	Өрхийн аж ахуйдаа тусалсан хүүхдийн тоо	Бүгд	Сургуульд сурч буй эсэх	
			Тийм	Үгүй
Нийт хүүхэд	201098	100	83,4	16,6
5-9	51923	100	69,8	30,2
10-14	82309	100	95,1	4,9
15-17	66866	100	79,5	20,5
Хот	51334	100	95,1	4,9
5-9	8198	100	88,9	11,1
10-14	21437	100	99,1	0,9
15-17	21699	100	93,6	6,4
Хөдөө	149764	100	79,4	20,6
5-9	43725	100	66,2	33,8
10-14	60872	100	93,7	6,3
15-17	45167	100	72,8	27,2

Өрхийн аж ахуйдаа тусалж буй хүүхдүүдийн тусалж эхэлсэн насыг судалж үзвэл улсын хэмжээнд 25.8 хувь нь 5-9 насандаа, 40.9 хувь нь 10-14 насандаа, 33.3 хувь нь 15-17 насандаа өрхийн аж ахуйдаа тусалж эхэлсэн байна. Хотын хүүхдүүд ихэвчлэн (51334 хүүхдээс 21699 нь) 15-17 насандаа өрхийн аж ахуйд оролцож эхэлж байхад хөдөөгийн хүүхдүүд ихэвчлэн (149764 хүүхдийн 60842 нь) 10-14 насандаа оролцож эхэлжээ. Эндээс үзэхэд өрхийн аж ахуйд 5-17 насны хүүхдүүдийн оролцох оролцоо хөдөөд хотынхыг бодвол 3 дахин их байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 39-д өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүдийг насны бүлэг болон байршлаар ямар ялгаатай байгаа эсэхийг харах зорилгоор (а) сургуульд сурч буй эсэх, (б) өрхөөс гадуур амьдарч буй эсэх гэж 2 бүлэглэн хувааж үзүүлэв. Хүснэгт 39а-д хүүхдүүдийн дүнд эзлэх хувийг суралцаж буй эсэх, өрхөөс гадуур амьдарч буй эсэхээр тооцсон болно. Улсын хэмжээнд 5-17 насны нийт 3219 хүүхэд өрхөөс гадуур ажиллаж байгаа ба үүний 1981 нь хотын, 1238 нь хөдөөний хүүхдүүд байна. Нийт хүүхдийн 1483 нь буюу 46.1 хувь нь 10-14 насандаа өрхөөс гадуур ажиллаж эхэлсэн байна. Хот хөдөөгөөр ялган авч үзвэл хотын хүүхдүүдийн ихэнхи нь (1981 хүүхдийн 1003 нь) 15-17 насандаа, хөдөөний хүүхдүүдийн ихэнхи нь (1238 хүүхдийн 603 нь) 10-14 насандаа өрхөөс гадуур ажиллаж эхэлсэн байна.



**Хүснэгт 39. Өрхөөс гадуур ажилаж байгаа хүүхдүүд, ажил хийж эхэлсэн насны бүлэг, хот хөдөөгөөр**

	Өрхөөс гадуур ажиллаж буй хүүхдийн тоо	Сургуульд сурч буй эсэх		Өрхөөс гадуур байрлаж буй эсэх	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй
Нийт хүүхэд	3219	2389	830	867	2352
5 - 6	292	281	11	11	281
7 - 9	303	278	25	187	116
10 - 14	1483	1136	347	552	931
15 - 17	1140	693	447	116	1024
Хот	1981	1392	589	339	1642
5 - 6	65	65	0	0	65
7 - 9	33	33	0	15	18
10 - 14	881	710	170	272	609
15 - 17	1003	584	419	52	951
Хөдөө	1238	997	241	528	710
5 - 6	228	216	11	11	216
7 - 9	270	246	25	172	98
10 - 14	603	426	177	280	323
15 - 17	137	109	28	64	73

10 хүрэхгүй насандаа өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн гэж хариулсан хүүхдүүд нийт хүүхдүүдийн 18.5 хувийг (3219 хүүхдийн 595 нь) эзэлж байна.

**Хүснэгт 39а. Өрхөөс гадуур ажилаж байгаа хүүхдүүд, ажил хийж эхэлсэн насны бүлэг, хот хөдөөгөөр, хувиар**

	Өрхөөс гадуур ажиллаж буй хүүхдүүд	Сургуульд сурч буй эсэх		Өрхөөс гадуур байрлаж буй эсэх	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй
Нийт хүүхэд	100.0	74,2	25,8	26,9	73,1
5 - 6	100.0	96,1	3,9	3,9	96,1
7 - 9	100.0	91,9	8,1	61,8	38,2
10 - 14	100.0	76,6	23,4	37,2	62,8
15 - 17	100.0	60,8	39,2	10,2	89,8
Хот	100.0	70,3	29,7	17,1	82,9
5 - 6	100.0	100,0	0,0	0,0	100,0
7 - 9	100.0	100,0	0,0	45,5	54,5
10 - 14	100.0	80,7	19,3	30,9	69,1
15 - 17	100.0	58,2	41,8	5,2	94,8
Хөдөө	100.0	80,5	19,5	42,7	57,3
5 - 6	100.0	95,0	5,0	5,0	95,0
7 - 9	100.0	90,9	9,1	63,8	36,2
10 - 14	100.0	70,7	29,3	46,5	53,5
15 - 17	100.0	79,3	20,7	46,9	53,1

Сургуульд суралцаж буй эсэх, өрхөөс гадуур амьдарч буй эсэхээр нь


хүүхдүүдийг тооцоход хотын хүүхдүүд хөдөөний хүүхдүүдээс 10.2 хувиар бага хүүхдүүд өрхөөс гадуур ажиллахын зэрэгцээ сургуульд суралцаж байна. Нийт өрхөөс гадуур ажиллаж байгаа хүүхдүүдийн 73.1 хувь нь гэртээ амьдарч байгаа ба насны бүлгийн хувьд хот хөдөөд ялгаагүй ихэнхидээ 7-9 насандаа /45.5-63.8 хувь/ өрхөөс тусдаа газарт амьдарч, ажиллаж эхэлжээ. Түүнчлэн хотын хүүхдүүдийн 17.1 хувь нь өрхөөс тусдаа амьдарч байхад хөдөөд энэ үзүүлэлт 2.5 дахин их байгаа юм. Өрхөөс гадуур 15-17 насандаа ажиллаж эхэлсэн нийт хүүхдийн 39.2 хувь буюу бусад насны бүлгийг бодвол харьцангуй өндөр хувьтайгаар сургуульд сурахгүй байгаа нь магадгүй энэ хүүхдүүд дунд сургуулиа төгсөөд байнгын ажил эрхэлж эхэлсэнтэй холбоотой байж болох юм. 15-17 насандаа өрхөөс гадуур ажиллаж эхэлсэн хотын хүүхдүүдийн 58.2 хувь, хөдөөний хүүхдүүдийн 79.3 хувь нь сурч байгаа нь хотын хүүхдүүд дунд сургуулиа төгсөөд байнгын ажилд орж буйтай холбоотой байж болох юм.

## **7.5 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгаан**

### **7.5.1 Өрхийн аж ахуйд туслах болсон шалтгаан**

Судалгааны дүнгээс харахад нийт хүүхдүүдийн 32.2 хувь нь өрхийн аж ахуйдаа тусалсан байна. *Хүснэгт 40*-д хүүхдүүд өрхийн аж ахуйдаа туслах болсон шалтгааныг насны бүлэг, хот хөдөөгөөр харуулав. *Хүснэгт 40а*-аас харахад дийлэнх хүүхэд эцэг, эхдээ туслах зорилгоор өрхийн аж ахуйдаа тусалдаг байна. Өрхийн аж ахуйд тусалсан нийт хүүхдийн 85.4 хувь (201060 хүүхдийн 171707) нь ажлын дадлага туршлагатай болох зорилготой гэж хариулт өгсөн ба ингэж хариулсан хот, хөдөөгийн болон хөвгүүд, охидын тоо ойролцоо байна (Зураг 10). Үүний дараагаар ажлын дадлага, туршлагатай болох (10.0 хувь), өрхийн аж ахуйд ажиллах хүч дутагдсан (4.2 хувь) зэрэг шалтгаанууд орж байна. Эцэг эхийн шахалтаар гэрийн ажил хийхэд оролцдог гэж тун цөөхөн хүүхэд (0.1 хувь) хариулсан бөгөөд хот, хөдөөгийн хүйсийн ялгаа нэг их байхгүй байна. *Хүснэгт 41*-д сургуульд сурч буй болон хамрагдаагүй хүүхдүүд ерөнхийдөө төстэй хариулт өгчээ. Хүүхдүүдийн дүнд эзлэх хувь зарим нэг шалтгаанаар бага зэрэг хэлбэлзэж байна. Үүнд дийлэнх хүүхэд эцэг эхдээ туслахын тулд гэж хариулсан ба энэ хариултыг эзлэх хувиар нь тооцоход сургуульд сурч буй хүүхэд 86.4 хувьтай, сургуульд хамрагдаагүй хүүхэд 81.2 хувьтай байна. Дараа нь ажлын дадлага, туршлагатай болох гэсэн шалтгааныг сургуульд сурч буй хүүхдүүдийн 10.1 хувь, сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн 9.8 хувь нь тус тус дурьджээ.

Зураг 10



Дүнд эзлэх хувийг насны бүлгээр тооцсон *Хүснэгт 40*-өөс харахад өрхийн аж ахуйд тусалж буй нийт хүүхдийн 25.8 хувийг 5–9 насныхан, 40.9 хувийг 10-14 насныхан, 33.3 хувийг 15-17 насныхан эзэлж байна. Ийнхүү өрхийн аж ахуйд тусалж буй 5-17 насны дөрвөн хүүхдийн нэг нь арваас доош насны хүүхдүүд байна.


## Хүснэгт 40. Өрхийн аж ахуйд тусалж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгаан, насны бүлэг, хот хөдөөгөөр

	Нийт хүүхэд						Сургуульд сурч буй хүүхэд						Сургуульд хамрагдаагүй хүүхэд					
	Бүгд	Ажлын дадлага туршлагатай болох	Эцэг эхдээ туслах	Өрхийн аж ахуйд ажиллах хүч дутагдсан	Эцэг эхийн шахалтаар	Бусад	Бүгд	Ажлын дадлага туршлагатай болох	Эцэг эхдээ туслах	Өрхийн аж ахуйд ажиллах хүч дутагдсан	Эцэг эхийн шахалтаар	Бусад	Бүгд	Ажлын дадлага туршлагатай болох	Эцэг эхдээ туслах	Өрхийн аж ахуйд ажиллах хүч дутагдсан	Эцэг эхийн шахалтаар	Бусад
Нийт хүүхэд	201060	20164	171707	8374	251	564	162426	16379	140344	5318	120	265	38634	3785	31363	3056	131	299
5-9	51923	5156	45580	1099	39	49	34690	3844	30181	651	6	7	38634	1312	15399	448	33	42
10-14	82269	7872	70732	3541	77	47	76889	7199	66684	2924	72	10	17233	673	4048	617	5	37
15-17	66868	7136	55395	3734	135	468	50847	5337	43479	1742	42	248	5380	1800	11916	1991	93	220
Хот	51296	4947	43985	2032	0	331	47570	4737	40982	1586	0	265	2034	210	3003	446	0	66
5-9	8198	371	7518	302	0	7	7007	371	6331	298	0	7	16021	0	1187	4	0	0
10-14	21397	2037	18637	714	0	10	20897	2027	18272	588	0	10	1192	10	365	125	0	0
15-17	21701	2539	17831	1017	0	314	19667	2340	16379	700	0	248	500	199	1451	317	0	66
Хөдөө	149764	15217	127721	6342	251	232	114856	11642	99362	3732	120	0	13987	3575	28360	2610	131	232
5-9	43725	4786	38062	797	39	42	27683	3474	23850	354	6	0	3726	1312	14212	443	33	42
10-14	60872	5835	52095	2828	77	37	55992	5172	48412	2336	72	0	16042	663	3683	492	5	37
15-17	45167	4597	37564	2717	135	154	31180	2996	27099	1043	42	0	4880	1601	10465	1674	93	154
Хөвгүүд	109202	10160	92978	5417	168	479	85895	7718	74725	3218	42	191	34908	2441	18253	2199	126	288
Охид	91858	10004	78729	2957	83	85	76532	8661	65619	2100	78	74	23307	1344	13110	857	5	11

### 7.5.2 Өрхөөс гадуур ажиллах болсон шалтгаан

Өрхөөс гадуур ажил эрхэлж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгааныг насны бүлэг, хот хөдөө, хүйсээр *Хүснэгт 41*-д, харин өрхөөс гадуур ажил хийх болсон шалтгааны бүтцийг *Зураг 11*-д харуулав. Зургаас харахад өрхийн орлогод нэмэр болох зорилгоор олонхи хүүхэд (3219 хүүхдийн 1957 нь буюу 60.8 хувь) эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байна. Ийм хариултыг сургуульд сурч буй хүүхдүүдийн 56.9 хувь (2337 хүүхдийн 1329 нь), харин сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн 71.2 хувь (882 хүүхдийн 628) нь өгчээ. Ажлын дадлага, туршлагатай болох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх болсон гэсэн хариултыг нийт хүүхдүүдийн 7.2 хувь нь (3219 хүүхдийн 233), сургуульд сурч буй хүүхдүүдийн 9.0 хувь нь (2337 хүүхдийн 211), сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн 2.5 хувь нь (882 хүүхдийн 22 нь) тус тус өгсөн. Сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн 13.1 хувь нь сургуульд сурахад гарах зардлыг олохын тулд ажилласан гэсэн үр дүн гарлаа. Өөрийгөө авч явах, эдийн засгийн хувьд бие даахын тулд зарим хүүхэд ажил эрхэлж байна.

*Зураг 11. Өрхийн аж ахуйдаа тусалж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгааны бүтэц, хувиар*



*Хүснэгт 41*-ээс харахад ажил эрхлэх шалтгаан хүйсээр ялгаатай байна. Тухайлбал, ажлын дадлага, ур чадвартай болохын тулд ажил эрхэлсэн гэж хөвгүүдийн 4.5 хувь, охидын 14.1 хувь, харин сургуульд сурахад гарах зардлыг

олох зорилгоор ажилласан гэж хөвгүүдийн 9.5 хувь, охидын 0.6 хувь нь тус тус хариулжээ. Харин өрхийн орлогод нэмэр болох зорилгоор ажилласан хүүхдүүдийн дунд хүйсийн ялгаа нэг их ажиглагдсангүй. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд хүргэсэн шалтгаан болох ажлын дадлага туршлагатай болох гэсэн шалтгааныг сургуульд сурч буй хүүхдүүдийн 9.0 хувь хариулсан байхад сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн 2.5 хувь нь буюу бараг 4 дахин бага хүүхэд хариулжээ.


## Хүснэгт 41. Өрхөөс гадуур ажиллаж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгаан, насны бүлэг, хот хөдөөгөөр

	Нийт хүүхэд							Сургуульд сурч буй хүүхэд							Сургуульд хамрагдаагүй хүүхэд					
	Бүгд	Ажлын дадлага туршлагатай болох	Өрхийн орлогод нэмэр болох	Өөрийгөө авч явах/эдийн засгийн хувьд бие даах	Сургуульд сурахад гарах зардлыг олох	Хүүхэд өөрөө хүссэн	Бусад	Бүгд	Ажлын дадлага туршлагатай болох	Өрхийн орлогод нэмэр болох	Өөрийгөө авч явах/эдийн засгийн хувьд бие даах	Сургуульд сурахад гарах зардлыг олох	Хүүхэд өөрөө хүссэн	Бусад	Бүгд	Ажлын дадлага туршлагатай болох	Өрхийн орлогод нэмэр болох	Өөрийгөө авч явах/эдийн засгийн хувьд бие даах	Сургуульд сурахад гарах зардлыг олох	Хүүхэд өөрөө хүссэн
Нийт хүүхэд	3219	233	1957	229	224	534	43	2337	211	1329	201	108	445	43	882	22	628	28	116	89
5-9	52	14	38	0	0	0	0	47	14	33	0	0	0	0	6	0	6	0	0	0
10-14	1079	40	623	5	0	412	0	957	40	516	0	0	401	0	123	0	108	5	0	10
15-17	2087	179	1296	224	224	122	43	1334	157	781	201	108	43	43	753	22	515	23	116	79
Хот	1981	14	1254	194	224	251	43	1387	4	850	194	108	188	43	593	10	405	0	116	63
5-9	33	0	33	0	0	0	0	33	0	33	0	0	0	0	0	0	0	0	0	0
10-14	391	0	246	0	0	145	0	360	0	215	0	0	145	0	31	0	31	0	0	0
15-17	1557	14	976	194	224	107	43	995	4	602	194	108	43	43	562	10	374	0	116	63
Хөдөө	1238	219	703	35	0	282	0	950	207	480	7	0	257	0	288	12	223	28	0	26
5-9	20	14	6	0	0	0	0	14	14	0	0	0	0	6	0	6	0	0	0	0
10-14	689	40	377	5	0	267	0	597	40	301	0	0	257	0	91	0	76	5	0	10
15-17	530	165	320	30	0	15	0	339	153	179	7	0	0	191	12	141	23	0	15	
Хөвгүүд	2296	102	1396	81	218	457	43	1522	81	870	53	102	372	43	775	22	526	28	116	84
Охид	923	130	562	148	6	77	0	815	130	459	148	6	72	0	107	0	102	0	0	5

## 7.6 Ажил эрхлэхгүй бол үзүүлэх нөлөө

Хэрэв хүүхдүүд орлого олж буй ажлаа хийхээ боливол өөрт нь болон өрхөд нь ямар нөлөө үзүүлэх талаар хүүхдүүдийн бодлыг сонирхоход нийт өрхөөс гадуур ажил хийж буй хүүхдүүдийн 46.3 хувь нь өрхийн амьжиргааны түвшин доошлох, 43.8 хувь нь ямар ч нөлөөгүй, 7.1 хувь нь өрх орлогын эх үүсвэргүй болох, 2.2 хувь нь бусад, 0.8 хувь нь ажлын хөдөлмөрийн дадлага туршлагагүй болох нөлөөтэй гэж хариулжээ.


Зураг 12. Ажил эрхлэхгүй бол өөрт нь болон өрхөд үзүүлэх нөлөө, хувиар



Хүйсээр авч үзвэл өрхийн амжиргааны түвшин доошилно, ямар нэгэн нөлөөгүй гэсэн хариултууд зонхилж байна. Хөвгүүдийн 48.1 хувь нь өрхийн амьжиргаа доошилно гэсэн байхад ийм хариултыг охидын 41.7 хувь нь өгчээ. Харин ямар ч нөлөөгүй гэсэн хариултын хувьд хөвгүүдийн 39.4 хувь нь, охидын 54.5 хувь нь өгчээ. Мөн нөлөөг байршил өөрөөр хэлбэл хот суурин газар болон хөдөө, орон нутгийн хүүхдүүдийг Улаанбаатар хотын хүүхдүүдтэй харьцуулж *Зурагт 13-т* үзүүлэв. Зургаас үзэхэд хотын хүүхдүүдийн ихэнхи нь буюу 49.1 хувь нь өрхийн амжиргааны түвшин доошилно, 42.1 хувь ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй гэж нь хариулсан байхад хөдөөний хүүхдүүдийн 41.6 ба 46.4 хувь нь эдгээр хариултуудыг өгсөн байна. Нийслэл Улаанбаатар хотын хүүхдүүдийн 61.0 хувь нь өрхийн амьжиргааны түвшин доошилно гэж хариулсан нь анхаарал татаж байна.



Зураг 13. Ажил эрхлэхгүй бол өөрт нь болон өрхөд үзүүлэх нөлөө, Улаанбаатар хот, хот, хөдөөгөөр, хувиар



Өрх орлогын ямар нэгэн эх үүсвэргүй болно гэж Улаанбаатар хотын хүүхдүүдийн 12.4 хувь нь хариулсан байгаа нь эдгээр хүүхдүүд ганцаараа бие даан өрхдөө орлого олж байна гэсэн үг юм.

### 7.7 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлснээс болж өвдөж, гэмтсэн хүүхдүүд

Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил эрхэлж буй хүүхдүүдийн дийлэнх (99.8 хувь) хийж буй ажлаасаа болж өвдөж, гэмтээгүй гэж хариулжээ. Гэхдээ хүүхдүүдийн 0.2 хувь нь ажлаасаа болж өвдөж гэмтсэн бөгөөд энэ талаарх мэдээллийг Хүснэгт 42-т өвчний төрөл болон өвчлөлийн зэрэглэл, хот хөдөөгөөр харуулав.


Нийт ажил эрхэлсэн хүүхдээс 165 хүүхэд ажлаасаа болж, өвдсөж, гэмтсэн байна. Эдгээр хүүхдүүдийн 93.9 хувь хөвгүүд, 6.1 хувь нь охид байна харин хот, хөдөөгөөр авч үзэхэд нийт хүүхдийн өвдөж, гэмтсэн хүүхдийн 83.0 хувь нь хотын, 17.0 хувь нь хөдөөний хүүхдүүд байна. Өвдөж, гэмтсэн хүүхдүүдийн 37.0 хувь нь эмчийн тусламж шаардлагагүй гэсэн бол 43.6 хувь нь эмчид үзүүлж, 17.0 хувь нь эмнэлэгт хэвтэж, эмчлүүлэх шаардлагатай болсон ба 2.4 хувь нь түр зуур

хөдөлмөрийн чадваргүй болсон байна. Ажлаас болж өвдөж, гэмтсэн хүүхдийн 6.1 хувь нь харшилтай болж. 93.9 хувь нь бусад төрлийн өвчингөөр өвдсөн байна.

**Хүснэгт 42. Ажлаасаа болж өвдөж, гэмтсэн хүүхдийн тоо, өвчний төрөл, өвчлөл, гэмтлийн зэрэглэл, хүйс, хот, хөдөө, насны бүлгээр**

	Ажлын байран дээр өвдөж, гэмтсэн хүүхдүүд			Хот, хөдөөгөөр				
				Хот		Хөдөө		
	Дүн	Хүйс		Дүн	Насны бүлэг		Дүн	Насны бүлэг
		Эрэгтэй	Эмэгтэй		10-14	15-17		10-14
Өвдөж, гэмтлийн төрөл – бүгд:	165	155	10	137	4	133	28	28
Харшилтай болсон	10	0	10	10	4	6	0	0
Бусад	155	155	0	127	0	127	28	28
	93.9	6.1						
Хамгийн сүүлд авсан өвчлөл, гэмтлийн зэрэглэл:								
Дүн	165	155	10	137	4	133	28	28
Эмчийн тусламж шаардлагагүй	61	61	0	61	0	61	0	0
Эмчид үзүүлсэн	72	62	10	72	4	68	0	0
Эмнэлэгт хэвтэж, эмчлүүлэх шаардлагатай болсон	28	28	0	0	0	0	28	28
Түр зуур чадваргүй болсон	4	4	0	4	0	4	0	0

**Зураг 14. Өвчлөл, гэмтэлтэй холбогдолтой зардлын төлбөрийн төрөл, хувиар**



Эдгээр хүүхдийн эмчилгээний зардлыг ажил олгогч нар нь бус харин ихэнхдээ эцэг эх нь гаргасан байна.

## **БҮЛЭГ 8. ХҮНД ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ АЖИЛ ХИЙЖ БАЙГАА ХҮҮХЭД**

### **8.1. Нийтлэг зүйл**

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн нэг нь “Аюултай ажил” юм. Аюултай ажилд хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн дарамтад өртүүлэх ажил, газар дор, усны гүнд, аюултай өндөрт болон хязгаарлагдмал орон зайнд хийгдэх ажил, аюултай машин, тоног төхөөрөмж багаж хэрэгсэл ашиглан ажиллах, хүнд ачаа зөөх, эрүүл мэндэд хортой бодис, үйл ажиллагаа, халуун, хүйтэн, чимээ шуугиан, доргилтын нөлөөнд хийх ажил, уртасгасан буюу шөний цагаар ажиллах, ажил олгогчийн орон байранд хүндэтгэх шалтгаангүйгээр хашигдан хийх ажлууд багтана. Аюултай ажилд багтах ажлын жагсаалтыг улс орон бүр нийгмийн түншлэлийн гурван талаараа зөвлөлдсөний үндсэн дээр үндэсний хэмжээнд тодорхойлох ёстой байдаг. Монгол Улсын 1999 оны Хөдөлмөрийн тухай хуулинд насанд хүрээгүй хүнийг оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон бөгөөд насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан байна. НХХЯ-аас энэхүү албан ёсны жагсаалтыг 2008 оны 9 дүгээр сард шинэчлэн баталлаа. 2006-2007 оны МХХС-ны асуулгын дагуу эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил хийж буй нийт хүүхдүүдийн дотор тэдний ажлын байрны нөхцөл, ажлын цагийн үргэлжлэл, эдийн засгийн үйл ажиллагааны салбар болон ажил мэргэжлийн ангиллыг нь үндэслэн аюултай ажил хийж буй хүүхдийг тооцон гаргаж ирэх оролдлого хийсэн бөгөөд энэ дүнг танилцуулж байна.

### **8.2. Аюултай ажил эрхэлж буй 5-17 насны хүүхдийн тоо**

ОУХБ-ын хөдөлмөрийн талаархи тодорхойлолтын дагуу хүнд хортой ажлын нөхцөл бүхий эдийн засгийн үйл ажиллагааны салбарт ажиллаж байгаа, хүнд, хортой бус ажлын нөхцөл бүхий салбарт хүнд хортой ажил хийж байгаа, хүнд, хортой бус ажлыг долоо хоногт 43 ба түүнээс дээш цагаар хийж байгаа, долоо хоногт 43-аас доош цаг ажилласан 5-11 насны хүүхэд, 15-аас илүү цаг ажилласан 12-14 насны хүүхдүүдийг хамруулан аюултай ажил эрхэлж байгаа хүүхдийн тоог тооцож гаргасан болно. Судалгааны тооцоогоор 5-17 насны эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхэлж буй нийт 71330 хүүхдийн 67.3 хувь буюу 48000 хүүхэд аюултай хэлбэрийн ажил эрхэлж байна гэсэн дүн гарч байна (Хүснэгт 43).

Энэ ажлыг хийж буй нийт хүүхдийн 61.0 хувь буюу 29.3 мянга нь эрэгтэй, 49.0 хувь буюу 18.7 мянга нь эмэгтэй хүүхэд байна.

**Хүснэгт 43. Аюултай ажил хийж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйсээр**

Насны бүлэг/хүйс	Аюултай эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож буй хүүхэд <sup>а</sup>	Уртасгасан цагаар ажиллаж буй хүүхэд <sup>б</sup>	Хүнд хортой ажлын нөхцөлд ажиллаж буй хүүхэд <sup>в</sup>	Аюултай ажил хийж буй хүүхэд <sup>д</sup>
5-11 нас				
Эрэгтэй	38	762	0	15393
Эмэгтэй	24	12	0	11541
Дүн	62	773	0	26935
12-14 нас				
Эрэгтэй	26	1536	168	7130
Эмэгтэй	18	183	95	4049
Дүн	44	1719	263	11178
15-17 нас				
Эрэгтэй	40	5297	681	6759
Эмэгтэй	29	2201	303	3128
Дүн	69	7498	983	9887
5-17 насны нийт хүүхэд				
Эрэгтэй	104	7594	849	29282
Эмэгтэй	71	2396	397	18718
Нийт дүн	175	9990	1246	48000

Тайлбар: <sup>а</sup> Хуулиар хориглосон ажлын байранд ажиллаж буй хүүхдийн тоо


<sup>б</sup> Долоо хоногт 43 ба түүнээс дээш цагаар ажиллаж буй хүүхдийн тоо

<sup>в</sup> Хүнд хортой нөхцөлтэй ажлын байранд ажиллаж буй хүүхдийн тоо

<sup>д</sup> Ажлын байрны нөхцөл, хийж буй ажлын төрөл болон сүүлийн 7 хоногт ажилласан цагийг нь үндэслэн тодорхойлж гаргаж ирсэн аюултай ажил эрхэлж буй хүүхдийн тоо


Ажил эрхлэх насны доод хязгаарын тухай 138-р конвенцээр суурь боловсрол эзэмших наснаас доош насны хүүхдийг бүтэн цагаар ажил хийлгэхгүй байхыг ОУХБ-ын гишүүн орнуудын үүрэг байхаар заасан, Монгол Улсын хуулийн насанд хүрээгүй хүүхдийг оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон заалтын дагуу сүүлийн долоо хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийсэн 5-11 насны хүүхдүүдийг аюултай ажил эрхэлж байна гэж хамруулж байгаа тул эдгээр хүүхдүүдийн тоо нийт аюултай ажил хийж буй хүүхдийн 56.1 хувийг эзэлж байна. Аюултай ажил эрхэлж буй арван хүүхэд тутмын зургаа нь 5-11 насны хүүхэд, дөрөв нь 12-17 насны хүүхдүүд байна.

Зураг 15. Аюултай ажил эрхэлж буй хүүхдийн насны бүтэц, хувиар




Аюултай ажил эрхэлж буй хүүхдийг хүйс, насны бүлгээр нь авч үзэхэд энэхүү төрлийн ажлыг хөвгүүд түлхүү хийж байгаа нь Зураг 15-аас харагдаж байна. 15-17 насны аюултай ажил эрхэлж буй гурван хүүхдийн хоёр нь хөвгүүд байна.

Зураг 16. Аюултай ажил эрхэлж буй хүүхдийн тоо, хүйс, насны бүлгээр



Сүүлийн долоо хоногт 43 ба түүнээс дээш цагаар ажилласан 5-17 насны нийт 9990 хүүхэд байгаагийн 76.0 хувь буюу 7595 нь хөвгүүд, 24.0 хувь буюу 2395 нь охид байна.

**Зураг 17. Сүүлийн 7 хоногт 43 ба түүнээс дээш цагаар ажилласан хүүхдийн хүйсийн бүтэц, насны бүлгээр**



Долоо хоногт 43 ба түүнээс дээш цагаар ажиллаж байгаа хүүхдүүдийн ихэнхийг хөвгүүд эзэлж байгаа нь хүйс, насны бүлгээр харуулсан дээрх зургаас харагдаж байна. Сүүлийн долоо хоногт 43 ба түүнээс дээш цагаар ажилласан 5-11 насны бараг бүх хүүхэд, 12-14 насны арван хүүхдийн ёс нь, 15-17 насны арван хүүхдийн долоо нь хөвгүүд байна.

Хүнд хортой ажлын нөхцөл бүхий уул уурхай, олборлох, боловсруулах аж үйлдвэр, барилгын салбаруудын хуулийн дагуу насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрнуудад ашигт малтмал олборлох, боловсруулах, байшин барилга барих, засварлах, металл цутгах, гагнах, хэвлэл, нэхмэл, хувцас, ангийн үс, арьс боловсруулахтай холбогдолтой төрөл бүрийн ажил хийж буй хоёр зуу орчим хүүхэд байна.

Аюултай ажил эрхэлж буй хүүхдийг тодорхойлон гаргаж ирэхэд голлон авч үзсэн нэг шалгуур нь тухайн хүүхдийн ажлын байрны нөхцөл байсан. Энэхүү шалгуураар 5-17 насны хүнд хортой ажлын нөхцөлд ажил хийж буй 1300 орчим

хүүхэд байгаагийн 68.0 хувь нь эрэгтэй, 32 хувь нь охидууд байна. Хүнд нөхцөлд ажиллаж байгаа хоёр хүүхдийн нэг нь 15-17 насныхан байна. Барилгын салбарт ажиллаж байгаа арван хүүхэд тутмын зургаа нь өндөрт, хоёр нь хүйтэн нөхцөлд, дөрөв нь долоо хоногт 43 ба түүнээс дээш цаг ажиллаж байна. Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулах салбарт ажиллаж буй бүх хүүхэд их дуу чимээтэй, хэт халуун, чийгтэй нөхцөлд ажиллаж байна гэсэн бол, хоёрдогч түүхий эд бэлтгэдэг бүх хүүхдүүд хэт халуун, чийгтэй, хүйтэн орчинд хөдөлмөрийн аюултай багаж хэрэгсэл хэрэглэдэг гэж хариулсан байна.

## БҮЛЭГ 9. ХҮҮХДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН УЛИРЛЫН ХЭЛБЭЛЗЭЛ

### 9.1 Нийтлэг зүйл

Тус судалгааны нэг зорилго нь ажил эрхэлж байгаа буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоог байнгын болон тухайн үеийн идэхийн аргачлалаар улирлын хэлбэлзлийг тусган үндэсний, хэмжээнд болон хот, хөдөөгийн түвшинд судлан гаргах явдал юм. Энэ зорилгын хүрээнд нийт түүврийн хэмжээг 4 улирлаар бүлэглэн тэнцүү хувааж, түүврийн сонголтыг 3 сар тутам буюу улирал бүрээр хангалттай хэмжээнд хийсэн болно. Нэг улиралд 3072 өрхийг түүвэрлэн хамруулж, нийт дөрвөн улирлын тоо мэдээг нэгтгэн тооцоолж гаргасны зэрэгцээ хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх зарим гол үзүүлэлтүүдийг улирлаар гаргасан дүнг танилцуулж байна.

Хүүхдийн хөдөлмөрийн судалгааны хугацаа цаг тооллын улирлын хугацаатай таарахгүй бөгөөд судалгааны эхний буюу 1 дүгээр улиралд 2006 оны 7-9 –р сар, 2 дугаар улиралд 2006 оны 10-12-р сар, 3 дугаар улиралд 2007 оны 1-3-р сар, харин судалгааны сүүлийн буюу 4 дүгээр улиралд 2007 оны 4-6-р сарууд хамрагдсан болно.

### 9.2 Ажил эрхэлж буй 5-17 насны хүүхдийн тоо

Судалгаагаар ажил эрхэлж байгаа буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоог улирлаар тооцон гаргасан дүнг *Хүснэгт 44*-д харуулав.

**Хүснэгт 44 . Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, улирлын тооцоогоор**

Насны бүлэг/ хүйс	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	VII-IX	X-XII	I-III	IV-VI
Бүгд	118405	40462	56117	70336
5-9	30702	7381	14282	20101
10-14	43930	12140	19200	24795
15-17	43773	20941	22635	25440
Эрэгтэй	68044	25352	37412	41343
5-9	17195	4625	9147	10361
10-14	24585	6369	12657	16107
